



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



Diversity of
Cultural Expressions

СОЁЛЫН ИЛЭРХИЙЛЛИЙН ОЛОН ТӨРЛИЙГ ХАМГААЛАХ БОЛОН ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ТУХАЙ 2005 ОНЫ КОНВЕНЦЫН ҮНДСЭН БАРИМТ БИЧГҮҮД



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



Diversity of
Cultural Expressions

СОЁЛЫН
ИЛЭРХИЙЛЛИЙН ОЛОН
ТӨРЛИЙГ ХАМГААЛАХ
БОЛОН ХӨХИҮЛЭН
ДЭМЖИХ ТУХАЙ 2005 ОНЫ
КОНВЕНЦЫН ҮНДСЭН
БАРИМТ БИЧГҮҮД



Анхны хэвлэлийг ЮНЕСКО-оос эрхлэн гаргав.

Хаяг: Франц улс, Парис хот, 7, place de Fontenoy, 75352

Эх материал: Basic Texts of the 2005 Convention on the Protection and Promotion of the Diversity of Cultural Expressions. 2017 Edition.

© UNESCO 2017

Эх хувийг Франц улсын MH DESIGN компани эрхлэн бэлтгэв.

© ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс болон Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Энэхүү хэвлэлийг ЮНЕСКО-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссоос эрхлэн гаргав.

Хэвлэлтэд дурдсан тэмдэглээ болон материалын танилцуулга нь ЮНЕСКО-ийн аливаа улс, бүс нутаг, хот эсхүл, газар нутаг, түүний удирдлагуудын эрх зүйн статус, түүний хил хязгаар, заагтай холбоотой ямарваа нэгэн үзэл бодлын илэрхийллийг агуулахгүй.

Энэ хэвлэлд илэрхийлж буй үзэл бодол, санаанууд нь гагцхүү зохиогчдынх бөгөөд тэдгээр нь заавал ЮНЕСКО-ийнх байх албагүй.

Энэхүү орчуулгын эхийг Монголын Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яам болон ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын удирдлага дор бэлтгэв.



ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар монгол хэлнээ хөрвүүлэх төслийн зохицуулагчаар ажиллав



Энэхүү номыг ЮНЕСКО-ийн санхүүжилтээр ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс монгол хэлнээ хөрвүүлэн хэвлүүлэв.



Энэхүү номыг БСШУСЯ-ны дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.

Гарчиг

ЮНЕСКО-ийн Ерөнхий захирлын үг	V
1. Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенц	7
2. Үйл ажиллагааны удирдамж	27
• Соёлын илэрхийллийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээ	29
• Соёлын илэрхийллийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ - Онцгой нөхцөл байдал	31
• Мэдээлэл хуваалцах болон ил тод байдал	34
- Хавсралт-Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээний дөрвөн жил тутмын тайлангийн хамрах хүрээ	37
• Боловсрол ба олон нийтийн ойлголт	54
• Иргэний нийгмийн үүрэг ба оролцоо	56
- Хавсралт-Конвенцын байгууллагуудын хуралд иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах багц шалгуур	59
• Олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих	59
• Соёлыг тогтвортой хөгжлийн бодлогод нэгтгэх нь	60
• Хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа	63
• Түншлэлийн хэлбэрүүд	66
• Хөгжиж буй орнуудад зориулсан хөнгөлөлттэй нөхцөл	69
• Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сангийн нөөцийг ашиглах тухай удирдамж	74
• Мэдээлэл солилцох, дүн шинжилгээ хийх болон түгээх	82
• Конвенцыг танилцуулах болон хөхиүлэн дэмжих явдлыг хангах арга хэмжээ	85
• Конвенцын бэлгэ тэмдгийг хэрэглэх заавар	87
• Дижитал орчинд конвенцыг хэрэгжүүлэх тухай удирдамж	92
3. 2005 оны конвенцод нэгдсэн талуудын бага хурлын үйл ажиллагааны журам	101
4. Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих Засгийн газар хоорондын хорооны үйл ажиллагааны журам	109
5. Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сангийн тусгай дансны санхүүгийн дүрэм	119
6. Хавсралтууд	123
а. Соёрхон батлах загвар бичиг	124
б. 2005 оны конвенцод нэгдсэн талуудын бага хурлын хуралдаанууд	125
в. Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих Засгийн газар хоорондын хорооны хуралдаанууд	125

ӨМНӨХ ҮГ

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай 2005 оны ЮНЕСКО-ийн конвенцыг баталснаас хойш олон улсын хууль эрхзүйн салбар дахь соёлтой холбоотой хоосон орон зай эзэнтэй болсон билээ. Энэхүү конвенц нь олон улсын харилцан зөвшилцөл болон соёлын бараа, үйлчилгээний хөгжил дэвшилд гүйцэтгэх үүргийг тодорхойлох чиг баримжаа болоод байна.

Соёл бол дан бараа бүтээгдэхүүн хэмээхээс илүү өргөн ойлголт юм. Кино, ном, дүрслэх урлаг болон соёлын орчин цагийн илэрхийллийн олон төрөл нь бидний оюун санаа, бусдаас ялгарах онцлог, хүсэл эрмэлзлийг тээж байдаг билээ. Эдгээр нь ажлын байр бий болгож, хөгжил дэвшил, шинэчлэлд ч хөтөлж байна. Өдгөө энэхүү соёлын болон эдийн засгийн гэсэн хос хэмжүүр тогтвортой хөгжлийн талаарх маргааны төвд байх болжээ.

Конвенц нь бүтээлч байдлыг тэтгэн баяжуулж, уран бүтээлчдийг дотоодын болон олон улсын зах зээл дээр гарах боломжоор ханган, тэдний уран бүтээл олон нийтэд өргөн хүрээнд эрх тэгш хүрч байгааг баталгаажуулах төрийн бодлого ба хөнгөлөлтийн журам батлах засгийн газрын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрдөг билээ.

Одоогоор ЮНЕСКО-ийн гишүүн 193 улсын ихэнх нь энэхүү конвенцыг соёрхон батлаад байна. Конвенцын үндсэн баримт бичгийн 2017 оны хэвлэл нь соёлын бараа, үйлчилгээний хэрэглээ, үйлдвэрлэл, хуваарилалтын арга замыг өөрчилж байгаа дижитал орчинд конвенцыг хэрэгжүүлэхэд зориулсан үйл ажиллагааны шинэ удирдамжийг багтаасан болно. Энэхүү шинэ дижитал эринд эдгээр удирдамж нь бидний үйл ажиллагааг бэхжүүлэн ЮНЕСКО-ийн норматив баримт бичгийг шинэчлэх, дижитал болон соёлын хэмээн зааглахтай холбоотой асуудлуудад хариулт өгөх юм.

Батлагдаад 10 гаруй жил өнгөрч байгаа ч 2005 оны конвенц анхдагч олон улсын хэлэлцээр хэвээр байна. Энэхүү үндсэн баримт бичиг нь эрч хүчтэй соёлын салбарыг бий болгон хөгжүүлэх орчны хүрээг тогтоон тодорхойлж байна. Өнөөдөр бид юу юунаас ч илүүтэйгээр энэхүү онцгой конвенцыг дэмжих хэрэгтэй байна. Энэ конвенц нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал чиглүүлэгч байж соёлын бүхий л нөөцөд тулгуурлан улам бүр цэцэглэн хөгжих, илүү ихийг багтаасан, илүү амар амгалан нийгмийг цогцлоох ЮНЕСКО-ийн үйл хэргийн салшгүй чухал хэсэг болж байна.

Andrey Ayzoulay

1

СОЁЛЫН ИЛЭРХИЙЛЛИЙН
ОЛОН ТӨРЛИЙГ ХАМГААЛАХ
БОЛОН ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ
ТУХАЙ КОНВЕНЦ

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенц

2005 оны 10-р сарын 20, Парис

Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хурал 2005 оны 10 дугаар сарын 3-21-ний өдрүүдэд Парис хотноо хуралдсан 33 дугаар чуулганаараа

- Соёлын олон төрөл нь хүн төрөлхтний өвөрмөц шинж байдлыг тодорхойлогч болохыг нотлон
- Соёлын олон төрөл нь хүн төрөлхтний нийтлэг өв мөн бөгөөд бүх нийтийн сайн сайхны төлөө түүнийг нандигнан хамгаалж, хадгалах ёстойг ухамсарлан,
- Соёлын олон төрөл нь сонголтын хүрээг өргөжүүлж, хүн төрөлхтний чадавх, үнэт зүйлсийг тэтгэн хөгжүүлэх олон талт баялаг ертөнцийг цогцлоож, ингэснээрээ нийгмийн бүлэг, ард түмэн, үндэстнүүдийн тогтвортой хөгжлийн гол хөдөлгөгч хүч гэдгийг ухамсарлан
- Ардчилал, хүлцэл тэвчээр, нийгмийн шударга ёс, ард түмэн болон соёл хоорондын харилцан хүндэтгэлийн хүрээнд хөгжин цэцэглэх соёлын олон төрөл нь орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад зайлшгүй шаардлагатай болохыг эргэн санан,
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн бусад хэрэгслээр зарлан тунхагласан хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд соёлын олон төрөл чухал ач холбогдолтой болохыг онцгойлон дурдаж,
- Үндэсний болон олон улсын хөгжлийн бодлого, түүнчлэн хөгжлийн төлөөх олон улсын хамтын ажиллагааны чиглэлийг боловсруулахдаа соёлыг онцгой чухал бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэх, ингэхдээ ядуурлыг арилгахад чиглэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мянганы Тунхаглал (2000)-ыг харгалзан үзэх шаардлагатайг тэмдэглэн
- Соёл нь тодорхой цаг хугацаа, орон зайд олон төрөл хэлбэрийг олж бүрэлдэх бөгөөд энэхүү олон төрөл нь хүн төрөлхтнийг бүрдүүлж буй ард түмэн, нийгмийн бүлгийн өвөрмөц хэв шинж, соёлын илэрхийллийн давтагдашгүй чанар болоод олон янз байдлаар илэрдгийг харгалзан үзэж
- Биет болон биет бус баялгийн эх сурвалж болох уламжлалт мэдлэг, ялангуяа уугуул иргэдийн мэдлэгийн тогтолцоо, тогтвортой хөгжилд оруулах тэдгээрийн хувь нэмрийг ач холбогдол болон тэдгээрийг зохих ёсоор хамгаалах, хөхиүлэн дэмжих шаардлагатайг хүлээн зөвшөөрч
- Соёлын илэрхийллийн олон төрлийг агуулгыг нь оролцуулан хамгаалахад чиглэсэн арга хэмжээг, ялангуяа соёлын илэрхийллүүд нь устаж үгүй болох, эсхүл ноцтой аюулд учрах нөхцөл байдалд авах шаардлагатайг хүлээн зөвшөөрч,
- Соёл нь нийгмийн эв нэгдэл, ялангуяа эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, үүргийг дээшлүүлэхэд ач холбогдолтой болохыг тэмдэглэн,

- Соёлын олон төрөл нь үзэл санаагаа чөлөөтэй илэрхийлэх хэлбэрээр бэхжиж, соёл хоорондын тогтмол солилцоо, харилцан үйлчлэлээр тэтгэгддэг болохыг ухамсарлан
- Чөлөөтэй сэтгэх, илэрхийлэх, мэдээлэх болон мэдээллийн олон төрлийн хэрэгсэл нь нийгэмд цэцэглэн хөгжих боломжийг соёлын илэрхийллүүдэд олгодог болохыг дахин нотлон,
- Соёлын илэрхийллийн олон төрөл, тэр дундаа уламжлалт соёлын илэрхийллүүд нь иргэд болон ард түмэнд үзэл бодол, үнэт зүйлсээ илэрхийлэх, бусадтай хуваалцах боломжийг олгодог чухал хүчин зүйл гэдгийг хүлээн зөвшөөрч,
- Хэлний олон төрөл нь соёлын олон төрлийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг гэдгийг эргэн санаж, соёлын илэрхийллийг хамгаалж, хөхиүлэн дэмжихэд боловсрол үндсэн үүрэг гүйцэтгэдэг болохыг нотлон
- Уламжлалт соёлын илэрхийллээ чөлөөтэй бүтээн бий болгох, түгээн, дэлгэрүүлэх хийгээд өөрсдийгөө хөгжүүлэх зорилгоор үүнээс хүртэх хэлбэрээр илрэлээ олж буй соёлын амьдрах чадвар нь үндэсний цөөнх болон нутгийн уугуул хүмүүсийг оролцуулан бүгдэд чухал ач холбогдолтой болохыг харгалзан,
- Соёлын илэрхийллийг тэтгэн шинэчилж, нийгмийн дэвшлийн төлөө соёлыг хөгжүүлэхэд оролцож буй хүмүүсийн үүргийг дээшлүүлдэг соёл хоорондын харилцан үйлчлэл ба бүтээн туурвих чанар нь нэн чухал үүрэгтэйг онцлон тэмдэглэж,
- Соёлын бүтээн туурвих үйл ажиллагаанд оролцож буй хүмүүсийг дэмжихэд оюуны өмчийн эрх чухал болохыг хүлээн зөвшөөрч,
- Соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь өвөрмөц хэв шинж, үнэт зүйлс, утга агуулгыг илэрхийлдгийн хувьд эдийн засгийн хийгээд соёлын аль алиных нь шинжийг агуулдаг учраас тэдгээрийг зөвхөн арилжааны үнэ цэнтэй зүйлс төдий ойлгож болохгүй гэдэгт итгэн,
- Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хурдацтай хөгжлийн үр дүнд даяаршлын үйл явц нь соёл хоорондын харилцан үйлчлэлийг нэмэгдүүлэх цоо шинэ нөхцөлийг бий болгохын зэрэгцээ соёлын олон төрлийн, тэр дундаа баян болон ядуу орнуудын хоорондын тэнцвэрт харьцаа алдагдах эрсдэлийг дагуулах сорилт болж байгааг тэмдэглэн,
- Соёлын олон төрлийг дээдлэн хүндэтгэх явдлыг хангах, түүнчлэн үзэл санаагаа үгээр болон дүрсээр чөлөөтэй илэрхийлэхийг дэмжихэд шаардлагатай гэж үзэж буй олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулахыг зөвлөмж болгох асуудлаар ЮНЕСКО-ийн хүлээсэн үүргийг ухамсарлан,
- ЮНЕСКО-оос баталсан соёлын олон төрөл хийгээд соёлын эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон олон улсын хэрэгслүүдийн заалтууд, ялангуяа 2001 оны Соёлын олон төрлийн тухай түгээмэл тунхаглалд үндэслэн,

2005 оны 10-р сарын 20-ны өдөр энэхүү конвенцыг батлав.

I. Зорилго ба удирдлага болгох зарчмууд

1 дүгээр зүйл. Зорилгууд

Энэхүү конвенцын зорилго нь:

- a) соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих;
- b) соёлын харилцан ашигтайгаар чөлөөтэй харилцан үйлчилж цэцэглэн хөгжих нөхцөлийг бүрдүүлэх;
- c) соёл хоорондын харилцан хүндлэл ба энхийн соёлыг дэмжихийн төлөө дэлхий дахинд соёлын өргөн цар хүрээтэй, тэнцвэртэй солилцоог хангах үүднээс соёл хоорондын харилцан яриаг хөхиүлэн дэмжих;
- d) соёлыг ард түмэн, үндэстнүүдийн хоорондын гүүр болгох гэсэн нэгэн санааны дор соёл хоорондын харилцан үйлчлэлийг хөгжүүлэх зорилгоор соёл хоорондын харилцааг хөхиүлэн дэмжих;
- e) соёлын илэрхийллийн олон төрөлд хүндэтгэлтэй хандах, орон нутгийн, үндэсний, олон улсын түвшинд түүний үнэ цэн, ач холбогдлын тухай мэдлэг ойлголтыг дээшлүүлэх явдлыг дэмжих;
- f) бүх улс оронд, ялангуяа хөгжиж буй улсуудад соёл ба хөгжил хоорондын уялдаа холбоо чухал болохыг дахин нотлон харуулж, энэхүү уялдаа холбооны жинхэнэ үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх явдлыг хангах зорилгоор үндэсний болон олон улсын хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээг дэмжих;
- g) өвөрмөц дүр төрх, үнэ цэнэ, утга агуулгын тээгч болсон соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог мөн чанарыг хүлээн зөвшөөрөх;
- h) өөрийн нутаг дэвсгэр дээрх соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд шаардлагатай гэж үзсэн бодлого, арга хэмжээг боловсруулж батлах хэрэгжүүлэх онцгой эрхүүдийг оролцогч талууд эдлэнэ гэдгийг дахин нотлон харуулах;
- i) соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор, ялангуяа хөгжиж буй орнуудын чадавхийг дээшлүүлэх үүднээс түншлэлийг өргөтгөх замаар олон улсын хамтын ажиллагаа, эв нэгдлийг бэхжүүлэх.

2 дугаар зүйл. Удирдлага болгох зарчмууд

1. Хүний эрх ба үндсэн эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх зарчим

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэх, харилцах, түүнчлэн хувь хүмүүсийн соёлын илэрхийллээ чөлөөтэй сонгох боломж зэрэг хүний эрх ба үндсэн эрх чөлөө баталгаажсан нөхцөлд соёлын олон төрлийг хамгаалж хөхиүлэн дэмжиж чадна. Энэхүү конвенцын заалтуудыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тодорхойлсон, эсхүл олон улсын эрх зүйгээр баталгаажсан хүний эрх, үндсэн эрх чөлөөг зөрчих буюу тэдгээрийн үйлчлэх хүрээг хязгаарлах зорилгоор ашиглах эрх хэнд ч байхгүй.

2. Онцгой бүрэн эрх эдлэх зарчим

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм болон олон улсын эрх зүйн зарчмын дагуу улсууд өөрсдийн нутаг дэвсгэрт соёлын илэрхийлийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх онцгой бүрэн эрхтэй.

3. Бүх соёлыг ижил тэгш үнэлж, хүндэтгэх зарчим

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалж, хөхиүлэн дэмжих нь үндэстний цөөнх болон уугуул хүмүүсийн соёлыг оролцуулан бүх соёлыг ижил тэгш үнэлж, хүндэтгэх ёстойг хүлээн зөвшөөрнө гэсэн үг.

4. Олон улсын эв нэгдэл, хамтын ажиллагааны зарчим

Олон улсын хамтын ажиллагаа, эв нэгдэл нь бүх улс оронд, ялангуяа хөгжиж буй орнуудад одоо байгаа болон шинээр бий болж буй соёлын үйлдвэрлэл оролцуулан өөрсдийн соёлыг илэрхийлэхэд шаардагдах баримт бичгийг орон нутгийн, үндэстний болон олон улсын түвшинд бий болгож, бэхжүүлэх боломж олгоход чиглэсэн байвал зохино.

5. Хөгжлийн эдийн засаг, соёлын хоёр талт зарчим

Соёл нь хөгжлийн гол хөдөлгөгч хүчний нэг учраас хөгжлийн соёлын тал нь эдийн засгийн нэгэн адил чухал ач холбогдолтой бөгөөд хувь хүмүүс болон ард түмэн түүнд оролцож, үр өгөөжийг нь хүртэх үндсэн эрхтэй.

6. Тогтвортой хөгжлийн зарчим

Соёлын олон төрөл нь хувь хүмүүс болон нийгмийн хувьд үнэт баялаг болдог. Өнөө болон хойч үеийнхний төлөө тогтвортой хөгжлийг хангах зайлшгүй нэгэн шаардлага нь соёлын олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, тэтгэх явдал юм.

7. Ижил тэгш хүртэх зарчим

Дэлхий дахины олон төрөл бүхий баялаг соёлын илэрхийлэл нь ижил тэгш хүртээмжтэй байх, түүнчлэн соёлууд нь өөрсдийгөө илэрхийлэх болон түгээн дэлгэрүүлэх баримт бичгийг ашиглах боломжоор хангагдах нь соёлын олон төрлийг бэхжүүлж, харилцан ойлголцлыг хөхиүлэн дэмжих чухал хүчин зүйлс болно.

8. Нээлттэй бөгөөд тэнцвэртэй байх зарчим

Улсууд соёлын илэрхийллийн олон төрлийг дэмжсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ дэлхийн бусад соёлд зохих ёсоор нээлттэй байлгахыг эрмэлзэх бөгөөд эдгээр арга хэмжээ нь энэхүү конвенцын зорилгод нийцсэн байхад анхаарна.

II. Үйлчлэх хүрээ

3 дугаар зүйл. Үйлчлэх хүрээ

Энэхүү конвенц нь оролцогч талуудаас соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих асуудлаар авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээнд үйлчилнэ.

III. Тодорхойлолтууд

4 дүгээр зүйл. Тодорхойлолтууд

Энэхүү конвенцын зорилгод нэр томъёог дараах байдлаар ойлгоно:

1. Соёлын олон төрөл

“Соёлын олон төрөл” гэдэг нь бүлэг, хамт олон, хүмүүсийн соёл илэрхийллээ олж буй олон янз хэлбэрийг хэлнэ. Өөрсдийгөө илэрхийлэх эдгээр хэлбэр нь хамт олон дотор, түүнчлэн тэдгээрийн хооронд дамжин өвлөгддөг.

Соёлын олон төрөл нь соёлын илэрхийллийн олон янз хэлбэрийн ачаар хүн төрөлхтний соёлын өвийг илэрхийллээ олох, өргөжин тэлэх, өвлүүлэхэд ашигладаг янз бүрийн арга хэрэгслээр дамжин илэрдэг төдийгүй янз бүрийн урлагийн бүтээл болон ашиглаж буй хэрэгсэл, технологиос үл хамааран соёлын илэрхийллийн бүтээгдэхүүнийг бүтээх, түгээх, хуваарилах болон хэрэглэх замаар илэрлээ олдог.

2. Соёлын агуулга

“Соёлын агуулга” гэдэг нь соёлын өвөрмөц хэв шинжээс үүдэлтэй буюу түүнийг илэрхийлэх бэлгэдлийн утга санаа, уран сайхны агуулга болон соёлын үнэт зүйлсийг хэлнэ.

3. Соёлын илэрхийллүүд

“Соёлын илэрхийллүүд” гэдэг нь хувь хүмүүс, бүлэг, хамт олны бүтээл түүрвилын үр дүнд бий болсон соёлын агуулга бүхий илэрхийллүүд юм.

4. Соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ

“Соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ” гэдэг нь шинж чанар, хэрэглээ, тодорхой зорилгынх нь үүднээс авч үзэхэд арилжааны үнэ цэнээс үл хамааран соёлын илэрхийллийг агуулсан буюу тээж явдаг үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хэлнэ. Соёлын үйл ажиллагаа нь өөрөө эцсийн зорилго байж болох төдийгүй соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд хувь нэмэр оруулж болно.

5. Соёлын үйлдвэр

“Соёлын үйлдвэр” гэдэг нь дээр дурдсан 4 дэх хэсэгт тодорхойлсон соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж, түгээн дэлгэрүүлдэг салбарыг хэлнэ.

6. Соёлын бодлого болон арга хэмжээ

“Соёлын бодлого болон арга хэмжээ” гэдэг нь соёлд суурилсан, эсхүл хувь хүмүүс, бүлэг, хамт олны соёлын илэрхийллийн хэлбэрүүдэд шууд нөлөө үзүүлэхэд чиглэсэн орон нутгийн, үндэсний, бүс нутгийн, эсхүл олон улсын түвшин дэх соёлын бодлого, арга хэмжээг хэлэх бөгөөд тэдгээрт соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээн түүрвих, үйлдвэрлэх, түгээх, хуваарилах болон хүртээмжтэй байх зэргийг хамааруулна.

7. Хамгаалалт

“Хамгаалалт” гэдэг нь соёлын илэрхийллийн олон төрлийг хадгалах, хамгаалах болон нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хэлнэ. “Хамгаалах” гэдэг нь эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэсэн үг.

8. Соёл хоорондын харилцан үйлчлэл

“Соёл хоорондын харилцан үйлчлэл” гэдэг нь олон янзын соёл зэрэгцэн оршиж, ижил тэгш байдлаар харилцан үйлчлэх, мөн яриа хэлэлцээ, харилцан хүндэтгэлийн үндсэн дээр соёлын нэгдсэн илэрхийллийг бий болгох боломжийг хэлнэ.

IV. Талуудын эрх ба үүрэг

5 дугаар зүйл. Эрх, үүрэгт холбогдох ерөнхий журам

1. Талууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, олон улсын эрх зүйн зарчмууд болон хүний эрхийн асуудлаар бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн баримт бичгүүдэд заасны дагуу өөрсдийн соёлын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх болон соёлын олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, түүнчлэн энэхүү конвенцын зорилгод хүрэхийн тулд олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх онцгой бүрэн эрхтэйг дахин нотолж байна.
2. Аливаа тал өөрийн улсын нутаг дэвсгэрт соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж, арга хэмжээ авах тохиолдолд түүний бодлого, арга хэмжээ нь энэхүү конвенцын заалтуудад нийцсэн байна.

6 дугаар зүйл. Үндэсний түвшин дэх талуудын эрх

1. 4.6 дугаар зүйлд тодорхойлсон соёлын бодлого, арга хэмжээний хүрээнд талууд өөрсдийн нөхцөл байдал, шаардлагыг харгалзан соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээг нутаг дэвсгэртээ авч хэрэгжүүлж болно.
2. Эдгээрт дараах арга хэмжээ багтаж болно. Үүнд:
 - a. соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн зохицуулалтын арга хэмжээ;
 - b. тухайн нутаг дэвсгэрт байгаа соёлын нийт үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний дунд байр сууриа олох боломжийг үндэсний соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд зохих ёсоор олгохдоо бүтээн түүрвэх, үйлдвэрлэх, түгээх, хуваарилах, ашиглах талаас нь авч үзэх бөгөөд эдгээр үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд хэрэглэхтэй холбогдсон арга хэмжээг оролцуулна;
 - c. үндэсний бие даасан соёлын үйлдвэр болон албан бус салбарын үйл

ажиллагааг соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх, түгээх, хуваарилах хэрэгслээр бодитой хангахад чиглэсэн арга хэмжээ;

- d. төрөөс санхүүгийн дэмжлэг туслалцаа олгоход чиглэсэн арга хэмжээ;
- e. ашгийн бус байгууллагууд болон төрийн болоод хувийн хэвшлийн байгууллагууд, уран бүтээлчид, соёлын салбарын бусад мэргэжилтнүүдийг хөхиүлэн дэмжих, соёлын үзэл санаа, илэрхийлэл, соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг чөлөөтэй солилцон, түгээх явдлыг хөгжүүлэн, хөхиүлэн дэмжих, түүнчлэн тэдгээрийн үйл ажиллагаанд бүтээн түүрвих болон ажил хэрэгч сэтгэлгээг урамшуулахад чиглэсэн арга хэмжээ;
- f. шаардлагатай тохиолдолд нийтийн үйлчилгээний байгууллагуудыг байгуулж, дэмжихэд чиглэсэн арга хэмжээ;
- g. уран бүтээлчид болон соёлын илэрхийллийг бүтээхэд оролцдог бусад хүмүүсийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээ;
- h. олон нийтийн радиог оролцуулан олон төрлийн мэдээллийн хэрэгслийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээ.

7 дугаар зүйл. Соёлын илэрхийллийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээ

- 1. Талууд өөрсдийн нутаг дэвсгэрт хувь хүмүүс болоод нийгмийн бүлгүүдийг дэмжсэн орчныг бүрдүүлэх хүчин чармайлт гаргана. Үүнд:
 - a) өөрсдийн соёлын илэрхийллийг бүтээн түүрвих, үйлдвэрлэх, түгээх, хуваарилах болон түүнээс хүртэх, ингэхдээ эмэгтэйчүүд, тэрчлэн үндэсний цөөнх болоод нутгийн уугуул иргэдийг оролцуулан нийгмийн янз бүрийн бүлгүүдийн онцгой нөхцөл, хэрэгцээ шаардлагыг зохих ёсоор анхааран үзнэ;
 - b) өөрсдийн болон дэлхийн бусад орны нутаг дэвсгэрт үүсэн бий болсон янз бүрийн соёлын илэрхийллээс хүртэх.
- 2. Талууд уран бүтээлчид, бүтээн түүрвих үйл ажиллагаанд оролцдог бусад хүмүүс, соёлын салбарын хамт олон, тэдний үйл ажиллагааг дэмждэг байгууллагуудын оруулж буй чухал хувь нэмэр болон соёлын илэрхийллийн олон төрлийг тэтгэн баяжуулах тэдгээрийн үндсэн үүргийг мөн хүлээн зөвшөөрөхийг эрмэлзэнэ.

8 дугаар зүйл. Соёлын илэрхийллийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ

- 1. 5 болон 6 дугаар зүйлтэй харшлахгүй бол аль нэг тал өөрийн нутаг дэвсгэрт соёлын илэрхийллүүд нь устаж үгүй болох эрсдэлтэй, ноцтой аюул учирсан, эсхүл нэн даруй хамгаалалтад авах шаардлагатай болсон онцгой нөхцөл байдлыг тодорхойлж болно.
- 2. Талууд энэхүү конвенцод заасны дагуу 1 дэх хэсэгт дурдсан нөхцөл байдалд соёлын илэрхийллийг хамгаалж, хадгалахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

3. Талууд 23 дугаар зүйлд заасан Засгийн газар хоорондын хороонд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлсэн бүхий л арга хэмжээний талаар илтгэх бөгөөд хороо нь зохих зөвлөмжийг гаргаж болно.

9 дүгээр зүйл. Мэдээлэл солилцоо болон ил тод байдал

Талууд:

- a) дөрвөн жил тутамд ЮНЕСКО-д илгээдэг тайландаа өөрсдийн нутаг дэвсгэрт болон олон улсын түвшинд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар зохих мэдээллийг өгнө;
- b) энэхүү конвенцтой холбогдсон мэдээллийг солилцох асуудлыг хариуцсан холбоо барих хүн/байгууллагыг томилно;
- c) соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихтэй холбогдсон мэдээллийг хуваалцаж солилцоно.

10 дугаар зүйл. Боловсрол ба олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх

Талууд:

- a) соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихийн ач холбогдлыг боловсрол болон олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөрүүдээр дамжуулан дэмжин, хөгжүүлнэ;
- b) энэ зүйлийн зорилгод хүрэхийн тулд бусад улс, олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай хамтран ажиллана;
- c) соёлын үйлдвэрийн салбарт боловсрол, сургалт, солилцооны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар бүтээн түүрвих үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж, үйлдвэрлэлийн чадавхийг бэхжүүлэхэд хүчин чармайлт тавина. Эдгээр арга хэмжээг уламжлалт үйлдвэрлэлийн хэлбэрүүдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар хэрэгжүүлнэ.

11 дүгээр зүйл. Иргэний нийгмийн оролцоо

Талууд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд иргэний нийгэм гол үүрэгтэйг хүлээн зөвшөөрнө. Энэхүү конвенцын зорилгод хүрэхийн тулд талуудын тавьж буй хүчин чармайлтад иргэний нийгмийн идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжинэ.

12 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих

Талууд соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжих таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хоёр талын, бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааг дараах зорилгоор бэхжүүлэхийг эрмэлзэхдээ 8 болон 17 дугаар зүйлд заасан нөхцөл байдлыг онцгой анхаарна. Үүнд:

- a) соёлын бодлогын асуудлаар талууд хоорондын яриа хэлэлцээг дэмжих;
- b) соёлын мэргэжилтнүүдийн болон олон улсын соёлын солилцоо, түүнчлэн тэргүүний арга туршлага хуваалцах замаар соёлын салбарын

төрийн байгууллагуудын стратегийн болон менежментийн чадавхийг дээшлүүлэх;

- c) соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжих зорилгоор иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил болон тэдгээрийн хооронд түншлэлийг бэхжүүлэх;
- d) мэдээллийн солилцоо болон соёлын харилцан ойлголцлыг бэхжүүлэх, түүнчлэн соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжих зорилгоор шинэ технологи ашиглах явдлыг дэмжиж, түншлэлийг хөхиүлэн дэмжинэ;
- e) хамтран үйлдвэрлэх болон хамтран түгээх хэлэлцээр байгуулахыг дэмжинэ.

13 дугаар зүйл. Соёлыг тогтвортой хөгжлийн бодлогод нэгтгэх

Талууд тогтвортой хөгжилд таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор соёлыг өөрсдийн тогтвортой хөгжлийн бүх шатны бодлогод нэгтгэхийг эрмэлзэх бөгөөд энэ хүрээнд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихтэй холбоотой асуудлыг харгалзан үзэхийг дэмжинэ.

14 дүгээр зүйл. Хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа

Талууд тогтвортой хөгжил болон ядуурлыг бууруулах, ялангуяа хөгжиж буй орнуудын онцгой хэрэгцээ шаардлагыг хангахын тулд соёлын эрчтэй салбарыг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах замаар хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийг эрмэлзэнэ. Үүнд:

- a) Хөгжиж буй орнуудын соёлын үйлдвэрийг дараах хэлбэрээр бэхжүүлэх:
 - (i) хөгжиж буй орнуудын соёлын үйлдвэрлэл, түгээн дэлгэрүүлэх чадавхийг бий болгон бэхжүүлэх;
 - (ii) тэдгээрийн соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг дэлхийн зах зээл болон олон улсын худалдааны сүлжээнд илүү өргөнөөр хамруулахад дэмжлэг үзүүлэх;
 - (iii) орон нутгийн болоод бүс нутгийн амьдрах чадвартай зах зээлийг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх;
 - (iv) хөгжиж буй орнуудын соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрсдийн нутаг дэвсгэрт оруулахыг дэмжих зорилгоор хөгжингүй орнууд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
 - (v) бүтээн түүрвэх үйл ажиллагааг дэмжин, хөгжиж буй орнуудын уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөнийг дэмжих;
 - (vi) хөгжингүй болон хөгжиж буй улс хоорондын хамтын ажиллагаа, ялангуяа хөгжим болон кино урлагийн салбарын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих;

- b) Мэдээлэл, түршлага, тусгай мэдлэг солилцох замаар чадавхийг бэхжүүлэх, түүнчлэн хөгжиж буй орнуудын төрийн болон хувийн хэвшлийн салбарт, ялангуяа стратегийн болон удирдлагын чадавх, бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, соёлын илэрхийллийг хөхиүлэн дэмжиж, түгээх, бичил, жижиг болон дунд үйлдвэрийг хөгжүүлэх, технологи ашиглах болон үр чадварыг хөгжүүлж, дамжуулах чиглэлээр боловсон хүчин бэлтгэх;
- c) Хөшүүргийн зохих арга хэмжээ авах замаар технологи болон нөү-хауг ялангуяа соёлын үйлдвэр, аж ахуйн байгууллагуудын дунд дамжуулах;
- d) Дараах хэлбэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх:
- (i) 18 дугаар зүйлд заасны дагуу Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сан байгуулах;
 - (ii) Шаардлагатай тохиолдолд хөгжлийн албан ёсны тусламж олгох бөгөөд бүтээн туурвих үйл ажиллагааг урамшуулан дэмжихэд чиглэсэн техникийн туслалцааг оруулна;
 - (iii) Бага хүүтэй зээл, мөнгөн тэтгэмж зэрэг санхүүгийн тусламжийн бусад хэлбэр болон санхүүжилтийн бусад арга хэрэгслүүд.

15 дугаар зүйл. Түншлэлийн хэлбэрүүд

Талууд хөгжиж буй орнуудын соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чадавхийг бэхжүүлэхэд хамтран ажиллах зорилгоор төрийн, хувийн хэвшлийн болон ашгийн бус байгууллагуудын хоорондын түншлэлийг хөгжүүлэхийг хөхиүлэн дэмжинэ. Түншлэлийн эдгээр шинэлэг хэлбэрүүд нь хөгжиж буй орнуудын бодит хэрэгцээ шаардлагыг харгалзан дэд бүтэц, хүний нөөц, бодлогын цаашдын хөгжил, түүнчлэн соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний солилцоонд онцгой анхаарал тавина.

16 дугаар зүйл. Хөгжиж буй орнуудад зориулсан хөнгөлөлттэй нөхцөл

Хөгжингүй орнууд нь хөгжиж буй орнуудын уран бүтээлчид болон соёлын салбарын бусад ажилтан, мэргэжилтнүүд, түүнчлэн соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд хөнгөлөлттэй нөхцөлийг бүтцийн болон эрх зүйн зохих хүрээнд олгох замаар хөгжиж буй орнуудтай соёлын солилцоо хийхэд дэмжлэг үзүүлнэ.

17 дугаар зүйл. Соёлын илэрхийлэлд ноцтой аюул учирсан тохиолдолд хэрэгжүүлэх олон улсын хамтын ажиллагаа

8 дугаар зүйлд дурдсан нөхцөл байдалд талууд харилцан бие биедээ туслалцаа үзүүлэх зорилгоор, ялангуяа хөгжиж буй орнуудыг анхааран, хамтран ажиллана.

**18 дугаар зүйл. Соёлын олон төрлийг
дэмжих олон улсын сан**

1. Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сан /цаашид “сан” гэх/-г үүгээр байгууна.
2. Энэ нь ЮНЕСКО-ийн санхүүгийн дүрэмд заасан ёсоор итгэлцлийн сан байна.
3. Сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
 - a. талуудын сайн дурын хандив;
 - b. энэ зорилгоор ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаар баталсан хөрөнгө;
 - c. бусад улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн байгууллагууд болон хөтөлбөрүүд, бүс нутгийн болон олон улсын бусад байгууллагууд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, эсхүл хувь хүмүүсээс оруулах хандив, бэлэг, өв залгамжлал;
 - d. сангийн хөрөнгөд ногдох аливаа хүү;
 - e. цуглуулсан хандив болон сангийн хөрөнгийг нэмэгдүүлэхээр зохион байгуулсан арга хэмжээнээс олсон орлого;
 - f. сангийн дүрмээр зөвшөөрөгдсөн аливаа бусад эх үүсвэр.
4. Сангийн хөрөнгийн зарцуулалтыг 22 дугаар зүйлд заасан талуудын бага хурлын удирдамжийг үндэслэн Засгийн газар хоорондын хороо шийдвэрлэнэ.
5. Засгийн газар хоорондын хороо нь өөрийн баталсан тодорхой төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой нийтийн болон тусгай зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн хандив болон бусад хэлбэрийн тусламжийг авч болно.
6. Санд хандив өгөх нь энэхүү конвенцын зорилгод үл нийцэх улс төр, эдийн засгийн болон бусад ямар ч нөхцөлийг дагалдуулах ёсгүй.
7. Талууд энэхүү конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор сайн дурын хандиваа тогтмол өргөж байхад хүчин чармайлт гаргана.

**19 дүгээр зүйл. Мэдээлэл солилцох, дүн шинжилгээ
хийх болон түгээх**

1. Талууд соёлын илэрхийллийн олон төрлийн талаар цуглуулсан мэдээлэл болон статистик мэдээ, түүнчлэн түүнийг хамгаалах, хөхиүлэн дэмжих тэргүүний туршлагатай холбоотой мэдээлэл, тусгай мэдлэг, туршлага солилцохоор тохиролцоно.
2. ЮНЕСКО нь Нарийн бичгийн дарга нарын газрын бүтцийг ашиглан уг асуудлаарх бүхий л мэдээлэл, статистик мэдээ, тэргүүн туршлагыг цуглуулах, дүн шинжилгээ хийх болон түгээн дэлгэрүүлэх явдлыг дэмжинэ.
3. ЮНЕСКО нь мөн соёлын илэрхийллийн салбарт үйл ажиллагаа явуулдаг янз бүрийн салбар болон төрийн, хувийн хэвшлийн, ашгийн бус байгууллагуудын талаарх мэдээллийн санг бүрдүүлж, шинэчилж байна.

4. Мэдээлэл цуглуулах ажлыг дэмжихийн тулд ЮНЕСКО нь уг асуудлаар түслэмж авахыг хүссэн талуудын чадавхийг бий болгох, түсгай мэдлэг болон туршлагыг нь өргөжүүлэхэд онцгой анхаарна.
5. Энэхүү зүйлийн дагуу цуглуулсан мэдээлэл нь 9 дүгээр зүйлийн заалтуудад заасан мэдээлэлд нэмэлт болно.

V. Бусад хэрэгсэлтэй холбогдох нь

20 дугаар зүйл. Бусад гэрээнүүдтэй холбогдох нь: харилцан дэмжих, харилцан нөхөх болон үл захирагдах

1. Талууд нь энэхүү конвенц болон нэгдэн орсон бусад бүх гэрээгээр хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлэх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрнө. Ийнхүү энэхүү конвенцыг бусад гэрээнд үл захируулан:
 - а) энэхүү конвенц болон нэгдэн орсон бусад гэрээнүүд харилцан бие биеэ дэмжихийг талууд хөхиүлэн дэмжинэ;
 - б) талууд нэгдэн орсон бусад гэрээг тайлбарлах болон хэрэглэхдээ эсхүл олон улсын бусад үүрэг хүлээхдээ энэхүү конвенцын холбогдох заалтуудыг анхааран үзэх болно.
2. Энэхүү конвенцын аль ч заалтыг талуудын нэгдэн орсон бусад гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг өөрчлөх мэтээр тайлбарлахгүй.

21 дүгээр зүйл. Олон улсын зөвлөлдөөн ба зохицуулалт

Талууд олон улсын бусад чуулга уулзалтын үеэр энэхүү конвенцын зорилго, зарчмыг дэмжих үүрэг хүлээнэ. Үүний тулд талууд эдгээр зорилго, зарчмыг эрхэмлэн шаардлагатай тохиолдолд харилцан зөвшилцөнө.

VI. Конвенцын байгууллагууд

22 дугаар зүйл. Оролцогч талуудын бага хурал

1. Талуудын бага хурлыг байгуулна. Талуудын бага хурал нь энэхүү конвенцын байнгын удирдах дээд байгууллага юм.
2. Талуудын бага хурал нь хоёр жил тутамд ээлжит чуулганаа ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын хүрээнд хуралдуулахыг эрмэлзэнэ. Бага хурлын шийдвэрээр, эсхүл талуудын гуравны нэгээс доошгүй хувийн Засгийн газар хоорондын хороонд тавьсан хүсэлтээр ээлжит бус чуулганыг хуралдуулж болно.
3. Талуудын бага хурал нь өөрийн үйл ажиллагааны дүрмийг батална.
4. Талуудын бага хурал нь дараах чиг үүрэгтэй ажиллана. Үүнд:
 - а) Засгийн газар хоорондын хорооны гишүүдийг сонгох;
 - б) Засгийн газар хоорондын хорооноос уламжилсан энэхүү конвенцод оролцогч талуудын тайланг хүлээн авч, хянан үзэх;

- c) түүний хүсэлтээр Засгийн газар хоорондын хорооноос боловсруулсан үйл ажиллагааны удирдамжийг батлах;
- d) энэхүү конвенцын зорилгод хүрэх шаардлагатай гэж үзсэн бусад дэмжлэг туслалцааг авах.

23 дугаар зүйл. Засгийн газар хоорондын хороо

1. Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих Засгийн газар хоорондын хороо /цаашид “Засгийн газар хоорондын хороо” гэх/-г ЮНЕСКО-ийн дэргэд байгуулна. Засгийн газар хоорондын хороо нь 29 дүгээр зүйлд заасны дагуу конвенц хүчин төгөлдөр болсны дараа талуудын бага хурлаас дөрвөн жилийн хугацаатай сонгогдсон конвенцод оролцогч 18 улсын төлөөлөгчдөөс бүрдэнэ.
2. Засгийн газар хоорондын хороо нь жилд нэг удаа хуралдана.
3. Засгийн газар хоорондын хороо нь оролцогч талуудын бага хурлын удирдлага дор түүнээс өгсөн чиглэлд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж, түүнд тайлагнана.
4. Конвенцод оролцогч улсуудын тоо 50 болоход Засгийн газар хоорондын хорооны гишүүдийн тоо 24 хүртэл нэмэгдэнэ.
5. Засгийн газар хоорондын хорооны гишүүдийн сонгуулийг газарзүйн тэгш хуварилалтын болон ээлжлэн сонгогдох зарчмаар явуулна.
6. Энэхүү конвенцоор олгосон бусад үүрэг хариуцлагад хохирол учруулахгүйгээр Засгийн газар хоорондын хороо нь дараах чиг үүрэгтэй ажиллана:
 - a) энэхүү конвенцын зорилгод хүрэхэд дэмжлэг үзүүлэх, түүний хэрэгжилтийг хөхиүлэн дэмжих, хяналт тавих;
 - b) Конвенцын заалтуудыг хэрэгжүүлэх, хэрэглэхтэй холбоотой үйл ажиллагааны удирдамжийг талуудын бага хурлын хүсэлтээр бэлтгэж, батлуулах;
 - c) Конвенцод оролцогч талуудын тайланг өөрийн тайлбар болон тайлангийн агуулгын хураангуйн хамт талуудын бага хуралд оруулан хэлэлцүүлэх;
 - d) Конвенцын холбогдох заалтууд, ялангуяа 8 дугаар зүйлд заасны дагуу конвенцод оролцогч талуудаас мэдэгдсэн нөхцөл байдалд зохих зөвлөмжийг гаргах;
 - e) олон улсын бусад чуулга уулзалтын үеэр энэхүү конвенцын зорилго, зарчмыг дэмжих зорилгоор зөвлөлдөөний журам болон бусад арга хэрэгслийг бий болгох;
 - f) талуудын бага хурлаас даалгасан аливаа бусад үүргийг хэрэгжүүлэх.
7. Засгийн газар хоорондын хороо нь үйл ажиллагааныхаа дүрэм ёсоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, эсхүл хувь хүмүүстэй тодорхой асуудлаар зөвлөлдөх зорилгоор тэднийг өөрийн хуралдаанд оролцохыг хэдийд ч урьж болно.

8. Засгийн газар хоорондын хороо нь үйл ажиллагааныхаа дүрмийг боловсруулж, талуудын бага хуралд батлуулахаар оруулна.

24 дүгээр зүйл. ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газар

1. Конвенцын байгууллагууд нь ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын дэмжлэг туслалцааг авна.
2. Нарийн бичгийн дарга нарын газар нь талуудын бага хурал болон Засгийн газар хоорондын хорооны ажлын баримт бичгүүд болон хуралдааны хэлэлцэх асуудлын төслийг бэлтгэх бөгөөд шийдвэрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, тайлан гаргана.

VII. Төгсгөлийн заалт

25 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

1. Конвенцыг тайлбарлах эсвэл хэрэглэхэд энэхүү конвенцод оролцогч талуудын хооронд үүссэн маргааныг талууд хэлэлцээний замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
2. Хэрэв холбогдох талууд хэлэлцээний замаар тохиролцоонд хүрч чадахгүй бол тэд хамтран гуравдагч талын сайн санааны үйлчилгээ буюу зуучлалыг авч болно.
3. Хэрэв гуравдагч талын сайн санааны үйлчилгээ буюу зуучлагч байхгүй, эсвэл маргааныг хэлэлцээ, сайн дурын үйлчилгээ, эсхүл зуучлалын замаар шийдвэрлэж чадаагүй бол аль нэг тал энэхүү конвенцын хавсралтад заасан журмын дагуу эвлэрлийн арга хайна. Талууд Эвлэрлийн комиссоос гаргасан маргаан шийдвэрлэх саналыг чин сэтгэлээсээ судална.
4. Талууд конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах буюу нэгдэн орох үед дээр дурдсан эвлэрлийн журмыг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа мэдэгдэж болно. Ийм мэдэгдэл гаргасан аль ч тал ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд мэдэгдэж, уг мэдэгдлийг хэдийд ч эргүүлэн татан авч болно.

26 дугаар зүйл. Гишүүн орнууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох

1. Энэхүү конвенцыг ЮНЕСКО-ийн гишүүн улсууд Үндсэн хуулийнхаа холбогдох журмын дагуу соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орно.
2. Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд хадгалуулна.

27 дугаар зүйл. Нэгдэн орох

1. Энэхүү конвенц нь ЮНЕСКО-ийн гишүүн бус, гэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллага эсхүл түүний аль нэг төрөлжсөн байгууллагын гишүүн бөгөөд ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаас түүнд нэгдэн орохыг уриалсан бүх улсын хувьд нэгдэн ороход нээлттэй байна.

2. Энэхүү конвенц нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн 1514 (XV) тогтоолын дагуу бүрэн тусгаар тогтноогүй боловч Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүлээн зөвшөөрснөөр дотооддоо өөрийгөө бүрэн удирдах эрх бүхий, энэхүү конвенцоор зохицуулах аливаа асуудлыг шийдвэрлэх эрх мэдэлтэй, ялангуяа эдгээр асуудлаар олон улсын гэрээ байгуулах эрх мэдэл бүхий нутаг дэвсгэр нэгдэн ороход мөн нээлттэй байна.
3. Дараах заалтууд бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудад үйлчилнэ:
 - a) Энэхүү конвенц нь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны аливаа байгууллага нэгдэн ороход мөн нээлттэй байх бөгөөд доорх хэсгүүдэд зааснаас бусад тохиолдолд оролцогч улсуудын нэгэн адил конвенцын заалтуудтай бүрэн холбогдоно.
 - b) Дээрх байгууллагын нэг буюу хэд хэдэн гишүүн улс мөн энэхүү конвенцод оролцогч талууд нь энэхүү конвенцын дагуу үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрсдийн хариуцлагыг харилцан тохиролцоно. (c) дэд хэсэгт заасан мэдэгдэх журам дуусгавар болсны дараа байгууллага болон гишүүн улсуудын тус тусын хариуцлага хүчин төгөлдөр болно. Байгууллага ба гишүүн улсууд нь энэхүү конвенцоос үүдэн гарах эрхийг зэрэг эдлэх боломжгүй. Мөн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд нь өөрийн эрх мэдэлд хамрах асуудлаар санал өгөх эрхээ эдлэхдээ энэхүү конвенцод оролцогч өөрийн гишүүн улсуудын тоотой тэнцүү тооны саналын эрхтэй байна. Гишүүн улсууд санал өгөх эрхээ эдэлж буй тохиолдолд эдгээр байгууллагууд нь өөрсдийн эрхийг эдлэхгүй бөгөөд энэ нь эсрэг тохиолдолд мөн адил хамаарна.
 - c) бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага болон түүний гишүүн улс буюу улсууд нь (б) дэд хэсэгт заасны дагуу харилцан тохиролцсон тус тусын хариуцлагыг түүнд холбогдох талуудад дараах байдлаар мэдэгдэнэ:
 - (i) уг байгууллага нь энэхүү конвенцоор зохицуулах асуудлуудтай холбогдсон тус тусын хариуцлагыг нэгдэн орсон баримт бичигт тодорхой заасан байна;
 - (ii) тус тусын холбогдох хариуцлагыг цаашид өөрчлөх тохиолдолд бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага нь эдгээр хариуцлагыг өөрчлөх тухай аливаа саналыг конвенцын хадгалагчид мэдэгдэх бөгөөд хадгалагч нь өөрийн зүгээс уг өөрчлөлтөд оролцогч талуудад мэдэгдэнэ;
 - c) Конвенцод оролцогч талууд болж буй бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудаас уг байгууллагад эрх мэдлээ шилжүүлсэн тухай хадгалагчид тусгайлан мэдэгдээгүй бүх асуудлаар өөрсдийн эрх мэдлийг хадгалж үлдсэнд тооцно.
 - d) “Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага” гэдэг нь Нэгдсэн Үндэстний Байгууллага буюу түүний аль нэг төрөлжсөн байгууллагын гишүүн тусгаар тогтносон улсуудаас бүрдсэн, энэхүү конвенцоор зохицуулах асуудлаар өөрсдийн эрх мэдлийг гишүүн улсууд

нь түүнд шилжүүлсэн бөгөөд дотоод журмынхаа дагуу конвенцод оролцогч тал болохоор зүй ёсоор зөвшөөрөгдсөн байгууллагыг хэлнэ.

4. Нэгдэн орсон хэрэгслийг ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд хадгалуулахаар өгнө.

28 дугаар зүйл. Холбоо тогтоох байгууллага

Энэхүү конвенцод оролцогч тал бүр 9 дүгээр зүйлд дурдсан холбоо барих хүн/байгууллагыг томилно.

29 дүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү конвенц нь түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай 30 дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш энэ өдөр буюу түүнээс өмнө нь соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай өөрсдийн холбогдох баримт бичгийг хадгалуулахаар өгсөн улсууд, эсхүл бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Харин аливаа бусад улсын хувьд тэрээр соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай өөрийн баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.
2. Энэ зүйлийн зорилгод бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас хадгалуулахаар өгсөн ямар ч баримт бичгийг уг байгууллагын гишүүн улсуудаас хадгалуулахаар өмнө нь өгсөн баримт бичигт нэмж тооцохгүй.

30 дугаар зүйл. Холбооны буюу нэгдмэл бус үндсэн хуулийн тогтолцоо

Олон улсын гэрээ нь үндсэн хуулийн тогтолцооноос нь үл хамааран бүх талуудад ижил үйлчилдэг болохыг хүлээн зөвшөөрч, дараах заалтуудыг холбооны буюу нэгдмэл бус үндсэн хуулийн тогтолцоотой талуудад хэрэглэнэ:

- а. холбооны буюу хууль тогтоох төв засаглалын эрх мэдлийн хүрээнд хэрэглэх энэхүү конвенцын заалтуудын хувьд холбооны буюу төв засгийн газрын хүлээх үүрэг нь холбооны бүс оролцогч улсуудын үүрэгтэй нэгэн адил байна;
- б. холбооны үндсэн хуулийн тогтолцооны дагуу хууль тогтоох үүрэггүй, холбооны бүрэлдэхүүн нэгж болох муж, хязгаар, эсхүл кантоны эрх мэдлийн хүрээнд хэрэглэх энэхүү конвенцын заалтуудын хувьд холбооны засгийн газар нь шаардлагатай тохиолдолд улс, хязгаар, муж, эсхүл кантоны эрх бүхий байгууллагуудад дээрх заалтууд болон тэдгээрийг батлах тухай зөвлөмжийн хамт мэдэгдэнэ.

31 дүгээр зүйл. Цуцлах

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцыг цуцалж болно.
2. Конвенцыг цуцалсан тухайгаа бичгээр үйлдэж ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд хадгалуулна.

3. Цуцалсан тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш арван хоёр сарын дараа цуцлалт хүчин төгөлдөр болно. Цуцлалт хүчин төгөлдөр болох хүртэл цуцалж буй талын хүлээсэн санхүүгийн үүрэг огт өөрчлөгдөхгүй.

32 дугаар зүйл. Хадгалагчийн үүрэг

Энэхүү конвенцыг хадгалагчийн хувьд ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал 26 болон 27 дугаар зүйлд дурдсан соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай хадгалуулахаар өгсөн бүх хэрэгслүүд болон 31 дүгээр зүйлд заасан конвенцыг цуцалсан тухай мэдэгдлүүдийн талаар тус байгууллагын гишүүн бус улсууд, 27 дугаар зүйлд дурдсан бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагад мэдэгдэнэ.

33 дугаар зүйл. Нэмэлт өөрчлөлт

1. Аливаа тал ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцод нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Ерөнхий захирал уг саналыг бүх талуудад хүргүүлнэ. Уг саналыг хүргүүлснээс хойш зургаан сарын дотор талуудын талаас багагүй хувь нь уг саналыг дэмжсэн хариу ирүүлбэл Ерөнхий захирал түүнийг талуудын бага хурлын дараагийн чуулганд оруулан хэлэлцүүлж, боломжтой бол батлуулна.
2. Нэмэлт өөрчлөлтийг санал хураалтад хүрэлцэн ирж, оролцсон талуудын гуравны хоёроос дээш хувийн саналаар батална.
3. Энэхүү конвенцод оруулсан нэмэлт өөрчлөлтийг баталсны дараа түүнийг соёрхон батлуулах, хүлээн зөвшөөрүүлэх, батлуулах, эсхүл түүнд нэгдэн оруулахаар талуудад хүргүүлнэ.
4. Энэхүү конвенцын нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон талуудын хувьд уг нэмэлт өөрчлөлт энэ зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан баримт бичгүүдийг талуудын гуравны хоёр хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Харин түүнийг цаашид соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсхүл түүнд нэгдэн орох тал бүрийн хувьд нэмэлт өөрчлөлт нь тухайн талаас соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсхүл түүнд нэгдэн орсон баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.
5. 3 болон 4 дэх хэсэгт заасан журмыг Засгийн газар хоорондын хорооны гишүүдийн тооны талаар 23 дугаар зүйлд оруулсан нэмэлт өөрчлөлтөд хэрэглэхгүй.
6. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа энэхүү конвенцын оролцогч тал болсон улс, эсхүл 27 дугаар зүйлд тодорхойлсон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага нь өөр аливаа санал ирүүлээгүй бол түүнийг:
 - a) нэмэлт өөрчлөлт оруулсан энэхүү конвенцын тал;
 - b) эдгээр нэмэлт өөрчлөлттэй холбоогүй аливаа талын хувьд энэхүү конвенцод нэмэлт өөрчлөлт оруулаагүй тал гэж үзнэ.

34 дүгээр зүйл. Адил хүчинтэй эх бичвэрүүд

Энэхүү конвенцыг араб, хятад, англи, франц, орос, испани хэлээр үйлдсэн бөгөөд зургаан эх бичвэр бүгд адил хүчинтэй.

35 дугаар зүйл. Бүртгэл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенцыг ЮНЕСКО-ийн Ерөнхий захирлын хүсэлтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

Хавсралт Эвлэрлийн үйл явц

1 дүгээр зүйл. Эвлэрлийн комисс

Маргалдагч талуудын аль нэгний хүсэлтээр эвлэрлийн комиссыг байгуулна. Талууд өөрөөр тохироогүй бол комисс нь таван гишүүнээс бүрдэх бөгөөд холбогдол бүхий тал бүр хоёр гишүүн томилж, ийнхүү томилогдсон гишүүд хамтран ерөнхийлөгчөө сонгоно.

2 дугаар зүйл. Комиссын гишүүд

Хоёроос илүү тал маргаанд оролцож буй тохиолдолд ижил ашиг сонирхолтой талууд хамтран комиссын өөрийн гишүүдийг томилно. Хоёр эсвэл түүнээс олон талууд өөр өөр ашиг сонирхолтой байх юмуу, ижил ашиг сонирхолтой эсэх дээр тохиролцож чадахгүй бол тэд өөрсдийн гишүүдийг тус тусдаа томилно.

3 дугаар зүйл. Томилгоо

Эвлэрлийн комисс байгуулах тухай хүсэлт тавьснаас хойш талууд хоёр сарын дотор комиссын бүх гишүүдийг томилж чадаагүй бол ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал хүсэлт тавьсан талын саналаар дараагийн хоёр сарын дотор шаардлагатай томилгоог хийнэ.

4 дүгээр зүйл. Комиссын ерөнхийлөгч

Эвлэрлийн комиссын сүүлийн гишүүн томилогдсон өдрөөс хойш хоёр сарын дотор гишүүд ерөнхийлөгчөө сонгож чадаагүй бол ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал аль нэг талын хүсэлтээр дараагийн хоёр сарын дотор ерөнхийлөгчийг томилно.

5 дугаар зүйл. Шийдвэр

Эвлэрлийн комисс нь гишүүдийн олонхийн саналаар шийдвэрээ гаргана. Маргалдагч талууд өөрөөр тохиролцоогүй бол комисс өөрийн дотоод журмыг тодорхойлно. Комиссоос маргааныг шийдвэрлэх санал боловсруулж гаргах бөгөөд талууд түүнийг чин сэтгэлээсээ судалж үзнэ.

6 дугаар зүйл. Эсрэг байр суурь

Эвлэрлийн комисс эрх мэдэлтэй эсэх тухайд эсрэг байр суурь илэрхийлэгдэх тохиолдолд асуудлыг комисс өөрөө шийднэ.

2

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Үйл ажиллагааны удирдамж

Оролцогч талуудын хоёр дахь хуралдаан (2009 оны 6-р сарын 15-16, Парис), гурав дахь хуралдаан (2011 оны 6-р сарын 14-15, Парис), дөрөв дэх хуралдаан (2013 оны 6-р сарын 11-13, Парис), тав дахь хуралдаан (2015 оны 6-р сарын 10-12 Парис), зургаа дахь хуралдаанаар (2017 оны 6-р сарын 12-15, Парис) тус тус батлав.

Соёлын илэрхийллийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээ

- Соёлын илэрхийллийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ – Онцгой нөхцөл байдал
- Мэдээлэл солилцоо ба ил тод байдал
 - Хавсралт-Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээний дөрвөн жил тутмын тайлангийн хамрах хүрээ
- Боловсрол ба олон нийтийн ойлголт
- Иргэний нийгмийн үүрэг ба оролцоо
 - Хавсралт-Конвенцын байгууллагуудын хуралд иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах багц шалгуур
- Соёлыг тогтвортой хөгжлийн бодлогод нэгтгэх нь
- Хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа
- Түншлэлийн хэлбэрүүд
- Хөгжиж буй орнуудад зориулсан хөнгөлөлттэй нөхцөл
- Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сангийн нөөцийг ашиглах тухай удирдамж
- Мэдээлэл солилцох, дүн шинжилгээ хийх болон түгээх
- Конвенцыг танилцуулах болон хөхиүлэн дэмжих явдлыг хангах арга хэмжээ
- Конвенцын бэлгэ тэмдгийг хэрэглэх заавар
- Дижитал орчинд конвенцыг хэрэгжүүлэх тухай удирдамж
- Үйл ажиллагааны удирдамж – Соёлын илэрхийллийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээ

Соёлын илэрхийллийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээ

7 дугаар зүйл. Соёлын илэрхийллийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээ

1. Талууд:
 - (a) тусгай нөхцөл байдалд болон эмэгтэйчүүдийн хэрэгцээ, түүнчлэн угсаатны цөөнх болон нутгийн уугуул иргэдэд харъяалагдах олон төрлийн нийгмийн бүлгүүдэд анхаарал хандуулан өөрсдийн соёлын илэрхийллийг бүтээх, үйлдвэрлэх, нэвтрүүлэх, түгээхэд нь;
 - (b) өөрийн нутаг дэвсгэрийн дотор болон дэлхийн бусад улс орнуудын соёлын илэрхийллийн олон төрлийг хүртэх боломжийг бий болгоход нь хувь хүн болон нийгмийн бүлгүүдийг дэмжсэн орчныг өөрийн нутаг дэвсгэрт бүрдүүлэхэд хүчин чармайлт гаргана.
2. Талууд уран бүтээлчид, бүтээн туурвих үйл явцад оролцогч бусад хүмүүс, соёлын салбарын хамт олон, тэдний үйл ажиллагааг дэмждэг байгуулагуудын оруулж буй чухал хувь нэмэр болон соёлын илэрхийллийн олон төрлийг тэтгэн баяжуулахад тэдний гүйцэтгэх үндсэн үүргийг мөн хүлээн зөвшөөрөхийг эрмэлзэнэ.

Зарчмууд

1. Соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжихийн тулд талуудын боловсруулсан соёлын бодлого болон арга хэмжээ нь:
 - 1.1 Үндсэн хуулийн хүрээнд хамааруулан зохих түвшинд нэгдсэн чиг хандлагын нэг хэсэг байна;
 - 1.2 Конвенцын 2 дугаар зүйлд заасан удирдах зарчим дээр тулгуурласан байна;
 - 1.3 Соёлын илэрхийллийн олон төрөлд хувь нэмэр оруулж буй нийгмийн бүхий л гишүүд, ялангуяа угсаатны цөөнх, уугуул иргэд, эмэгтэйчүүдийн бүрэн дүүрэн оролцоо, хамрагдах явдлыг дэмжинэ;
 - 1.4 Соёлын салбарт хэрэглэгддэг бусад олон улсын хууль эрхзүйн хэрэгслүүдийн зүйл ангийг харгалзан үзнэ;
 - 1.5 Ямар ч арга хэрэгсэл, технологи ашиглан бүтээж, үйлдвэрлэж, түгээн дэлгэрүүлж, тарааж, хүртээж болох олон төрлийн соёлын үйл ажиллагаа, бараа, үйлчилгээний бүхий л талыг харгалзан үзэж эрч хүчтэй соёлын салбарын хөгжлийг дэмжинэ.
- 1.6 Онцгойлон:

- 1.6.1 соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээхээр чармайж буй уран бүтээлчид болон бүтээгчдийг бүтээн түүрвих үед нь дэмжин туслах;
- 1.6.2 үйлдвэрлэлийн механизмыг нэвтрүүлэх болон соёлын үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжсэнээр соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг үйлдвэрлэлийн шатанд нь дэмжих;
- 1.6.3 үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд төрийн, хувийн хэвшлийн байгууллагын сувгуудаар дамжуулан соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хуваарилалтад орох боломжийг түгээлтийн үе шатанд нь дэмжих;
- 1.6.4 хүртэх буюу хүртээмж бий болгох үе шатанд нь зохих урамшуулал бий болгосноор дотоодын болон гадаадын соёлын ямар үйл ажиллагаа, бараа, үйлчилгээ байгаа талаарх мэдээлэл хүргэх, олон нийтийн мэдээлэлд хандах чадавхийг хөгжүүлэхийг тус тус зорино.

Соёлын илэрхийллийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээ

Улсуудын соёлын бодлогоо томъёолох, хэрэгжүүлэх болон холбогдох арга хэмжээнүүдийг батлан хэрэгжүүлэх бүрэн эрхийнх нь дагуу (Конвенцын 5.1 дүгээр зүйл) талуудыг соёлын салбарт бодлогын арга хэрэгсэл ба сургалтын үйл ажиллагааг боловсруулан хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжинэ. Эдгээр арга хэрэгсэл, үйл ажиллагаа нь соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг оролцогч бүх талуудын, ялангуяа Үйл ажиллагааны удирдамжид тодорхойлсноор иргэний нийгмийн оролцоотойгоор бүтээн түүрвих, үйлдвэрлэх, түгээн дэлгэрүүлэх, хуваарилах, хүртэх үйл явцыг дэмжихэд чиглэгдэх ёстой юм.

2. Эдгээр арга хэрэгсэл нь дараах салбаруудтай холбогдож болно. Үүнд:

- 2.1 Хууль эрх зүйн: соёлын салбарын хууль эрхзүйн тогтолцоо бүрдүүлэх (тухайлбал, өргөн нэвтрүүлэг, зохиогчийн эрх, уран бүтээлчийн нийгэмд эзлэх байр суурийн талаарх хууль эрхзүйн баримт бичгүүд гэх мэт);
- 2.2 Бүтээн түүрвих/ үйлдвэрлэх/ түгээх: дотоодын соёлын агуулгыг бүтээх, үйлдвэрлэх, үзүүлэн таниулах, дамжуулах эрх бүхий соёлын байгууллагуудыг байгуулах;
- 2.3 Санхүүгийн дэмжлэг: дотоодын соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээн түүрвих, үйлдвэрлэх, хуваарилах, түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор татварын урамшуулал олгох зэрэг санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг боловсруулах;
- 2.4 Нөлөөлөл ба сурталчилгаа: Талуудын эрхийг таниулах, сурталчлах зорилго бүхий төрөл бүрийн олон улсын хууль эрхзүйн арга хэрэгслүүдийн талаарх солилцооны хөтөлбөрт оролцох;
- 2.5 Экспорт, импортын бодлого: экспортын баримжаатай (соёлын илэрхийллийг гадаадад сурталчлах) болон импортод суурилсан (тухайн зах зээл дээрээ соёлын илэрхийллийн олон төрлийг түгээх

- боломж олгох) стратегийн аль алиныг нь хөгжүүлэх;
- 2.6 Хүртээмжийг бий болгох стратеги: соёлын бараа, үйлчилгээг хүртэх, хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор эдийн засгийн эмзэг бүлэгт зориулсан хөтөлбөр, урамшууллын механизмыг дэмжин ажиллах зэрэг болно.
3. Соёлын салбарт технологийн өөрчлөлт явагдаж байгаа нь соёлын агуулгыг бүтээх, үйлдвэрлэх, хуваарилах, түгээн дэлгэрүүлэхэд ч мөн тодорхой хэмжээний өөрчлөлт авчирч болохыг анхааран үзэж талууд дараах хэлбэрийн хөндлөнгийн оролцоог хөхиүлэн дэмжинэ. Үүнд:
- 3.1 технологийн шинэ орчинд шилдэг байдлаар дасан зохицох соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн бодлого, арга хэмжээг онцгойлон авч үзэх;
- 3.2 шинэ технологийн санал болгож буй хэтийн төлөвийн үр шимийг бүрэн дүүрэн хүртэхэд шаардагдах мэдлэг, үр чадвар эзэмшихийн тулд соёлын мэргэжилтнүүд, соёлын үйлдвэрлэл, нэн ялангуяа залуучуудад тус дэм болох мэдээлэл болон тусгай мэдлэгийг дамжуулахад дэмжлэг үзүүлэх.
4. Бодлогын арга хэмжээ, хэрэгслүүд нь боломж байваас тухайн орон нутгийн уугуул хүн амыг оролцуулан одоогийн байгаа бүтэц, сүлжээн дээр тулгуурлах нь зүйтэй бөгөөд эдгээр бүтцийг цаашид бодлогын индэр болгон хөгжүүлэх ямар боломж байгааг нь судлан үзвэл зохистой. Үүний хамтаар үндэсний түвшинд соёлын бодлого боловсруулах, бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг бүрэлдүүлэхдээ аль боломжтой газар нь бүс нутгийн байр сууриар түүнийгээ баталгаажуулах боломжтой юм.
5. Удирдлага болгон баримтлах зарчим, хэрэгжүүлэхийг нь хөхиүлэн дэмжсэн арга хэмжээний зэрэгцээ талууд нь соёлын салбарт шилдэг амжилт үзүүлсэн бодлого, арга хэмжээ, хөтөлбөр, санаачилгуудын талаарх мэдээлэл, туршлагаа хуваалцаж, илүү сайн харилцаа холбоо тогтоохыг хөхиүлэн дэмжинэ.

Соёлын илэрхийллийг хамгаалахад¹ чиглэсэн арга хэмжээ

Онцгой нөхцөл байдал

8 дугаар зүйл. Соёлын илэрхийллийг хамгаалах арга хэмжээ

1. 5 болон 6 дугаар зүйлийн заалтуудад харшлахгүй бол аль нэг тал өөрийн нутаг дэвсгэрт соёлын илэрхийллүүд устаж үгүй болох эрсдэлтэй, ноцтой аюул учирсан, эсхүл нэн даруй хамгаалалтад авах шаардлагатай болсон онцгой нөхцөл байдлыг тодорхойлж болно.
2. Талууд энэхүү конвенцын заалтуудтай нийцүүлэн 1 дэх хэсэгт дурдсан нөхцөл

байдалд соёлын илэрхийллийг хамгаалж, хадгалахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

3. Талууд 23 дугаар зүйлд заасан Засгийн газар хоорондын хороонд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар илтгэх бөгөөд хороо нь зохих зөвлөмжийг гаргаж болно.

17 дугаар зүйл. Соёлын илэрхийлэлд ноцтой аюул учирсан нөхцөл байдалд хэрэгжүүлэх олон улсын хамтын ажиллагаа

8 дугаар зүйлд дурдсан нөхцөл байдалд талууд харилцан туслалцаа үзүүлэх зорилгоор, ялангуяа хөгжиж буй орнуудыг анхааран, хамтран ажиллана.

Онцгой нөхцөл байдал

1. Соёлын илэрхийлэлд учирч болох аюул нь тухайлбал, соёлын, биет эсхүл эдийн засгийн шинж чанартай байж болох юм.
2. Талууд энэхүү конвенцын 8 дугаар зүйлд заасны дагуу онцгой нөхцөл байдалд өөрийн нутаг дэвсгэрт соёлын илэрхийллийг хамгаалах, хадгалахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч болно.

Соёлын илэрхийллийг хамгаалах, хадгалахад чиглэсэн арга хэмжээ

3. 8 дугаар зүйлийн 2-т заасны дагуу талуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь талуудын тодорхойлсон “онцгой нөхцөл байдал”-ын шинж чанараас хамаарах бөгөөд дараах зүйлээр хязгаарлахгүй. Үүнд: хурдан шүүрхай үр дүнгээ өгөх богино хугацааны эсхүл онцгой арга хэмжээ; хэрэгжиж буй бодлого, арга хэмжээнд хүч нэмэх, нэмэлт өөрчлөлт оруулах; шинэ бодлого, арга хэмжээ нэвтрүүлэх; урт хугацааны стратеги боловсруулах, олон улсын хамтын ажиллагаанд хандах зэрэг зүйл багтана.
4. Талууд 8 (2) дугаар зүйлд заасан арга хэмжээ нь конвенцын удирдах зарчимд саад учруулахгүй байх, аль ч талаараа конвенцын агуулга, үзэл санаатай нийцэж байгааг талууд баталгаажуулах ёстой.

Хороонд тайлагнах

5. 8-3 дугаар зүйлд заасны дагуу талууд Засгийн газар хоорондын хороонд тайлан хүргүүлэх бүртээ:
 - 5.1 тухайн нөхцөл байдал ЮНЕСКО-ийн бусад конвенцын хамрах хүрээний субъект биш болохыг тодорхойлох;
 - 5.2 соёлын илэрхийлэл эрсдэлд орсон эсхүл аюулд учирсан, аль эсвэл нэн даруй хамгаалалтад авах шаардлага байгаа эсэхийг мэргэжилтнүүд, иргэний нийгэм, шаардлагатай гэж үзвэл орон нутгийн хүн амыг оролцуулан тогтоох;
 - 5.3 аюулын эх үүсвэрийг бодит тоо, баримт оролцуулан нотлох;
 - 5.4 эрсдэлд ороод буй соёлын илэрхийллийн эмзэг байдал хийгээд ач холбогдлыг тодорхойлох;
 - 5.5 соёлын илэрхийлэлд учраад буй эрсдэл, аюулын үр дагаврын мөн чанарыг тодорхойлох хийгээд соёлын үр дагаврын мөн чанарыг

- дэлгэн харуулах;
- 5.6 онцгой нөхцөл байдлыг засахын тулд хэрэгжүүлсэн болон санал болгосон арга хэмжээнүүдийг богино хугацааны болон онцгой арга хэмжээ, урт хугацааны стратеги зэргийг оролцуулан тайлбарлах;
- 5.7 шаардлагатай гэж үзвэл олон улсын хамтын ажиллагаа болон туслалцаа авах хүсэлт гаргах.
6. 8.1 дүгээр зүйлд заасан онцгой нөхцөл байдал үүссэнийг аливаа тал тодорхойлж 8.2 дугаар зүйлд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ талаар тухайн холбогдох тал хороонд тайлагнана. Тайлан нь энэ бүлгийн 5 дугаарт жагсаасан мэдээллийг агуулсан байна.
7. Тайланг холбогдох асуудлын талаарх мэдээллийг түгээх болон авч хэлэлцэх бололцоо олгох зорилгоор хорооны ээлжит хуралдаан хуралдахаас доод тал нь гурван сарын өмнө хороонд хүргүүлсэн байна.

Засгийн газар хоорондын хорооны үүрэг

8. Хороо нь өөрийн ээлжит хуралдааны хэлэлцэх асуудалд 8 дугаар зүйлд заасан онцгой нөхцөл байдлын талаарх тайланг багтаан оруулна. Хуралдаанаар тайлан, түүнд хавсаргасан бүрэлдэхүүн хэсгүүдийг нягтлан үзнэ.
9. Тал өөрийн нутаг дэвсгэрт онцгой нөхцөл үүссэнийг тодорхойлон, энэ тухай хороонд мэдэгдсэн нөхцөлд хорооны зүгээс, хэрэв шаардлагатай гэж үзвэл 8 (3) дугаар болон 23 (6) дугаар зүйлд заасны дагуу нөхцөл байдлыг засахад авч хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн талд санал болгон зөвлөмж хүргүүлнэ.
10. 8 (1) дүгээр зүйлд заасан онцгой нөхцөл байдал үүссэнийг аль нэг талын зүгээс тодорхойлсон бол хороо дараах арга хэмжээг санал болгож болно. Үүнд:
- 10.1 ижил төстэй нөхцөлд орсон талуудын тэргүүн туршлагыг түгээхэд дэмжлэг үзүүлэх;
- 10.2 нөхцөл байдлыг талуудад мэдээлж, 17 дугаар зүйлийн хүрээнд туслалцаа үзүүлэх зорилгоор арга хэмжээ авахыг уриалах;
- 10.3 холбогдох талд хэрэв шаардлагатай бол Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сангаас тусламж хүсэхийг санал болгоно. Энэхүү хүсэлтдээ энэ бүлгийн 5 дугаар хэсэгт өгүүлсэн мэдээлэл, тоо баримт болон шаардлагатай гэж үзэж буй бүх мэдээллийг хавсаргах хэрэгтэй.

Тогтмол хугацааны тайлан

11. Хэрэв аливаа тал 8 (1) дүгээр зүйлд заасан онцгой нөхцөл байдал үүссэнийг тодорхойлон 8 (2) дугаар зүйлд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тохиолдолд эдгээр арга хэмжээнийхээ талаарх зохих мэдээллийг 9 (а) дүгээр зүйлд заасны дагуу ЮНЕСКО-д илгээдэг тогтмол хугацааны тайландаа багтаасан байна.

Олон улсын хамтын ажиллагаа

12. 17 дугаар зүйлд заасны дагуу талууд 8 дугаар зүйлд заасан нөхцөл байдал

үүссэн тохиолдолд хөгжиж буй орнуудад онцгой анхаарал тавьж, харилцан түслалцаа үзүүлэх тал дээр хамтран ажиллах ёстой.

13. Хамтын ажиллагаа нь хоёр талт, бүс нутгийн эсхүл олон талт хэлбэртэй байж болно. Энэ утгаараа талууд 17 дугаар зүйлд заасны дагуу бусад талуудаас түсламж хүсэж болох бөгөөд энэ түслалцаа нь тухайлбал техникийн эсвэл санхүүгийн байж болно.
14. Холбогдох талуудын онцгой нөхцөл байдлыг арилгахад чиглэсэн бие даасан үйл ажиллагааны хажуугаар талуудын уялдан зохицуулсан хамтын ажиллагааг дэмжих ёстой.

Мэдээлэл солилцоо ба ил тод байдал

9 дүгээр зүйл. Мэдээлэл солилцоо ба ил тод байдал

Талууд:

- (a) дөрвөн жил тутамд ЮНЕСКО-д илгээдэг тайландаа өөрсдийн нутаг дэвсгэрт болон олон улсын түвшинд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ талаар зохих мэдээллийг өгнө;
- (b) энэхүү конвенцтой холбогдсон мэдээллийг солилцох үүрэг бүхий холбоо барих хүн/байгууллагыг томилно;
- (c) соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихтэй холбогдсон мэдээллийг хуваалцаж, солилцоно.

Конвенцод нэгдсэн талуудын дөрвөн жил тутмын тайлан

1. Тал бүр конвенцыг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ өргөн барьснаас хойш дөрөв дэх жилдээ, цаашид дараагийн дөрвөн жил тутамд 22.4 (б) дүгээр зүйлд заасны дагуу оролцогч талуудын бага хуралд танилцуулахаар тайлангаа хүргүүлнэ.
2. Тайлан нь талуудын өөрийн нутаг дэвсгэрт болон олон улсын түвшинд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний талаар төдийгүй тэдгээрийн нөлөө, үр дүнгийн талаарх холбогдох мэдээлэл агуулсан байна.
3. Энэхүү тайланд орсон мэдээлэл, тоо баримт нь конвенцыг хэрэгжүүлэх, түүний дагалдах үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах зорилгоор туршлага, шилдэг жишээгээ харилцан солилцох боломжийг бий болгох юм.

Тайлангийн загвар маягт ба агуулга

4. Талууд оролцогч талуудын бага хурлаас баталж, удирдамжуудад хавсаргасан тайлангийн хамрах хүрээг тодорхойлсон загвар маягтын дагуу мэдээлэл өгнө. Бага хуралд оролцогч талууд 9 (a) дүгээр зүйлд заасны дагуу тогтоосон хуваариа харгалзан үзэж тухайн хамрах хүрээг өөрчлөх шийдвэр гаргаж болно гэж ойлгох нь зүйтэй.
5. Дөрвөн жил тутмын тайлан нь чанарын болон тоон мэдээллээр хангах бөгөөд конвенцын 2 дугаар зүйлд тодорхойлсон удирдах зарчмуудад

тулгуурлан соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих ямар бодлого, арга хэмжээг хэрхэн, ямар учраас, хэзээ, хир үр нөлөөтэй нэвтрүүлсэн тухайд дүн шинжилгээ өгөх юм. Түүнчлэн тайлан статисткийн тоо баримт агуулахаас гадна талуудын хуваалцахыг хүссэн арга хэмжээний шилдэг жишээ, түршлагыг аль болох их оруулахыг зорино.

6. Тайланг бэлтгэхдээ талууд соёлын засаглал болон бүтээлч салбарын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхэд конвенцын үр дагавар юу байхыг харгалзан үзэх болно. Талууд тайлангаа бичихдээ соёл урлаг, боловсрол, худалдаа, аж үйлдвэр, аялал жуулчлал, хөдөлмөр, нийгэм-эдийн засгийн хөгжил, санхүү, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, харилцаа холбоо хариуцсан засгийн газрын байгууллагууд болон бусад хамаарал бүхий төрийн байгууллагуудыг оролцуулсан яам хоорондын хамтарсан ажлын хэсгийг байгуулж ажиллахыг дэмжиж байна. Мөн түүнчлэн тайлан бэлтгэхэд бүс нутаг, хотууд зэрэг засгийн газрын шат шатны байгууллагууд хувь нэмрээ оруулах бололцоогоор ханган ажиллахад нь талуудыг дэмжинэ.
7. Хөгжиж буй орнуудад хөнгөлөлттэй нөхцөл олгох тухай конвенцын 16 дугаар зүйлийн Үйл ажиллагааны удирдамжийн дагуу хөгжингүй орнууд нь энэхүү зүйлийн заалтад нийцүүлэн өөрсдийн хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буйгаа тайлбарлан бичнэ. Хариуд нь хөгжиж буй орнууд хэрэгцээг тодорхойлох үнэлгээ хийсэн талаараа танилцуулж, хөнгөлөлттэй нөхцөлөөс өөрсдийн хүртэж буй ашиг тусыг нэмэгдүүлэхээр хэрэгжүүлсэн арга хэмжээгээ тайлагнах болно.
8. Тайлангийн мөчлөг бүрд зориулан бага хурлын оролцогч талууд холбогдох тогтоол шийдвэрээр дамжуулан одоогийн хэрэгжүүлж буй бодлогын асуудлууд хийгээд өөрчлөгдөж буй нөхцөл байдалд тохируулан нэг буюу хэд хэдэн сэдвийг анхаарлын хүрээ болгож болох юм.
9. ЮНЕСКО-ийн Дэлхий нийтээр хүйсийн тэгш байдлыг нэн тэргүүнд тавих хөтөлбөрт нийцүүлэн эмэгтэйчүүдийн соёлын илэрхийллийг хүртэх, түүний бүтээгч, үйлдвэрлэгч байх төдийгүй, нийгмийн соёлын амьдралд оролцох боломжийг нь бүрдүүлэх, хөхиүлэн дэмжих талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг тайланд багтаана.
10. Талууд ЮНЕСКО-оос залуучуудын талаар 2014-2021 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны шинэ стратегийг мөрдлөг болгон соёлын амьдралд залуучуудыг соёлын үйл ажиллагаа, бараа, үйлчилгээний бүтээгч, үйлдвэрлэгч, тэдгээрийн ашиг тусыг хүртэгчийн хувьд оролцох боломжийг нь бүрдүүлэх, урамшуулан дэмжих талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг тайландаа багтаана.
11. Тайлан нь хавсралтаас гадна 30 хуудсаас илүүгүй байна. Тиймээс мэдээлэл нь товч, тодорхой бөгөөд оновчтой байх нь зүйтэй.

Оролцооны үйл явцыг хангах нь

12. Тайлан бэлтгэх явцдаа талууд нийгмийн оролцоо болон мэдээллийн эх сурвалжийн өнөөгийн түвшинг бүхэлд нь олж харах зорилгоор засгийн газрын хийгээд засгийн газрын бус талуудыг оролцуулсан олон талт зөвлөлдөх үүлзалтуудыг зохион байгуулна.

13. Конвенцын 11 дүгээр зүйл болон иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх үйл ажиллагааны удирдамжийг мөрдлөг болгон талууд хамтран зөвшилцөх байдлаар тайлан бэлтгэхдээ иргэний нийгмийн оролцоог хангана. Тайлангийн төсөл боловсруулах явцад иргэний нийгэм ямар хэлбэрээр оролцсоныг тайланд онцолж өгнө.
14. Дөрвөн жил тутмын тайлангийн хүрээнд шаардагдах мэдээ мэдээлэл, тоо баримт цуглуулахдаа талууд орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд тусгай мэргэшсэн байгууллагуудтай хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжинэ.

Тайланг өргөн барих ба түгээн дэлгэрүүлэх

15. Бага хуралд оролцогч талуудын хүсэлтээр Нарийн бичгийн дарга нарын газар талуудыг тайланг өргөн барих хугацаанаас доод тал нь зургаан сарын өмнө дөрвөн жил тутам өгдөг тайландаа бэлтгэх хүсэлт явуулна. Энэ асуудлаар Нарийн бичгийн дарга нарын газар талуудын томилсон холбоо барих хүн/байгууллага болон ЮНЕСКО-ийн Байнгын төлөөлөгчийн газрууд, мөн ЮНЕСКО-ийн Үндэсний комиссууд хандана.
16. Талууд тайлангаа Нарийн бичгийн дарга нарын газарт хорооны аль нэг ажлын хэл дээр (англи эсхүл франц) цаасаар болон электрон хэлбэрээр хүргүүлнэ. Хэрэв боломжтой бол мэдээлэл солилцох зорилгоор талууд бусад нэмэлт хэл дээр өргөн барихыг дэмжинэ.
17. Талуудын тайланг хүлээн авсны дараа Нарийн бичгийн дарга нарын газар тэднийг бүртгэн, хүлээн авснаа мэдэгдэнэ.
18. Нарийн бичгийн дарга нарын газар оролцогч талуудын бага хурлын өмнө зохион байгуулагддаг (тухайлбал, хоёр жил тутам) хуралдаануудын өмнө дөрвөн жил тутмын тайлан болон бусад эх сурвалжаас авсан мэдээ мэдээлэл, тоо баримт дээр тулгуурлан олон улсын ба үндэсний түвшинд конвенцын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тайланг хороонд илгээнэ. Тайланд конвенцыг цаашид хэрэгжүүлэхэд анхаарах харилцан огтлолцож буй асуудлууд болон тулгамдаад буй бэрхшээлүүдийг тодорхойлж өгнө.
19. 22.4 (b) болон 23.6 (c) дугаар зүйлд заасны дагуу дөрвөн жил тутмын тайланг хорооны хурлаар хэлэлцүүлсний дараа оролцогч талуудын бага хуралд хүргүүлнэ. Тайланг хорооноос өгөх санал болон Нарийн бичгийн дарга нарын газрын бэлтгэсэн мониторингийн тайлан дагалдана.
20. Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихтэй холбоотой мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор дөрвөн жил тутмын тайланг хорооны хуралдаанаар авч хэлэлцсэний дараа тус бүрд нь олон нийтэд нээлттэй хүргэнэ.

Холбоо барих хүн/байгууллага

21. Соёрхон баталсны дараагаар талууд үндэсний түвшинд болон Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан олон улсын түвшинд конвенцын талаарх мэдээлэл солилцох үүрэг бүхий холбоо барих хүн/байгууллагыг томилно. Хэрэв холбоо барих хүн/байгууллага өөрчлөгдвөл талууд Нарийн бичгийн дарга нарын газарт нэн даруй мэдэгдэнэ.

22. Холбоо барих хүн/байгууллага нь конвенцын тухай мэдээллийг холбогдох яам болон төрийн байгууллагуудад түгээх харилцаа холбооны суваг болж ажиллана. Холбоо барих хүн/байгууллага нь олон нийтийн зүгээс конвенцын талаар асуусан асуултад хариулт өгөх үүрэгтэй байна.
23. Талууд холбогдох мэдээлэл цуглуулах, засгийн газрын болон засгийн газрын бус эх сурвалжаас ирэх мэдээллийг зохицуулах болон дөрвөн жил тутмын тайланг боловсруулахдаа холбоо барих хүн/байгууллагыг оролцуулна.

Хавсралт

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээний дөрвөн жил тутмын тайлангийн хамрах хүрээ

Бүтэц

Дөрвөн жил тутмын тайлан (цаашид “тайлан” гэх) нь түүнийг бэлтгэхээр томилогдсон хүн/байгууллагад чиглэл өгөх асуултууд бүхий долоон хэсгээс бүрдэнэ. Хуудасны тоог дараах байдлаар хуваарилахыг санал болгож байна.

Хэсэг	Гарчиг	Санал болгож буй хуудасны тоо
	Ерөнхий дүгнэлт	1
	Тусгай мэдээлэл	1
	Соёлын бодлого хэрэгжих орчны тойм	1
1	Соёлын бодлого ба арга хэмжээ	8
2	Олон улсын соёлын хамтын ажиллагаа	3
3	Хөнгөлөлттэй нөхцөл	3
4	Соёл ба тогтвортой хөгжил	3
5	Иргэний нийгмийн оролцоо ба мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх	3
6	Харилцан огтлолцох асуудлууд ба ЮНЕСКО-ийн тэргүүлэх чиглэлүүд	2
7	Хүрсэн ололт амжилт, тулгарч буй бэрхшээл, шийдвэр, цаашид хэрэгжүүлэх алхмууд	2
Хавсралт	Нэмэлт тоо баримт, мэдээ мэдээлэл ба статистик үзүүлэлтүүд	

Тайлан бичих удирдамж

Мэдээ мэдээлэл, тоо баримт цуглуулах болон тайлан бичихдээ дараах удирдамжийг анхааралдаа авах нь зүйтэй. Үүнд:

- (i) тайлангийн хуудасны тоо хавсралтаас гадна 30 хуудсаас илүүгүй байна;
- (ii) түнхагийн шинжтэй мэдэгдлийг тоо баримт, тайлбараар нотлосон байна;
- (iii) төрөл бүрийн эх сурвалжаас авсан мэдээлэл, дүн шинжилгээг жишээгээр баяжуулж өгнө;
- (iv) түүхийг харуулах гэсэн урт тайлбараас зайлсхийнэ.

Тайланг өргөн барих болон гүйцэтгэлийг хянах үйл ажиллагааны аргачлал

Дараах үйл явцыг хичээнгүйлэн дагана. Үүнд:

- (i) Талууд Нарийн бичгийн дарга нарын газраас хугацаат тайлангийн хамрах хүрээ хэмээх баримт бичигт тулгуурлан тайлан бичихэд зориулан боловсруулсан цахим загварыг ашиглан тайлангаа англи эсхүл франц хэл (Хорооны ажлын хэл), мөн боломжтой тохиолдолд бусад хэл дээр боловсруулж өргөн барина;
- (ii) Тайлангийн төгсгөлд талыг төлөөлөн гарын үсэг зурахаар томилогдсон албан тушаалтан гарын үсгээ эх хувилбараар нь зурсан байна;
- (iii) Гарын үсэг зурсан эх хувилбар/уудыг ЮНЕСКО-ийн Соёлын илэрхийллийн олон төрлийн хэлтэст дараах хаягаар илгээнэ. Үүнд: UNESCO, Section of the Diversity of Cultural Expressions, 7, Place Fontenoy 75352 Paris 07 SP, France;
- (iv) Тайланг Нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан загвартай адил цахим хэлбэрээр мөн илгээнэ.

Ерөнхий дүгнэлт

Талууд өөрийн тайлангийн агуулгыг нэг хуудсанд нэгтгэн дүгнэсэн байна. Ерөнхий дүгнэлт нь конвенцыг хэрэгжүүлэхэд хүрсэн гол гол ололт амжилт, тулгарч буй бэрхшээл, ирээдүйн төлөвт онцгой анхааран тайлангийн онцлогийг товойлгон харуулсан байх нь зүйтэй. Энэ нь тайлангийн танилцуулга юмуу агуулгын хураангуйлсан хүснэгт байх ёсгүй.

Дүгнэлтийг конвенцын 22.4 (b) болон 23.6 (c) дугаар зүйлд заасны дагуу хороо болон оролцогч талуудын бага хуралд хүргүүлнэ.

Тусгай мэдээлэл

- (a) Оролцогч талын нэр
- (b) Соёрхон баталсан огноо
- (c) Тайланг бэлдэх үүрэг бүхий байгууллага эсвэл нэгж
- (d) Албан ёсоор томилогдсон холбоо барих хүн/байгууллага
- (e) Тайлан бэлэн болсон огноо
- (f) Тайланд гарын үсэг зурахаар томилогдсон албан тушаалтны нэр
- (g) Тайлан бэлтгэхэд зориулан явуулдаг олон талын оролцоотой зөвлөлдөх үйл явцын тайлбар
- (h) Иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулан тайлан бэлтгэхэд оролцсон талуудын нэрс

Соёлын бодлогын хэрэгжих орчны тойм

Талууд өнөөгийн соёлын бодлогынхоо үндсэн зорилтууд ба тэргүүлэх чиглэлүүд болон тэдгээрийг томъёолох буюу шинэчлэн томъёолоход конвенцын үзүүлэх нөлөөллийг тодорхойлон бичнэ. Түүнчлэн дижитал орчин дахь соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжих боломж, тулгарч буй бэрхшээлийн талаар тайлагнана.

Ингэхдээ тэд дараах асуултад анхаарлаа хандуулах юм. Үүнд: Бодлого боловсруулах үйл явцад конвенцыг дараах арга замуудын аль нэг байдлаар ашиглаж ирэв үү?

- (i) Конвенц нь нэг буюу хэд хэдэн бодлогыг өөрчлөх үндэс мөн (болоод байна);
- (ii) Бодлогын хэлэлцүүлгийг дэмжих хэрэгсэл мөн (болоод байна);
- (iii) Одоо явагдаж буй бодлого боловсруулах үйл явцын лавлах мөн (болоод байна).

1. Соёлын бодлого ба арга хэмжээнүүд

Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр, үндэсний болон бүс нутгийн эсхүл орон нутгийн хэмжээнд соёлын үнэт зүйлийн гинжин хэлхээний өөр өөр шатанд, тухайлбал

- Бүтээл туурвил,
- Үйлдвэрлэл,
- Түгээлт /дэлгэрүүлэлт болон
- Оролцоо/таашаалын түвшинд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд зориулан боловсруулсан бодлого, арга хэмжээнүүдийн талаарх мэдээллээр хангана.

→ 2005 оны конвенцын хүрээнд соёлын биет бус өв хамаарахгүй тул энэ тайланд оруулахгүйг анхаарна уу.

Арга хэмжээ гэдэгт бүтээлч байдлыг өсгөн нэмэгдүүлэх, бие даасан үйлдвэрлэгчид болон түгээгчдэд тохирсон орчин бий болгох төдийгүй соёлын илэрхийллийн олон төрлийг олон нийтэд өргөн хүрээнд хүртээх боломжийг олгох үйл ажиллагаанууд гэж ойлгож болно. Тэдгээр нь захиргааны буюу хууль эрхзүйн, үйл ажиллагааны буюу хөтөлбөрт чиглэсэн, байгууллагын буюу санхүүгийн гэх мэт байж болно. Мөн тусгай нөхцөл байдал болон соёлын илэрхийллийг бүтээгч, үйлдвэрлэгч, түгээгч болох хувь хүн (эмэгтэйчүүд, залуучууд гэх мэт) ба хэсэг бүлэг хүмүүсийн (үндэсний цөөнх, нутгийн уугуул иргэд гэх мэт) хэрэгцээ шаардлагад онцгой анхаарал хандуулна.

Тайланд тусгах арга хэмжээний төрөл зүйлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд 6 дугаар зүйлд заасан «Оролцогч талуудын үндэсний түвшин дэх эрх үүрэг» болон «Соёлын илэрхийллийг дэмжих арга хэмжээ»-ний талаарх 7 дугаар зүйлд баталсан Үйл ажиллагааны удирдамжийг үзнэ үү. Шинэлэг жишээнүүдийн жагсаалтыг конвенцын цахим хуудаснаас үзэж болно.

Энэхүү хэсэгт авч үзэх гол асуултууд нь:

- (a) Арга хэмжээний нэр
- (b) Арга хэмжээний үндсэн зорилтууд юу вэ?
- (c) Арга хэмжээний хамрах хүрээ (орон нутгийн, үндэсний, бүс нутгийн түвшинд), шинж чанар (хууль эрхзүйн, зохицуулалтын, санхүүгийн, институцийн) болон онцлог шинж чанарууд юу вэ?
- (d) Энэхүү арга хэмжээг конвенцын 7 дугаар зүйлд «үндэсний цөөнх болон уугуул иргэдэд харъяалагдах» хэмээн тодорхойлсон хувь хүмүүс (жишээлбэл, эмэгтэйчүүд) болон/эсвэл нийгмийн бүлэгт онцгойлон зориулж байна үү?
- (e) Арга хэмжээг хэрэгжүүлснээр хүлээгдэж буй үр дүн юу вэ?
- (f) Арга хэмжээг ямар байгууллага хариуцан хэрэгжүүлж байгаа болон арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн ямар нөөц хуваарилагдсан бэ?
- (g) Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага болон/эсвэл хувийн салбар оролцсон эсэх?
- (h) Энэхүү арга хэмжээг
 - конвенцын зүйл заалтуудыг хэрэгжүүлэх,
 - конвенцоос үүдэлтэй бодлогын хэлэлцүүлгийг дэмжих/хөгжүүлэх,
 - конвенцод хамааралгүй бусад шалтгаануудыг танилцуулах зорилгоор хэрэгжүүлсэн үү?
- (i) Энэ арга хэмжээний хэрэгжилтийг үнэлсэн үү? Хэрвээ үнэлсэн бол үндсэн дүгнэлт нь юу байв? Үр нөлөөг тодорхойлоход ямар үзүүлэлтүүдийг хэрэглэсэн бэ?

Соёлын үнэт зүйлийн гинжин хэлхээний өөр өөр үе шатанд соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжих зорилгоор батлагдсан арга хэмжээнүүдтэй холбоотой дээр дурдсан (a)-(i) хүртэлх үндсэн асуултуудад хариулна уу.

Та арав хүртэлх тооны үндсэн арга хэмжээнүүдийг тодорхойлж болно.

7. Олон улсын соёлын хамтын ажиллагаа

Энэ хэсгийн зорилго нь олон улсын соёлын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийн талаар тайлагнахад оршино.

Арга хэрэгсэл гэдэгт

- Төрийн албан тушаалтнуудын хоорондын бодлогын асуудлаарх яриа хэлэлцүүлэгт дэмжлэг үзүүлэх;
- Стратегийн болон менежментийн чадавхийг бий болгох зорилго бүхий төрийн өмчийн соёлын байгууллагад ажиллаж буй ажилтнууд хоорондын солилцоог дэмжих;
- Бүтээн туурвих, үйлдвэрлэх чадавхийг бэхжүүлэх зорилго бүхий соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй мэргэжилтнүүд хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэсэн олон улсын соёлын хамтын ажиллагааны хамрах хүрээ, хөтөлбөрийн үйл ажиллагааг ойлгож болно.

Тайланд тусгах арга хэмжээний төрөл зүйлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй бол 12 дугаар зүйл (Олон улсын хамтын ажиллагааг дэмжих)-ийг үзнэ үү. Шинэлэг жишээнүүдийн жагсаалтыг конвенцын цахим хуудаснаас үзэж болно.

Энэхүү хэсэгт авч үзэх гол асуултууд нь:

- Арга хэмжээний нэр
- Арга хэмжээний үндсэн зорилтууд юу вэ?
- Арга хэмжээний хамрах хүрээ (орон нутгийн, үндэсний, бүс нутгийн түвшинд), шинж чанар (хууль эрхзүйн, зохицуулалтын, санхүүгийн, институцийн) болон онцлог шинж чанарууд юу вэ?
- Энэхүү арга хэмжээг конвенцын 7 дугаар зүйлд «үндэсний цөөнх болон уугуул иргэдэд харъяалагдах» хэмээн тодорхойлсон хувь хүмүүс (жишээлбэл, эмэгтэйчүүд) болон/эсвэл нийгмийн бүлэгт онцгойлон зориулж байна уу?
- Арга хэмжээг хэрэгжүүлснээр хүлээгдэж буй үр дүн юу вэ?
- Арга хэмжээг ямар байгууллага хариуцан хэрэгжүүлж байгаа болон арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн ямар нөөц хуваарилагдсан бэ?
- Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн бүс байгууллага болон/эсвэл хувийн хэвшил оролцсон эсэх?
- Энэхүү арга хэмжээг
 - конвенцын зүйл заалтуудыг хэрэгжүүлэх,
 - конвенцоос үүдэлтэй бодлогын хэлэлцүүлгийг дэмжих/хөгжүүлэх,
 - конвенцод хамааралгүй бусад шалтгаануудыг танилцуулах зорилгоор хэрэгжүүлсэн үү?
- Энэ арга хэмжээний хэрэгжилтийг үнэлсэн үү? Хэрвээ үнэлсэн бол үндсэн дүгнэлт нь юу байв? Үр нөлөөг нь тодорхойлохын тулд ямар үзүүлэлтүүдийг хэрэглэсэн бэ?

Соёлын үнэт зүйлийн гинжин хэлхээний өөр өөр үе шатанд соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжих зорилгоор батлагдсан арга хэмжээнүүдтэй холбоотой дээр дурдсан (a)-(i) хүртэлх үндсэн асуултуудад хариулна үү.

Та зургаа хүртэлх тооны үндсэн арга хэмжээнүүдийг тодорхойлж болно.

3. Хөнгөлөлттэй нөхцөл

Энэхүү хэсгийн зорилго нь конвенцын 16 дугаар зүйлд тодорхойлсон хөнгөлөлттэй нөхцөл олгох болон түүний үр шимийг хүртэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн талаар тайлагнахад оршино.

16 дугаар зүйлд зохих хууль эрхзүйн болон институцийн хүрээгээр дамжуулан тухайлбал хөгжиж буй орнуудад эрчимтэй соёлын салбар, илүү өргөн хүрээний, тэнцвэртэй соёлын солилцоо үүсэн бий болоход хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнуудад хөнгөлөлттэй нөхцөл олгохыг тайлбарласан болно. 16 дугаар зүйлд тодорхойлсон хөнгөлөлттэй нөхцөл гэдэгт соёлын болон/эсхүл худалдааны бүрэлдэхүүн хэсгүүдийг аль алиныг оролцуулан ойлгож болно.

Конвенцын хөнгөлөлттэй нөхцөлийн заалт нь хувь хүмүүс (уран бүтээлчид болон соёлын мэргэжилтнүүд), соёлын бараа болон үйлчилгээтэй хамааруулан хөгжингүй орнуудад хөгжиж буй орнуудыг дэмжих үүрэг оноож байна.

Иймд хөнгөлөлттэй нөхцөлийн арга хэмжээнүүдийг дараах гурван түвшинд үр нөлөөгөө үзүүлж буйгаар тайланд тусгаж болно. Үүнд:

- хувь хүний: уран бүтээлчид, соёлын мэргэжилтнүүдийн солилцоо, аялан туршлага судлахыг дэмжих болон тэдний дунд тусгай мэдлэг бий болгох зорилго бүхий хөтөлбөрүүдийг оролцуулан хүний нөөцийг хөгжүүлэх;
- институцийн болон байгууллагын: дэмжлэгийн схем болон хамтран түгээх гэрээ хэлэлцээрүүдийг оролцуулан салбарын эдийн засгийн хийгээд худалдааны хамрах хүрээг дэмжих зорилгоор соёлын үйлдвэрлэл ба байгууллагуудын чадавхийг бий болгох;
- үйлдвэрлэлийн: хоёр талт, бүс нутгийн хийгээд олон талт худалдааны гэрээ хэлэлцээрүүд, соёлын бодлого болон бусад хүрээгээр дамжуулан илүү өргөн хүрээнд харилцаа холбоог бий болгох зэрэг болно.

→ *Тайланд тусгах арга хэмжээнүүдийн хэлбэрүүдийн талаар илүү мэдээлэл хэрэгтэй бол 16 дугаар зүйл (Хөгжиж буй орнуудад зориулсан хөнгөлөлттэй нөхцөл) болон үүнтэй холбогдох Үйл ажиллагааны удирдамжийг үзнэ үү.*

Хөгжингүй орнууд

→ *Энэ дэд хэсгийг хөгжингүй орнуудаас Талуудад хаяглан илгээдэг. Хэрэв танай орон хөгжиж буй орон бол шууд дараагийн дэд хэсэг рүү шилжинэ үү.*

Хөгжингүй орнууд хөгжиж буй орнуудын уран бүтээлчид, соёлын мэргэжилтнүүд төдийгүй соёлын бараа, үйлчилгээнд хөнгөлөлттэй нөхцөлөөр дэмжин туслахаар баталсан арга хэмжээнүүдийнхээ талаар тайландаа өгүүлнэ.

Энэ хэсэгт дараах үндсэн асуултуудад хариулт өгнө. Үүнд:

- (a) Арга хэмжээний нэр
- (b) Арга хэмжээний үндсэн зорилтууд юу вэ?
- (c) Арга хэмжээний хамрах хүрээ (орон нутгийн, үндэсний, бүс нутгийн түвшинд), мөн чанар (хууль эрхзүйн, захиргааны, санхүүгийн, байгууллагын) болон онцлог шинж юу вэ?
- (d) Энэхүү арга хэмжээг онцгойлон конвенцын 7-р зүйлд тодорхойлсноор (үндэсний цөөнх болон уугуул иргэдэд харъяалагдах) эмэгтэйчүүд, нийгмийн бүлэгт зориулж байна уу?
- (e) Арга хэмжээг хэрэгжүүлснээр ямар үр дүн гарч байна вэ?
- (f) Арга хэмжээг ямар байгууллага хариуцан хэрэгжүүлж байгаа болон арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн ямар нөөц хуваарилагдсан бэ?
- (g) Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага эсвэл хувийн хэвшил оролцсон эсэх?
- (h) Энэхүү арга хэмжээг
 - конвенцын зүйл заалтуудыг хэрэгжүүлэх
 - конвенцоос үүдэлтэй буй бодлогын хэлэлцүүлгийг дэмжих/нэмэгдүүлэх
 - конвенцод хамааралгүй бусад шалтгаануудыг танилцуулах зорилгоор хэрэгжүүлсэн үү?
- (i) Энэ арга хэмжээний хэрэгжилтийг үнэлсэн үү? Хэрвээ үнэлсэн бол үндсэн дүгнэлт нь юу байв? Үр нөлөөг нь тодорхойлохын тулд ямар үзүүлэлтүүдийг хэрэглэсэн бэ?
Хөгжиж буй орнуудад зориулсан хөнгөлөлттэй нөхцөлийг дэмжин санхүүжүүлэх зорилгоор баталсан арга хэмжээнүүдийг харгалзан дээрх (a)-(i) хүртэлх үндсэн асуултуудад хариулна уу.

Та зургаа хүртэлх тооны үндсэн арга хэмжээнүүдийг тодорхойлж болно.

Хөгжиж буй орнууд

→ Энэ дэд хэсэг нь хөгжиж буй орнуудад зориулагдсан болно.

16 дугаар зүйлтэй холбогдуулан Үйл ажиллагааны удирдамжид “хөгжиж буй орнуудын хөнгөлөлттэй нөхцөлөөс хүртэх үр шимийг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулсан бодлого, арга хэмжээг боломжтой газар хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжинэ” гэж тусгайлан заасан болно.

Энэ хэсэгт талууд буюу хөгжиж буй орнууд өөрсдийн тэргүүлэх чиглэл, тусгай хэрэгцээ ба сонирголоо тодорхойлох, хөнгөлөлттэй нөхцөлөөс хүртэх үр ашгаа нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийнхээ талаар тайлбарлана. Мөн талууд Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээ тайлагнана.

Энэ хэсэгт дараах үндсэн асуултуудад хариулт өгнө. Үүнд:

- (a) Арга хэмжээний нэр
- (b) Арга хэмжээний үндсэн зорилтууд юу вэ?

- (c) Арга хэмжээний хамрах хүрээ (орон нутгийн, үндэсний, бус нутгийн түвшинд), мөн чанар (хууль эрхзүйн, захиргааны, санхүүгийн, байгууллагын) болон онцлог шинж юу вэ?
- (d) Энэхүү арга хэмжээг онцгойлон конвенцын 7-р зүйлд тодорхойлсноор (үндэсний цөөнх болон уугуул иргэдэд харъяалагдах) эмэгтэйчүүд, нийгмийн бүлэгт зориулж байна уу?
- (e) Арга хэмжээг хэрэгжүүлснээр ямар үр дүн гарч байна вэ?
- (f) Арга хэмжээг ямар байгууллага хариуцан хэрэгжүүлж байгаа болон арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн ямар нөөц хуваарилагдсан бэ?
- (g) Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага болон/эсвэл хувийн сектор оролцсон эсэх?
- (h) Энэхүү арга хэмжээг
 - конвенцын зүйл заалтуудыг хэрэгжүүлэх,
 - конвенцоор дэмжигдэж буй бодлогын хэлэлцүүлгийг дэмжих/нэмэгдүүлэх,
 - конвенцод хамааралгүй бусад шалтгаануудыг танилцуулах зорилгоор хэрэгжүүлсэн үү?

- (j) Энэ арга хэмжээний хэрэгжилтийг үнэлсэн үү? Хэрвээ үнэлсэн бол үндсэн дүгнэлт нь юу байв? Үр нөлөөг нь тодорхойлохын тулд ямар үзүүлэлтүүдийг хэрэглэсэн бэ?
Хөгжиж буй орнуудад зориулсан хөнгөлөлттэй нөхцөлийг дэмжин санхүүжүүлэх зорилгоор баталсан арга хэмжээнүүдийг харгалзан дээрх (a) – (i) хүртэлх үндсэн асуултуудад хариулна уу.

Та зургаа хүртэлх тооны үндсэн арга хэмжээнүүдийг тодорхойлж болно.

4. Соёлыг тогтвортой хөгжлийн бодлогод нэгтгэх нь

Энэ хүрээний 1, 2, 3 дугаар хэсэгт тайлагнасан бодлого ба арга хэмжээнүүдийг харгалзан үзэж талууд соёлыг стратегийн элемент болохын хувьд тогтвортой хөгжлийн бодлогод болон үндэсний хийгээд олон улсын түвшинд тусламжийн хөтөлбөрт нэгтгэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн жагсаалтыг оруулахад нээлттэй.

Ерөнхийдөө эдгээр арга хэмжээг эдийн засгийн өсөлт, хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, нийгмийн оролцоог хариуцсан агентлагууд (үндэсний түвшинд) болон хөгжлийн төлөө хамтын ажиллагааны агентлагууд (олон улсын түвшинд) хэрэгжүүлдэг.

13 дугаар зүйлийн талаарх Үйл ажиллагааны удирдамжид тогтвортой хөгжлийг “хойч үеийн эрэлт хэрэгцээг хангахын тулд авьяас чадварыг нь дутуу үнэлэхгүйгээр өнөөгийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх хөгжил юм” гэж тодорхойлсон байдаг (Хүрээлэн буй орчин болон хөгжлийн талаарх Дэлхийн хорооны илтгэл, 1987).

Иймд тогтвортой хөгжлийн бодлогыг эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгэм болон соёлын асуудал эрхэлсэн холбогдох эрх бүхий байгууллагууд томъёолон боловсруулж, баталж, хэрэгжүүлдэг хэмээн ойлгож болно. Энэ хэсэгт тайлагнах арга хэмжээний харилцан уялдаа бүхий холбоог чухалчилж үзнэ.

4.а. Үндэсний түвшний арга хэмжээнүүд

Дараах зорилго, үр дүнд хүрэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээ тодорхойлно уу. Үүнд:

- соёлыг үндэсний хөгжлийн нэгдсэн төлөвлөлтөд нэгтгэх, тухайлбал, стратеги, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө гэх мэт;
- соёлыг ядуурлыг устгах, нийгмийн оролцоог дээшлүүлэх, боловсрол ба сургалтын стратеги гэх мэтэд нэгтгэснээр нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны үр дүнд хүрэх;
- Нөхцөл бололцоо дутмаг хувь хүмүүс болон нийгмийн бүлгүүдийг (эмэгтэйчүүдийг оролцуулан) соёлын амьдралд оролцуулахын тулд шударга, эрх тэгш байх нөхцөлийг сахин хамгаалах;
- Бүс нутгууд, хот суурин болон хөдөө орон нутгийн хооронд соёлын нөөцийг тэгш хуваарилах асуудлыг хангах зэрэг болно.

→ *Тайланд тусгах арга хэмжээний хэлбэрүүдийн талаар илүү мэдээлэл авах бол 13 дугаар зүйлийн талаарх (Соёлыг тогтвортой хөгжилд нэгтгэх нь) Үйл ажиллагааны удирдамжийг харна уу.*

Энэ хэсэгт дараах үндсэн асуултуудад хариулт өгнө. Үүнд:

- (a) Арга хэмжээний нэр
- (b) Арга хэмжээний үндсэн зорилтууд юу вэ?
- (c) Арга хэмжээний хамрах хүрээ (орон нутгийн, үндэсний, бүс нутгийн түвшинд), мөн чанар (хууль эрхзүйн, захиргааны, санхүүгийн, байгууллагын) болон онцлог шинж юу вэ?
- (d) Энэхүү арга хэмжээг онцгойлон Конвенцын 7-р зүйлд тодорхойлсноор (үндэсний цөөнх болон уугуул иргэдэд харъяалагдах) эмэгтэйчүүд, нийгмийн бүлэгт зориулж байна уу?
- (e) Арга хэмжээг хэрэгжүүлснээр ямар үр дүн гарч байна вэ?
- (f) Арга хэмжээг ямар байгууллага хариуцан хэрэгжүүлж байгаа болон арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн ямар нөөц хуваарилагдсан бэ?
- (g) Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага эсвэл хувийн сектор оролцсон эсэх?
- (h) Энэхүү арга хэмжээг
 - конвенцын зүйл заалтуудыг хэрэгжүүлэх,
 - конвенцоор дэмжигдэж буй бодлогын хэлэлцүүлгийг дэмжих/ нэмэгдүүлэх,
 - конвенцод хамааралгүй бусад шалтгаануудыг танилцуулах зорилгоор хэрэгжүүлсэн үү?

- (i) Энэ арга хэмжээний хэрэгжилтийг үнэлсэн үү? Хэрвээ үнэлсэн бол үндсэн дүгнэлт нь юу байв? Үр нөлөөг нь тодорхойлохын тулд ямар үзүүлэлтүүдийг хэрэглэсэн бэ?

Соёлыг тогтвортой хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд нэгтгэх зорилгоор батлан хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг харгалзан дээрх (a) – (i) хүртэлх үндсэн асуултуудад хариулна уу.

Та зургаа хүртэлх тооны үндсэн арга хэмжээнүүдийг тодорхойлж болно.

4.b. Олон улсын түвшний арга хэмжээ

Хөгжиж буй орнуудад эрчимтэй бүтээлч салбар бий болгохыг дэмжих зорилгоор соёлыг бүс нутгийн/олон улсын хөгжлийн тусламжийн хүрээ, бодлого, хөтөлбөрүүдэд (Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагаа) доорх үйл ажиллагаануудаар дамжуулан нэгтгэж байгааг тодорхойлно уу. Үүнд:

Сургалт, сүлжээ бий болгох, мэдээлэл солилцоогоор дамжуулан бодлогын хөгжил ба бизнес эрхлэлтэд зориулсан хүний нөөцийн болон байгууллагын чадавхийг бэхжүүлэх;

Соёлын үйлдвэрлэлийн ба бизнесийн салбарын технологийн тусгай мэдлэгийг дамжуулах: хэрэгцээнд дүн шинжилгээ хийх, шинэ мэдээлэл харилцааны технологийг хүртэх, шинэ платформуудыг хөгжүүлэх гэх мэт;

Санхүүгийн дэмжлэг: Соёлын олон төрлийг дэмжих олон улсын санд хувь нэмэр оруулах, соёлын салбарыг албан ёсны хөгжлийн тусламжийн төлөвлөлтөд нэгтгэх, соёлын үйлдвэрлэлийн төрийн болон хувийн санхүүжилт хүртэх боломжийг нэмэгдүүлэх, санхүүгийн шинэлэг механизмыг бий болгох гэх мэт.

→ *Тайланд тусгах арга хэмжээний хэлбэрүүдийн талаар илүү мэдээлэл шаардлагатай бол 14 дүгээр зүйлийн (Хөгжлийн төлөө хамтын ажиллагаа) талаарх Үйл ажиллагааны удирдамжийг үзнэ үү.*

Энэ хэсэгт дараах үндсэн асуултуудад хариулт өгнө. Үүнд:

- (a) Арга хэмжээний нэр
- (b) Арга хэмжээний үндсэн зорилтууд юу вэ?
- (c) Арга хэмжээний хамрах хүрээ (орон нутгийн, үндэсний, бүс нутгийн түвшинд), мөн чанар (хууль эрхзүйн, захиргааны, санхүүгийн, байгууллагын) болон онцлог шинж юу вэ?
- (d) Энэхүү арга хэмжээг онцгойлон конвенцын 7-р зүйлд тодорхойлсноор (үндэсний цөөнх болон уугуул иргэдэд харьяалагдах) эмэгтэйчүүд, нийгмийн бүлэгт зориулж байна уу?
- (e) Арга хэмжээг хэрэгжүүлснээр ямар үр дүн гарч байна вэ?
- (f) Арга хэмжээг ямар байгууллага хариуцан хэрэгжүүлж байгаа болон арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн ямар нөөц хуваарилагдсан бэ?

(g) Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага эсвэл хувийн сектор оролцсон эсэх?

(h) Энэхүү арга хэмжээг

- конвенцын зүйл заалтуудыг хэрэгжүүлэх,
- конвенцоор дэмжигдэж буй бодлогын хэлэлцүүлгийг дэмжих/ нэмэгдүүлэх,
- конвенцод хамааралгүй бусад шалтгаануудыг танилцуулах зорилгоор хэрэгжүүлсэн үү?

(i) Энэ арга хэмжээний хэрэгжилтийг үнэлсэн үү? Хэрвээ үнэлсэн бол үндсэн дүгнэлт нь юу байв? Үр нөлөөг нь тодорхойлохын тулд ямар үзүүлэлтүүдийг хэрэглэсэн бэ?

Соёлыг олон улсын хөгжлийн тусламжид нэгтгэх зорилгоор батлан хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг харгалзан дээрх (a) – (i) хүртэлх үндсэн асуултуудад хариулна уу.

Та зургаа хүртэлх тооны үндсэн арга хэмжээнүүдийг тодорхойлж болно.

5. Иргэний нийгмийн оролцоо ба мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх нь

Энэ конвенцын зорилгод нийцүүлэн иргэний нийгэм гэдэгт соёлын болон холбогдох салбар дахь төрийн бус байгууллага, ашгийн төлөө бус байгууллага, мэргэжилтнүүд төдийгүй уран бүтээлчдийн болон соёлын хамт олны ажлыг дэмждэг бүлгийг багтаана. (Иргэний нийгмийн оролцооны талаарх Үйл ажиллагааны удирдамжийн 3 дахь догол мөрийг харна уу)

Талууд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихэд иргэний нийгмийн гүйцэтгэх үндсэн үүргийг хүлээн зөвшөөрч конвенцын зорилтуудыг биелүүлэхийн тулд зохион байгуулсан үйл ажиллагаануудад тэдний идэвхтэй оролцоог дэмжин ажиллах үүрэг аваад байгаа билээ.

Талууд

Энэхүү дэд хэсгийн зорилго нь талууд иргэний нийгмийг өөрсдийн үйл ажиллагаанд татан оролцуулахын тулд юу хийж байгаа болон тэдний оролцоог баталгаажуулахын тулд ямар нөөцөөр хангаж байгаа, мөн ямар үр дүнд хүрээд байгааг тайлагнахад оршино.

Талууд дараах үйл ажиллагаануудад иргэний нийгмийг хэрхэн оролцуулж байгаа талаар мэдээллээр хангана. Үүнд:

- Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх болон бусад үйл ажиллагаагаар дамжуулан конвенцын зорилтуудыг дэмжих;
- Өөрийн нутаг дэвсгэрт болон олон улсын түвшинд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийн талаар мэдээ баримт цуглуулах, мэдээлэл хуваалцах болон солилцох;

- Иргэний нийгмийн санаа бодлыг сонсох болон хэлэлцэж болох орон зайг бий болгох бодлогыг боловсруулах;
- Үйл ажиллагааны удирдамжийг хэрэгжүүлэх гэх мэт.

→ *Тайланд оруулах арга хэмжээний хэлбэрүүдийн талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл 11 дүгээр зүйл (Иргэний нийгмийн оролцоо) болон Үйл ажиллагааны удирдамжийн холбогдох хэсгийг үзнэ үү.*

Иргэний нийгэм

Энэ дэд хэсэг нь конвенцын 11 дүгээр зүйл болон Үйл ажиллагааны удирдамжид заасанчлан конвенцыг хэрэгжүүлэхэд иргэний нийгэм өөрийн үүрэг хариуцлагын хүрээнд юу хийснээ тайлагнахад зориулагдсан болно.

Иргэний нийгэм өөрсдийн хэрэгжүүлж байгаа дараах үйл ажиллагаануудын талаарх мэдээллээр тайланд хувь нэмрээ оруулж болно. Үүнд:

- Өөрийн нутаг дэвсгэрт болон олон улсын түвшинд конвенцын зорилтууд ба зарчмуудыг хөхиүлэн дэмжих;
- Конвенцыг соёрхон батлах болон засгийн газраар дамжуулан хэрэгжүүлэхийг дэмжих;
- Иргэд, холбоод, үйлдвэрүүд, түүний дотор эмэгтэйчүүд болон цөөнхийг оролцуулан эмзэг бүлгийн хүмүүсийн санаа бодлыг төрийн эрх мэдэл бүхий байгууллагуудад хүргэх,
- Соёлын засаглалыг туйлын ил тод, тодорхойлж болохуйц үр дүнд хүргэхэд хувь нэмрээ оруулах;
- Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хөндлөнгөөс хянах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэх мэт;
- Конвенцыг хэрэгжүүлэх болон мэдээ баримт цуглуулахтай холбоотой салбаруудын чадавхийг бэхжүүлэх;
- Дэлхийн өөр бусад бүс нутгийн төрийн болон хувийн салбарууд, иргэний нийгмийн төлөөлүүдтэй шинэлэг хэлбэрийн түншлэлийг бий болгох.

Иргэний нийгэм дараах үйл ажиллагаануудын талаарх мэдээллээ хуваалцахыг эрмэлзэж болно. Үүнд:

- Конвенцыг хэрэгжүүлэх хүрээнд дараагийн дөрвөн жилд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн үйл ажиллагаанууд;
- Тулгараад буй гол асуудлууд болон тэдгээр асуудлаас урьдчилан сэргийлэх болон даван туулах шийдлүүд гэх мэт.

→ *Тайлангийн энэ хэсэгт иргэний нийгмийн ямар байгууллагууд хувь нэмрээ оруулсныг тусгайлан зааж өгнө үү.*

6. Харилцан огтлолцох асуудлууд ба ЮНЕСКО-ийн тэргүүлэх чиглэлүүд

Харилцан огтлолцох асуудлууд

Энэ хэсэгт талууд конвенцын удирдах байгууллагуудын тодорхойлсноор тайлант хугацаанд үүсээд буй харилцан огтлолцох асуудлуудын талаар тайлан бичнэ. Тайланг (а) – (i) хүртэлх үндсэн асуултуудад хариулах байдлаар бичнэ.

Бага хурлын талуудын гаргасан шийдвэр нь тайлангийн дөрвөн жилийн хугацаанд хамаарах харилцан огтлолцох асуудлуудыг тайланд оруулсан эсэхийг шийднэ.

ЮНЕСКО-оос баримтлах Дэлхий нийтийн тэргүүлэх чиглэл: Жендэрийн тэгш байдал

Жендэрийн тэгш байдал бол 2014-2017 оны хөтөлбөрийн болон төсвийн жилүүдэд ЮНЕСКО-оос дэлхий даяар баримтлах тэргүүлэх чиглэл юм. Конвенцын 7 дугаар зүйлд зааснаар талууд «тусгай нөхцөл байдал болон эмэгтэйчүүдийн хэрэгцээнд онцгой анхаарахыг хөхиүлэн дэмжинэ» гэжээ.

Анхаарал хандуулна гэдэг нь эмэгтэйчүүдийг соёлын илэрхийллийг бүтээгч хийгээд үйлдвэрлэгч байх эсвэл иргэдийн хувиар соёлын амьдралд оролцогч байхыг дэмжих зорилго бүхий бодлого, арга хэмжээнүүдийг батлан хэрэгжүүлэхийг хэлнэ. Үүнд хүрэхийн тулд хууль эрхзүйн, хэрэгжүүлэх болон байгууллагын түвшний үйл ажиллагаануудаар дамжуулан нэгдсэн бодлого боловсруулах шаардлага гарч болох юм.

Энэ хэсэгт талууд жендэрийн тэгш байдлыг дэмжих болон эмэгтэйчүүдийг соёлын илэрхийллийг бүтээгч, үйлдвэрлэгч хийгээд түүнээс үр ашиг хүртэгч байхыг дэмжих зорилгоор соёлын салбарт хэрэгжүүлсэн доод тал нь нэг арга хэмжээг тодорхойлох ёстой. Үүний тулд талууд удирдамжийн дагуу (а) – (i) хүртэлх үндсэн асуултуудад хариулт өгөх хэрэгтэй.

ЮНЕСКО-ийн Залуучуудад чиглэсэн үйл ажиллагааны стратеги

Залуу хүмүүсийг чадавхжуулах хийгээд тэднийг конвенцын хэрэгжилтэд оролцуулахыг дэмжих нь ЮНЕСКО-оос 2014-2021 он хүртэл Залуучуудыг дэмжих үйл ажиллагааны стратегитэй нэг чиг шугамд тавигдаж байгаа юм.

Энэ хэсэгт талууд доод тал нь нэг бодлого буюу арга хэмжээг тодорхойлон тайлбарлана. Жишээлбэл:

- соёлын үйл ажиллагаа, бараа, үйлчилгээг бүтээх, үйлдвэрлэх болон тэдгээрээс үр ашиг хүртэхэд залуучуудын оролцоог хөхиүлэн дэмжих;

- залуучууд болон залуучуудын тэргүүлсэн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх болон тэдний санаа бодол, хэрэгцээ шаардлагыг соёлын бодлого боловсруулах үйл явцад нэгтгэхийг дэмжих;
- Соёлын болон бүтээлч үйлдвэрлэлд хэрэгтэй шинэ үр чадварууд, тухайлбал, бизнес эрхлэх, удирдан зохион байгуулах, технологийн үр чадваруудыг бий болгох сургалтын шинэ хөтөлбөр, төлөвлөгөөг дээд боловсролын болон сургалтын байгууллагууд дээр танилцуулах;
- Орон нутгийн хүн амын дунд буй соёлын илэрхийллийн олон төрлийн талаарх мэдээллийг цуглуулах болон түгээхэд залуучуудыг татан оролцуулах.

Үүний тулд удирдамжийн дагуу (a) – (i) хүртэлх үндсэн асуултуудад хариулна уу.

7. Ололт амжилт, сорилт бэрхшээл, шийдлүүд болон дараагийн алхмууд

Тайлангийн энэ хэсэгт талууд болон бусад оролцогч талууд дараах мэдээллийг хуваалцана. Үүнд:

1. Конвенцыг хэрэгжүүлэхэд хүрсэн гол үр дүн;
2. Хэрэгжүүлэлтэд гарч буй болон урьдчилан харж буй үндсэн бэрхшээлүүд;
3. Эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд боловсруулсан шийдлүүд;
4. Конвенц болон энэ хугацааны тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэхийн тулд дараагийн дөрвөн жилд хийхээр төлөвлөж буй алхмууд.

Конвенцын хэрэгжилтийн талаар дөрвөн жил тутмын тайлангаа аль хэдийн хүргүүлчихээд буй талууд өмнөх тайлангаасаа хойших дөрвөн жилийн хугацаанд хүрсэн үр дүн, тулгарсан бэрхшээлүүд болон шийдлүүдээ тодорхой тайлбарлана гэдгийг анхаарна уу.

Нэмэлт тоо баримт, мэдээлэл, статистик

Тайланг статистикийн мэдээллээр хангах нь практик хандлага юм. Энэ нь талуудаас аль болох байгаа хэмжээгээрээ статистик мэдээллээр хангахыг шаарддаг гэсэн үг. Энэ тоо баримт нь үндэсний хэмжээний асуулга, зураглалын судалгаагаар дамжуулан цуглуулсан мэдээлэл байж болно. Тоо баримтыг доорх санал болгож буй эх сурвалжаас олж авч болох юм. Мэдээллийн бүх эх сурвалж болон цуглуулсан/нийтэлсэн жилийг жагсаалтаар оруулна.

1. Эдийн засаг ба санхүү

Энэ хэсэгт тоон мэдээллийг тайлагнахдаа “соёлын салбар”-ыг статистикийн зорилгоор тодорхойлж, тэр тодорхойлолтоо тохируулан ашиглах нь чухал. Зааварчилгаа авах бол дараах холбоосоор орж 2009 оны ЮНЕСКО-ийн Соёлын статистикийн хүрээг ашиглаж болно.

<http://www.uis.unesco.org/culture/Documents/framework-cultural-statistics-culture-2009-en.pdf>

1.1. Соёлын бараа, үйлчилгээний нийт урсгал

Соёлын бараа, үйлчилгээг тодорхойлоход ашигладаг Барааг тодорхойлох,

кодлох үйлдүүлсэн систем (HS) болон Хугацаа хэтэрсэн төлбөрийн тэнцлийн (EBOPS) кодуудын жагсаалт бүхий 2009 оны ЮНЕСКО-ийн Соёлын статистикийн хүрээнээс соёлын бараа, үйлчилгээний тодорхойлолтыг харна уу. Соёлын үйлчилгээний статистикийн талаарх нэмэлт мэдээллийг Олон улсын худалдаа үйлчилгээний статистик гарын авлага <http://unstats.un.org/unsd/tradeserv/TFSITS/manual.htm> -аас олж үзэж болно.

1.1.a Соёлын бараа

- (a) Соёлын барааны экспорт (нийт ... ам.доллар; жил; эх сурвалж)
- (b) Соёлын барааны импорт (нийт ... ам.доллар; жил; эх сурвалж)

1.1.b Соёлын үйлчилгээ

- (a) Соёлын үйлчилгээний экспорт (нийт ... ам.доллар; жил; эх сурвалж)
- (b) Соёлын үйлчилгээний импорт (нийт ... ам.доллар; жил; эх сурвалж)

1.2. Соёлындын Нийт Бүтээгдэдотододыннийэний дыйт урсгал реда оруулжн нийт бүтээгдэх

Аж үйлдвэрийн ангиллын олон улсын стандарт (ISIC)-д хэрэглэгддэг соёлын кодуудын жагсаалтыг 2009 оны ЮНЕСКО-ийн Соёлын статистикийн хүрээнээс харна уу. ДНБ-д соёлын эзлэх хувийг (нэмүү өртөг шингэсэн, орц/гарц гэх мэт) тооцоолохдоо ямар аргагүй ашигласнаа тодорхойлно уу.

- (a) ДНБ (нийт ... ам.доллар; жил; эх сурвалж)
- (b) Соёлын үйл ажиллагааны ДНБ-д эзлэх хувь (хувь; жил; эх сурвалж)

1.3. Засгийн газраас соёлд зарцуулах зардал

- (a) Засгийн газрын нийт зардал (нийт ... ам.доллар; жил; эх сурвалж)
 - (b) Засгийн газрын зардал дахь соёлын зардлын эзлэх хувь (ам.доллар болон засгийн газрын нийт зардлын эзлэх хувь; жил; эх сурвалж)
- Хэрэв соёлын зардал тодорхойгүй байвал засгийн газрын амралт чөлөөт цаг, соёлд зарцуулах зардлыг ашиглана уу.

2. Ном

- (a) Хэвлүүлсэн номын тоо (жил; эх сурвалж)
- (b) Хэвлэлийн компанийн тоо (жил; эх сурвалж):
 - Жижиг (жилд 1-ээс 20 ном)
 - Дунд (жилд 21 - 49 ном)
 - Том (жилд 50 болон түүнээс дээш ном)
- (c) Номын дэлгүүр ба борлуулалт
 - Номын дэлгүүрийн сүлжээ (нийт тоо ба борлуулалт ам.доллар; жил; эх сурвалж)
 - Бие даасан номын дэлгүүр (нийт тоо ба борлуулалт ам.доллар; жил; эх сурвалж)
 - Их дэлгүүрийг оролцуулан жижиглэнгийн худалдааны бүтэц дотор үйл ажиллагаа эрхэлдэг номын дэлгүүр (нийт тоо ба борлуулалт ам.доллар; жил; эх сурвалж)

- Онлайн жижиглэн худалдаа эрхлэгч (нийт тоо ба борлуулалт ам.доллар; жил; эх сурвалж)

(d) Орчуулгын урсгал: хэвлүүлсэн орчуулгын бүтээлийн тоо (жил; эх сурвалж)

3. Хөгжим

(a) Үйлдвэрлэл: Үйлдвэрлэсэн цомогны тоо:

- Биет хэлбэртэй (жил; эх сурвалж)
- Дижитал хэлбэртэй (жил; эх сурвалж)
- Бие даасан (жил; эх сурвалж)
- Үндсэн (жил; эх сурвалж)

(b) Борлуулалт: студид бичүүлсэн хөгжимний борлуулалтын нийт тоо:

- Биет хэлбэртэй, CD болон бусад биет хэлбэрт хуваасан (жил; эх сурвалж)
- Дижитал хэлбэртэй, сингл трак болон дижитал цомгууд (жил; эх сурвалж)

4. Хэвлэл мэдээлэл

Хэвлэл мэдээллийн статистикийн талаарх тодорхойлолт болон мэдээлэл харахыг хүсвэл UIS-ийн Телевиз болон сонины үзүүлэлтүүдийн лавлах номыг <http://www.uis.unesco.org/Communication/Documents/tp10-media-indicators-2013-en.pdf> холбоосоор олж үзэх боломжтой.

(a) Телевизийн үзэгчид болон эзлэх хувь (жил; эх сурвалж)

Хөтөлбөрийн хэлбэр	Үзэгчдийн эзлэх хувь	Эзэмших хэлбэр (Төрийн, хувийн, орон нутгийн)	Хүртэх/үзэх хэлбэр (Төлбөртэй-үнэгүй)
1-р суваг			
2-р суваг			
3-р суваг			
4-р суваг			

(b) Өргөн нэвтрүүлгийн байгууллагууд (жил; эх сурвалж)

Өмчлөлийн хэлбэр	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын тоо			
	Зөвхөн радио сувгууд	Зөвхөн ТВ сувгууд	Радио болон ТВ сувгууд	Бүгд
Төрийн				
Хувийн				
Орон нутгийн				
Тодорхойгүй				
Нийт				

(с) Сонин (жил; эх сурвалж)

Хэвлэлийн формат *	Гарчгийн/ хэвлэлтийн тоо	
	Өдөр тутмын	Өдөр тутмын бус
Хэвлэмэл		
Зөвхөн үнэгүй		
Зөвхөн төлбөртэй		
Үнэгүй болон төлбөртэй аль аль нь		
Хэвлэмэл болон онлайн		
Зөвхөн үнэгүй		
Зөвхөн төлбөртэй		
Үнэгүй болон төлбөртэй аль аль нь		
Нийт		

*Онлайн сонинг оролцуулахгүй

5.Харилцаа холбоо, дэд бүтэц, хүртээмж

- (а) 1000 оршин суугч тутамд ногдох үүрэн утасны хэрэглэгчийн тоо (жил; эх сурвалж)
- (b) Гэртээ интернэт хэрэглэдэг айл өрхийн тоо (жил; эх сурвалж)
- (с) Интернэт хэрэглэдэг хувь хүмүүсийн тоо (жил, эх сурвалж)

6. Соёлын оролцоо

Сүүлийн 12 сарын хугацаанд соёлын үйл ажиллагаанд доод тал нь нэг удаа оролцож байгаа хүмүүсийн эзлэх хувь:

Соёлын оролцоо (хувиар)			
Үйл ажиллагаа	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт
Кинотеатр			
Театр (кабаре, дуурь, хүүхэлдэйн шоууудыг оролцуулан)			
Бүжиг (балетыг оролцуулан)			
Амьд концерт / хөгжмийн тоглолтууд			
Үзэсгэлэн			
Нийт			

Хэрэв боломжтой бол сүүлийн нэг жилийн хугацаанд соёлын үйл ажиллагаанд доод тал нь нэг удаа оролцоогүй шалтгааныг тодруулна.

Оролцоогүй үндсэн шалтгаанууд (хувиар)			
Хэлбэр	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт
Хэтэрхий үнэтэй			
Сонирхолгүй			
Цаг зав бага			
Мэдээлэл дутмаг			
Хэтэрхий хол			

7. Нэмэлт тодруулга

Хэрэв шаардлагатай бол нэмэлт тайлбар болон тодруулгыг өгнө үү.

Боловсрол ба олон нийтийн ойлголт

10 дугаар зүйл. Боловсрол ба олон нийтийн ойлголт

Талууд:

- Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихийн ач холбогдлыг боловсролын болон олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөрөөр дамжуулан өргөн хүрээнд ойлгуулахыг урамшуулан дэмжинэ;
- Конвенцын зүйлд заасан зорилгод хүрэхийн тулд бусад талууд, олон улсын болон бүсийн байгууллагуудтай хамтран ажиллана;
- Соёлын үйлдвэрлэлийн салбарт боловсролын, сургалтын болон солилцооны хөтөлбөрүүдийг боловсруулан бий болгосноор бүтээлч байдлыг дэмжин үйлдвэрлэлийн чадавхийг бэхжүүлэхийн төлөө чармайн ажиллана. Эдгээр арга хэмжээ нь үйлдвэрлэлийн уламжлалт хэлбэрүүдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хэв маягаар хэрэгжүүлэх нь зүйтэй.

Үндсэн зарчим

- Конвенцод нэгдсэн талууд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихийн ач холбогдлыг албан ба албан бус боловсролын хөтөлбөрүүдээр төдийгүй бүх насны хүмүүст зориулсан олон нийтийн дундах үйл ажиллагаануудаар дамжуулан ойлгуулахыг дэмжин, урамшуулах чухал үүргийг хүлээнэ.
- Боловсролын болон олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөрүүд ба арга хэмжээнүүд нь энэхүү конвенцын өвөрмөц онцлогийг тодруулан соёлын салбар дахь ЮНЕСКО-ийн бусад хэм хэмжээ болсон хэрэгслүүдтэй харьцуулан өөрийн онцлогийг гаргаж ирэх ёстой юм.

Боловсролын хэрэгслүүд ба хөтөлбөрүүд

- Талууд тодорхой түвшинд конвенцын зорилтууд болон зарчмуудыг дэмждэг боловсролын хөтөлбөрүүдийг зохион хэрэгжүүлэхэд нийцүүлэн нэгдсэн хандлага бий болгохыг дэмжих нь зүйтэй. Үүнд бодлого, хөтөлбөр, байгууллагын түвшинд соёл ба боловсролын хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх үйл явцыг мөн хамруулах нь зөв юм.

4. Соёлын үйлдвэрлэлийн талбар дахь мэргэжлүүд асар хурдацтай өөрчлөгдөж байна; иймд эдгээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд зориулсан сургалтууд нь энэ өөрчлөлтийг үргэлжлүүлсэн тусгал болон санаачилгад тохируулсан хөтөлбөр байх хэрэгтэй болж байна. Үүний тулд талууд шаардлагатай үр чадварууд ба сургалтын хоосон орон зайг тодорхойлох, ялангуяа дижитал мэдлэг, хөтөлбөр боловсруулах, сургалтын байгууллага ба үйлдвэрлэлийн салбарын хоорондын түншлэлийг бий болгох зэрэг асуудлуудыг хязгаарлалгүйгээр анхааралдаа авах ёстой. Эцэст нь тогтвортой хөгжил болон залуусын хөтөлбөрүүдэд төрийн эрх мэдэл бүхий байгууллагууд, хувийн байгууллагуудтай хамтран ажиллахыг мөн дэмжих нь зүйтэй юм.
5. Сургуулиуд соёлын илэрхийллийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихийн ач холбогдлын талаарх мэдлэг болон мэдээллийг залуухүмүүст дамжуулах чухал орчин юм. Энэ нөхцөлд талууд тодорхой түвшинд бодлого хөтөлбөрүүдийг танилцуулах төдийгүй шаардлагатай эх сурвалжуудыг дараах зорилгоор ашиглахыг дэмжиж болно. Үүнд:
 - (a) Орон нутгийн нөхцөл байдал, соёлд нийцүүлэн боловсруулсан сургуулийн хөтөлбөрт соёлын илэрхийллийн олон төрлийг оруулах;
 - (b) Боловсролын болон сургалтын материалуудыг олон янзаар боловсруулах, тухайлбал, онлайн, ном, CD, видео, баримтат кино, хэвлэмэл танилцуулга, гарын авлага, интерактив тоглоом гэх мэт;
 - (c) Ийм төрлийн материалыг боловсруулах, сургууль болон бусад боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанд оролцуулахаар уран бүтээлчид, соёлын мэргэжилтнүүдийг урих;
 - (d) Соёлын илэрхийллийн олон төрлийн талаарх оюутнуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хэрэгцээтэй үед нь удирдамж, гарын авлага гарган ашиглахад багш нарыг сургах, чадавхийг нь дээшлүүлэх;
 - (e) сургуулиудад соёлын илэрхийллийн олон төрлийн талаар заахад зориулсан сэдэв, загваруудыг санал болгоход насанд хүрэгчид болон эцэг эхчүүдийн холбоодыг татан оролцуулах;
 - (f) соёлын илэрхийллийн олон төрлийн талаарх мэдээллийг өөрийн орон нутгийн хүн амын дунд цуглуулах, түгээхэд залуучуудыг татан оролцуулах;
 - (g) боловсролын оролцооны аргагүй, сургах үйл ажиллагаа болон шавь сургалтыг дэмжих замаар хуримтлагдсан туршлагыг дамжуулах.
6. Дээд боловсролын сургалт, судалгааны байгууллагууд соёлын үйлдвэрлэлийн салбарт хийгээд соёлын бодлогын хөгжилд бүтээлч байдлыг бий болгох, чадавхийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой орчин юм. Энэ утгаараа талууд эдгээр байгууллагууд дээр соёлын үйлдвэрлэлийн болон соёлын бодлогын мэргэжилтнүүдийн дараа үеийн үр чадварыг хөгжүүлэх, аялан туршлага судлахыг идэвхжүүлж байдаг хөтөлбөрүүдийг танилцуулан хэрэгжүүлэхийг дэмжиж болно. Түүнчлэн талууд соёлын бодлого ба үйлдвэрлэлийн салбарт ЮНЕСКО-ийн Тэнхим байгуулах асуудлыг анхаарч үзэж болох юм.

Олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх

7. Талууд нөөц буюу эх үүсвэрийг төрөл бүрийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэрэгслийг олон янзын форматаар боловсруулахад болон шинэ мэдээлэл, харилцаа холбооны технологи, мэдлэг дамжуулах албан бүс хэрэгслүүдийг ашиглахад зориулж болно. Ийм төрлийн хэрэгслийг хөгжүүлэхэд уран бүтээлчид болон соёлын мэргэжилтнүүдийг урин оролцуулж болно.
8. Талууд соёлын илэрхийллийн олон төрлийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх болон мэдээлэл түгээх арга хэмжээ, үйл явдлуудыг дэмжин ажиллана. Тухайлбал, хурал зөвлөгөөн, сургалт семинар, олон нийтийн цуглаанаас гадна үзэсгэлэн, концерт, фестиваль, уралдаан тэмцээн, олон улсын өдрүүдийг зохион байгуулах гэх мэт. Энэ тохиолдолд талууд төрийн болон хувийн хэвшлийн оролцогчид, үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн бүтэц, сүлжээнүүдтэй түншлэх нь зүйтэй.
9. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихийн ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд үр дүнтэй хувь нэмэр оруулж чадна. Талууд хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүхий л төрөл зүйлээр дамжуулан олон төрлийн зорилтот бүлгүүдэд хүрч чадах тусгайлсан хөтөлбөр, кампанит ажлуудыг төлөвлөн гаргахад нь дэмжлэг үзүүлэх ёстой. Энэ салбараар мэргэших соёлын сэтгүүлчдийн сүлжээг бий болгохыг хөхиүлэн дэмжинэ. Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн сүлжээ болон радионууд соёлын илэрхийллийн олон төрлийн талаарх мэдлэгийг дэмжин дэлгэрүүлэхэд төдийгүй шилдэг сайн туршлагын талаарх мэдээллийг хуваалцахад үндсэн үүрэг гүйцэтгэж чадна.

Хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих

10. Талууд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихийн ач холбогдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд бусад засгийн газар хоорондын болон бүс нутгийн байгууллагуудтай нягт хамтын ажиллагаа тогтоохыг дэмжин ажиллана.
11. Талууд өөрсдийн томилсон холбоо барих байгууллага/хүн (конвенцын 9 ба 28 дугаар зүйлүүд) эсвэл Үндэсний комиссоор дамжуулан боловсролын хөтөлбөрүүд болон олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх үйл ажиллагаануудын хэрэгжилтэд хяналт тавих хийгээд тэдгээрийн хоорондын мэдээлэл, шилдэг туршлагыг хуваалцахыг дэмжин ажиллана.

Иргэний нийгмийн үүрэг ба оролцоо

1. Иргэний нийгмийн талаар конвенцод тусгасан хамгийн тодорхой заалт бол 11 дүгээр зүйл юм (Иргэний нийгмийн оролцоо). Иргэний нийгмийн хамаарлыг конвенцын 6, 7, 12, 15, 19 дүгээр зүйлүүдийг оролцуулан бусад хэд хэдэн заалтуудад шууд ба шууд бусаар тусгасан.

2. Зүйл - Иргэний нийгмийн оролцоо

Талууд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих чиглэлд иргэний нийгмийн гүйцэтгэх үндсэн үүргийг хүлээн зөвшөөрнө. Талууд конвенцын зорилтуудад хүрэх өөрсдийн үйл хэрэгтээ иргэний нийгмийн

идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжинэ.

Иргэнийн нийгмийн тодорхойлолт ба үүрэг

3. Конвенцод иргэний нийгэм гэдэг нь соёлын болон бусад туслах салбаруудын төрийн бус байгууллагууд, ашгийн төлөө бус байгууллагууд, мэргэжилтнүүд болон уран бүтээлчид, соёлын салбарынхны ажлыг дэмждэг бүлгүүдийг хэлнэ хэмээн зориудаар тусгасан болно.
4. Иргэний нийгэм нь конвенцын хэрэгжилтэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнд, иргэний нийгэм нь төрийн эрх мэдэлтнүүдэд иргэд, холбоод болон бизнес эрхлэгчдийн санаа бодлыг хүргэж, бодлого, хөтөлбөрүүдэд хөндлөнгөөс хяналт тавин хоточ нохойн үүрэг гүйцэтгэж үнэт зүйлсийг сахин хамгаалагч, шинэчлэгч байгаад зогсохгүй засаглалд ил тод, хариуцлагатай байдлыг авчрахад ихээхэн хувь нэмэр оруулдаг байна.

Конвенцын заалтуудыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн оруулах хувь нэмэр

5. Талууд соёлын бодлого боловсруулах талаарх тохиромжтой хэрэгслүүдтэй хослуулснаар, мөн соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихтэй холбоотой мэдээлэлд хүрэх боломжийг дэмжин энэ салбар дахь чадамжийг бэхжүүлэх үйл явцыг идэвхжүүлснээр конвенцын хэрэгжилтэд иргэний нийгмийг оролцуулахад дэмжлэг үзүүлнэ. Ингэснээр талууд нөхцөл байдалд тохирсон, уян хатан, үр дүнтэй тогтолцоог урьдчилан тооцоолж чадна.
6. Конвенцын хэрэгжилтэд иргэний нийгмийн шинийг санаачлагч, өөрчлөгч талын үүрэг гүйцэтгэх боломжит байдлыг бүрэн ашиглах нь зүйтэй. Иймд талууд иргэний нийгмийг соёлын бодлогыг томъёолоход төдийгүй конвенцын зорилтуудад хүрэхэд туслах соёлыг шинэчлэгч үйл явц, түршлага, хөтөлбөрүүдийг боловсруулахад шинэ санаа, хандлага оруулж ирэхийг нь дэмжин ажиллах хэрэгтэй.

Иргэний нийгмийн оруулах хувь нэмрийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Соёлын бодлогыг шинэчлэн сайжруулах хийгээд хэрэгжүүлэхэд нь талуудад дэмжлэг үзүүлэх;
- конвенцын хэрэгжилттэй холбоотой тусгай салбаруудын чадавхийг бий болгох болон соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах ба хөхиүлэн дэмжих талаарх мэдээ, баримт цуглуулах ажлыг зохион байгуулах;
- Эмэгтэйчүүд, цөөнх, уугуул иргэд гэх мэт нийгмийн бүлгийн дуу хоолойг дэмжсэнээр онцгой соёлын илэрхийллийг хөхиүлэн дэмжих, тэдгээр оролцогчдын тусгай нөхцөл байдал болон хэрэгцээг соёлын бодлогыг томъёолохдоо тусгасан эсэхийг баталгаажуулах;
- Конвенцыг засгийн газрууд өргөн хүрээнд соёрхон батлах болон хэрэгжүүлэхэд нөлөөлөл үзүүлэх, мөн конвенцын зорилтууд болон зарчмуудыг бусад олон улсын форумуудаар дэмжүүлэхэд нь талуудад туслах;

- Талуудад ээлжит тайлангаа гаргахад нь өөрийн чадамжийн хүрээнд хувь нэмэр оруулах. Энэ хувь нэмэр нь иргэний нийгэмд илүү их үүрэг хариуцлагыг авчирч, тайланг боловсруулахад ил тод нээлттэй байхад нь дэмжлэг үзүүлэх болно;
- Дэлхийн өөр бусад бүс нутгийн төрийн болон хувийн хэвшлийн салбартай, мөн иргэний нийгмийн төлөөлөлтэй шинэлэг түншлэл, хамтын ажиллагааг бий болгон хөгжүүлэхэд орон нутгийн, үндэсний хийгээд олон улсын түвшинд хамтран ажиллах (конвенцын 15 дугаар зүйл).

Конвенцын байгууллагуудын ажилд иргэний нийгмийн оруулах хувь нэмэр

7. Иргэний нийгэм нь конвенцын байгууллагуудын ажилд тэдний өөрсдийн тодорхойлсон хэлбэрүүдийн дагуу хувь нэмрээ оруулж дэмжин ажиллана.
8. Хороо нь конвенцын 23(7) дугаар зүйлд заасан тусгай асуудлуудаар төрийн болон хувийн байгууллагуудтай ямар ч үед зөвлөн ажиллана. Ийм тохиолдолд тухайн байгууллага буюу бүлэг нь хорооны хуралдаануудад оролцуулахыг баталсан эсэхээс үл хамааран хороо нь тэднийг өөрийн тусгай хуралдаанд урин оролцуулж болно.
9. Иргэний нийгмийн байгууллагууд талуудын бага хурал болон Засгийн газар хоорондын хорооны хуралдаанд ажиглагчийн статустайгаар оролцох эрхтэйгээс гадна тэдгээрийн үйл ажиллагааны дүрмийн дагуу дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
 - Конвенцын хэрэгжилтэд эерэг хувь нэмэр оруулах зорилгоор шаардлагатай гэж үзвэл байгууллагуудын хуралдаанаас өмнө талуудтай харилцаа тогтооно;
 - Эдгээр байгууллагуудын хуралд оролцох;
 - Тухайн байгууллагын даргын зөвшөөрлөөр үг хэлэх боломжоор хангагдах;
 - Дарга зөвшөөрөл өгсөн тохиолдолд тухайн байгууллагын ажилд холбогдох асуудлаа бичгээр илгээж, конвенцын Нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс мэдээлэл хийх баримт бичиг болгон бүх төлөөлөгч болон ажиглагчдад хүргүүлнэ.
 - Соёлын олон төрлийг дэмжих олон улсын санд оруулах иргэний нийгмийн оролцоо зэрэг болно.
10. Энэ оролцоонд холбогдох зүйлүүдийг сангийн нөөцийг ашиглах тухай үйл ажиллагааны удирдамжийн хүрээнд тодорхойлсон болно.

Хавсралт

Конвенцын байгууллагуудын хуралд иргэний нийгмийн төлөөллүүдийг оролцуулах шалгуур багц

1. Иргэний нийгмийн байгууллагууд эсвэл бүлгүүд дараах шалгууруудыг хангаж байвал конвенцын байгууллагуудын үйл ажиллагааны дүрмээр тогтоосон шалгууруудын дагуу конвенцын байгууллагуудын хуралдаануудад оролцох зөвшөөрөл олгож болно. Үүнд:
 - (a) Конвенцын хамаарах нэг буюу хэд хэдэн салбарыг сонирхож буй болон үйл ажиллагаанд нь оролцдог байх;
 - (b) Бүртгэлтэй улсынхаа хууль, дүрэм журамд нийцсэн эрхзүйн статустай байх;
 - (c) Үйл ажиллагааны тохирох салбарын төлөөлөл байх эсвэл тодорхой нийгмийн болон мэргэжлийн бүлгүүдийн төлөөлөл байх.
2. Бүртгүүлэх хүсэлт нь тухайн байгууллагын буюу бүлгийг албан ёсоор төлөөлөх хүний гарын үсэг бүхий байхаас гадна доорх материалууд дагалдана. Үүнд:
 - (a) Байгууллагын хууль ёсны гэрчилгээний хуулбар;
 - (b) Гишүүдийн жагсаалт эсвэл гишүүнчлэлгүй байгууллага бол (сан гэх мэт) удирдах зөвлөлийн гишүүдийн жагсаалт;
 - (c) Тухайн байгууллагыг ЮНЕСКО-ийн хамрах хүрээний салбаруудын төлөөлөл болохыг илэрхийлж чадах сүүлийн үеийн үйл ажиллагаануудын талаарх товч тайлбар.

Олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих

11 дүгээр зүйл-Олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих

Талууд 8 болон 17 дугаар зүйлд заасан нөхцөл байдлуудад онцгой анхаарал хандуулан соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжихэд нийцсэн нөхцөл байдлыг бий болгохын тулд хоёр талт, бүс нутгийн, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн төлөө дараах зорилтуудыг тавин хичээн ажиллана. Үүнд:

- (a) Соёлын бодлогын асуудлаарх талуудын хоорондын харилцан яриаг идэвхжүүлэх;
- (b) Мэргэжлийн болон олон улсын соёлын солилцоо, шилдэг туршлагаа солилцох үйл явцаар дамжуулан соёлын салбарын төрийн байгууллагуудын стратегийн ба менежментийн чадавхийг өсгөн нэмэгдүүлэх;
- (c) Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг хөхиүлэн дэмжих ба хөгжүүлэхэд иргэний нийгэм, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийнхний түншлэлийг идэвхжүүлэх;
- (d) Шинэ технологийн хэрэглээг дэмжих, мэдээлэл хуваалцах хийгээд

соёлын ойлголцлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн түншлэлийг бэхжүүлэх, соёлын илэрхийллийн олон төрлийг дэмжин хөгжүүлэх;

- (е) Хамтран бүтээн туурвих болон түгээн дэлгэрүүлэх гэрээ хэлэлцээрүүдийн үр дүнг дүгнэхийг хөхиүлэн дэмжих зэрэг болно.

Тогтвортой хөгжил дэх соёлын асуудал

13 дугаар зүйл - Соёлыг тогтвортой хөгжлийн бодлогод нэгтгэх

Талууд тогтвортой хөгжилд таатай нөлөө үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх бүхий л шатны хөгжлийн бодлогод соёлын асуудлыг нэгтгэхийг эрмэлзэх, мөн соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихтэй холбоотой асуудлуудыг дэмжих нь зүйтэй.

Үндсэн зарчмууд

1. Тогтвортой хөгжил гэдэг нь “хойч үеийн эрэлт хэрэгцээг хангахын тулд тэдний авьяас чадварыг нь дутуу үнэлэхгүйгээр өнөөгийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх хөгжил юм” (Хүрээлэн буй орчин, хөгжлийн асуудал эрхэлсэн Дэлхийн хорооны тайлан илтгэл, 1987).
2. Тогтвортой хөгжлийн эдийн засаг, соёл, нийгэм, хүрээлэн буй орчны асуудлууд хоорондоо харилцан хамааралтай.
3. Соёлын олон төрөл зүйлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хадгалж үлдэх нь нийгэм, соёлын байдал, хувь хүн, хамт олны сайн сайхан оршин тогтнох, соёл, соёлын байгууллагуудын бат бэх, бүтээлч байдлыг хадгалж үлдэхэд ихээхэн үүрэгтэй учраас өнөөгийн болоод ирээдүй хойч үеийнхэнд үр өгөөжтэй байх тогтвортой хөгжилд нэн чухал шаардлага (конвенцын 2.6 дугаар зүйл) билээ.
4. Соёлын илэрхийллийн олон төрлийг хөгжлийн үйл явц дотор авч үзэх учиртай. Энэ нь харилцан уялдаатай, өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой нийгмийг бэхжүүлэх, бүхий л соёлыг хүндэтгэн, эн тэнцүү авч үзэх бүхнийг хамарсан нийгмийг бий болгоход хувь нэмрээ оруулж байдаг.
5. Хүний хөгжлийн зорилгод хүрэх, ядуурлыг мэдэгдэхүйц бууруулахын тулд соёлыг үндэсний хэмжээний бодлого, төлөвлөгөө болон олон улсын хамтын ажиллагааны стратегид нэгтгэж үзэх хэрэгтэй.
6. Бүх түвшний хөгжлийн бодлогод (орон нутгийн, үндэсний, бүсийн, олон улсын) соёлыг нэгтгэж үзсэнээр дараах зүйлс боломжтой болох юм.
 - 6.1 Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд хувь нэмрээ оруулах;
 - 6.2 Соёлын илэрхийллийг бүтээх, бий болгоход дэлхий нийтийн, ялангуяа эмзэг бүлгүүдийн сонирхол, оролцоо, хүртэх эрхийг дэмжих;
 - 6.3 Соёлын илэрхийллийг бүтээх, бий болгох, түгээх, дэлгэрүүлэх замаар тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлт, зохистой амьдралын чанарыг

бий болгоход соёлын үйлдвэрлэлийн хувь нэмэр, чадавхийг бүрэн дүүрэн ойлгож үнэлэх;

- 6.4 Нийгэм дэх залуучуудын оролцоог идэвхжүүлэх, энх тайван оршин тогтнох соёл болон хүний эрхийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн соёлын үйл ажиллагаагаар дамжуулан нийгмийн нэгдэл нягтралыг хадгалах, хүчирхийлэлтэй тэмцэх;
- 6.5 Хот төлөвлөлт, аюулгүй байдал, олон нийтийн эрүүл мэнд, аялал жуулчлал, боловсролын салбар дахь хөгжлийн бодлогыг сайжруулах, идэвхжүүлэх.

Удирдамж

- 7. Тогтвортой хөгжил гэдэг нь орон нутгийн соёлын экосистемийн зохицлыг хадгалж үлдэхэд чиглэсэн орон нутгийн болон үндэсний хэмжээний агуулгад нийцсэн бодлого, арга хэмжээнүүдийг цуглуулсны үр дүн юм. Хөгжлийн бодлогыг уялдаа холбоотой, өөрийн болгож эзэмшихийн тулд үг бодлогыг боловсруулахдаа талууд дараах зүйлсийг анхаарч, тооцоолох хэрэгтэй.
 - 7.1 Эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгэм, соёлын тогтолцоо нь хоорондоо харилцан хамааралтай, бие биенээс нь салгаж үл болох зүйлс учраас тогтвортой хөгжлийн бодлогыг төрийн эрх бүхий холбогдох байгууллага, салбар, түвшинд боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ. Тийм ч учраас үр өгөөжтэй зохицуулалтын механизмыг ялангуяа үндэсний түвшинд бий болгох хэрэгтэй.
 - 7.2 Хөгжлийн бодлого дахь соёлын хүрээний ач холбогдлын талаарх ойлголтыг шийдвэр гаргагчид болон тэдний хамтрагчдын дунд өсгөн нэмэгдүүлэх, бусад салбарын хөгжлийн бодлого хариуцсан менежерүүдийн соёлын асуудалд илүү нарийн хандах мэдрэмжийг бий болгох зэрэг нь 13 дугаар зүйлд тусгагдсан зорилгод хүрэхэд нэн чухал юм.
 - 7.3 Тогтвортой хөгжлийн бодлогод соёлыг нэгтгэх нь дараах үр дүнг хүлээн зөвшөөрөхөд хүргэнэ. Үүнд:
 - 7.3.1 Соёлын олон төрөл болон илэрхийллийг ойлгох, таатайгаар хүлээн авахыг дэмжих зорилго бүхий боловсролыг түгээх өөр өөр талын асуудлуудыг хамаарах соёлын хамаарал, тогтвортой хөгжил дэх боловсролын үндсэн үүрэг,
 - 7.3.2 Конвенцын 7 дугаар зүйлд дурдсан нийгмийн янз бүрийн бүлгүүд, эмэгтэйчүүд, газар зүйн таагүй нөхцөлтэй бүс нутгуудын эрэлт хэрэгцээг тогтоох;
 - 7.3.3 Шинэ технологи ашиглалт, сүлжээнд холбогдсон харилцааны системүүдийн цар хүрээг тэлэх.

Соёлын илэрхийллийн олон төрлийг тогтвортой хөгжилд нэгтгэн үзэхтэй холбоотой арга хэмжээ

8. Соёлын илэрхийллийн олон төрлийг тогтвортой хөгжлийн бодлогын нэгэн хэсэг болгон хөхиүлэн дэмжих, хамгаалахтай холбоотой асуудлуудыг нэгтгэх, дэмжих зорилгоор талуудад дараах байдлаар дэмжлэг үзүүлэх:
 - 8.1 Урлагийн салбарын бүхий л уран бүтээлч, мэргэжилтэн, дадлагажигч нарын эрэлт хэрэгцээг тооцоолон үзэж, дэмжин хөгжүүлэх, бүтээлч авьяас чадварыг шаардлагатай нөхцөлөөр хангах. Ингэхдээ газар зүйн таагүй нөхцөлтэй бүс нутгууд дахь хувь хүн, нийгмийн бүлэг, эмэгтэйчүүдийн эрэлт хэрэгцээг онцгойлон анхаарах;
 - 8.2 Хэрэгжих боломжтой соёлын үйлдвэрлэлүүд, нэн ялангуяа орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулж буй бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжин хөгжүүлэх,
 - 8.3 Хэрэгжих боломжтой соёлын үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай хууль эрх зүйн хүрээллийг бий болгох, дэд бүтэц, байгууллагуудад урт хугацааны хөрөнгө оруулалт оруулахыг дэмжих;
 - 8.4 Орон нутгийн засаг захиргаа, тэдний хамтрагч, орон нутгийн хувьцаа эзэмшигч, нийгмийн янз бүрийн хэсгүүдийг энэ талаар илүү их ойлголттой болгох, мөн тогтвортой хөгжлөөс урган гарсан сорил, соёлын цар хүрээг тооцон үзэхийн ач холбогдолыг ойлгуулах;
 - 8.5 Санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар орон нутгийн түвшний соёлын байгууллагуудад техникийн, төсвийн, хүний нөөцийн тогтвортой чадавхийг бий болгох;
 - 8.6 Ялангуяа эмэгтэйчүүд, залуучууд, эмзэг бүлгийнхэнд чиглэсэн соёлын бараа бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, үйлчилгээг бүтээх, бий болгохыг тууштай, адил тэнцүү, дэлхий нийтийн хэмжээнд дэмжих;
 - 8.7 Соёлын илэрхийллийн олон төрөлтэй холбоотой асуудал эрхэлсэн төрийн байгууллага болон соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, бий болгох, түгээх, дэлгэрүүлэх үүрэг бүхий соёлын салбарын төлөөлөгчид, иргэний нийгэм зэргийг хамруулах, харилцан зөвлөлдөх;
 - 8.8 Соёлын салбартай холбоотой арга хэмжээ, хөгжлийн бодлогыг тодорхойлох, боловсруулах, хэрэгжүүлэхэд иргэний нийгмийг татан оролцуулах.
9. Тогтвортой хөгжил дэх соёлын үүргийг илүү сайн үнэлэхийн тулд статистикийн үзүүлэлтийг боловсронгуй болгох, мэдээллээ солилцдог болох, шилдэг туршлагаа хуваалцдаг, дэлгэрүүлдэг болох зэрэгт талуудыг дэмжин ажиллана.

Хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа

14 дүгээр зүйл. Хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа

Талууд тогтвортой хөгжил болон ядуурлыг бууруулах, ялангуяа хөгжиж буй орнуудын онцгой хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд эрчимтэй хөгжих соёлын салбарыг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах замаар хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийг эрмэлзэнэ.

- (a) Хөгжиж буй улс орнууд дахь соёлын үйлдвэрлэлийг дараах байдлаар бэхжүүлэх:
- (i) Хөгжиж буй улс орнуудад соёлын үйлдвэрлэл, түгээлтийн чадавхийг бий болгон бэхжүүлэх;
 - (ii) Тэдгээрийн соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг дэлхийн зах зээл болон олон улсын худалдааны сүлжээнд илүү өргөнөөр нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх;
 - (iii) Орон нутгийн болон бүс нутгийн хэрэгжих боломжтой зах зээлийг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх;
 - (iv) Хөгжиж буй орнуудын соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрсдийн нутаг дэвсгэрт оруулахыг дэмжих зорилгоор хөгжингүй орнууд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
 - (v) Хөгжиж буй орнуудын уран бүтээлчдийн бүтээн түүрвix үйл ажиллагааг дэмжин, тэдний шилжилт хөдөлгөөнд бололцооны хирээр дэмжлэг үзүүлэх;
 - (vi) Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хоорондын хамтын ажиллагаа, ялангуяа хөгжим, кино урлагийн салбарын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих.
- (b) Мэдээлэл, түршлага, тусгай мэдлэг солилцох замаар чадавхийг бэхжүүлэх, түүнчлэн хөгжиж буй орнуудын төрийн болон хувийн хэвшлийн салбарт, ялангуяа стратегийн болон удирдлагын чадавх, бодлого боловсруулалт, хэрэгжүүлэлт, соёлын илэрхийллийг хөхиүлэн дэмжих, түгээх, жижиг, дунд, бичил үйлдвэрийг хөгжүүлэх, технологи ашиглах, үр чадварыг хөгжүүлэх, дамжуулах чиглэлээр боловсон хүчин бэлтгэх;
- (c) Хөшүүрэг болох зохих арга хэмжээг хэрэгжүүлэх замаар технологи болон нөү-хауг нэвтрүүлэх, ялангуяа соёлын үйлдвэрлэл, хувийн хэвшлийн салбарт оруулж ирэх;
- (d) Дараах хэлбэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх:
- (i) 18 дугаар зүйлд заасны дагуу Соёлын олон төрлийг хамгаалах олон улсын сан байгуулах;
 - (ii) Шаардлагатай тохиолдолд хөгжлийн албан ёсны тусламж олгох бөгөөд үүнд бүтээн түүрвix үйл ажиллагааг урамшуулан дэмжихэд чиглэгдсэн техникийн туслалцааг оруулна;
 - (iii) Бага хүүтэй зээл, мөнгөн тэтгэмж, болон санхүүжилтийн бусад механизм зэрэг санхүүгийн тусламжийн бусад хэлбэрүүд.

Хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа: хамрах хүрээ, зорилго

1. Соёлын илэрхийллийн олон төрлийг харгалзан хөгжиж буй орнуудын тусгай эрэлт хэрэгцээнд хариу болгох, соёл, хөгжил хоёрын хоорондын холбоог бэхжүүлэх, соёлын салбарын шилжилт хөдөлгөөнийг дэмжих зэрэгт чиглэгдсэн арга зам, арга хэмжээнүүдийн жишиг жагсаалтыг 14 дүгээр бүлэгт дэлгэн үзүүлээ.
 - соёлын үйлдвэрлэлийг бэхжүүлэх зорилго бүхий арга хэмжээнүүд;
 - чадавх бүрдүүлэх хөтөлбөрүүд;
 - технологи нэвтрүүлэлт;
 - санхүүгийн дэмжлэг.
2. Талууд 14, 16 (Хөгжиж буй орнуудад зориулсан хөнгөлөлттэй нөхцөл) болон 18 дугаар зүйл (Соёлын олон төрөл зүйлийг хамаалах олон улсын сан)-д өгөгдсөн холбоосуудыг харгалзан эдгээр гурван зүйлийн үйл ажиллагааны зааварчилгааг уялдаа холбоотойгоор тохируулан ашиглах хэрэгтэй.
3. Хөгжиж буй орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд конвенцын 15 дугаар зүйлд заасанчлан түншлэлийг хөгжүүлэх, 16 дугаар зүйлд тусгагдсан хөнгөлөлттэй нөхцөл үзүүлэх зэрэг заалтаар талуудыг урамшуулан дэмжинэ.
4. Соёлын олон төрлийг хамгаалах олон улсын сангийн (18 дугаар зүйл) ач холбогдлыг талууд хөгжиж буй орнуудын соёлын илэрхийллийн олон төрлийг хөгжүүлэх, дэмжих олон талт хэрэгсэл хэмээн үздэг хэдий ч уг сан эдгээр орнуудад дэмжлэг үзүүлэх хоёр талын болон бүс нутгийн хэмжээний арга хэрэгсэл, арга хэмжээ байх үүрэг хүлээхгүй.

Чиг хандлага, арга хэмжээ

5. Хөгжиж буй орнууд соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжих, хамгаалахтай холбоотой өөрсдийн эн тэргүүнд авч үзэх зүйл, онцгой хэрэгцээ, сонирхлоо тодорхойлох, олон улсын хамтын ажиллагааг оновчтой болгохын тулд үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллах талаар хүчин чармайлт гаргана.
6. Талууд болон холбогдох түншүүдийн хоорондын хөгжлийн төлөөх хамтын ажиллагаанд 14 дүгээр зүйлд тусгасан хэлбэрүүдийг авч үзэж болох бөгөөд хөгжиж буй улс орнуудад соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, бий болгох, түгээх/дэлгэрүүлэхэд таатай орчин бий болгохыг дэмжих нь зүйтэй. 6.1 – 6.5 хүртэлх хэсгүүдэд энэ утгаар авч хэрэгжүүлж болох арга хэмжээнүүдийн жишиг жагсаалтыг үзүүлээ.

Дараах чиглэлийн арга хэмжээг бүрдүүлж байгаа зүйлс нь:

6.1 Хөгжиж буй орнуудад соёлын үйлдвэрлэлийг бэхжүүлэх

- 6.1.1 Орон нутгийн, үндэсний, бүс нутгийн түвшинд соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, бий болгох, түгээх, дэлгэрүүлэх чиглэлд бүтцийн, зохицуулалтын, хууль эрх зүйн, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр дэмжин туслах механизмыг бий болгох, сайжруулах;

6.1.2 Соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортод гаргахад чиглэсэн стратеги боловсруулахыг дэмжихийн зэрэгцээ орон нутгийн хувийн хэвшлийг бэхжүүлэх, соёлын салбарын уран бүтээлч, мэргэжилтэн, дадлагажигч нарт хүрэх үр өгөөжийг нэмэгдүүлэх;

6.1.3 Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын хоорондын соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний солилцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, улмаар орон нутгийн, үндэсний, бүсийн, олон улсын түвшинд түгээлтийн сүлжээ, тогтолцоог дэмжин нэмэгдүүлэх;

6.1.4 Орон нутгийн болон бүсийн соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгжих боломжтой зах зээлд дэмжлэг үзүүлэх, үүнийг ялангуяа, зохицуулах ажиллагаа, соёлын хамтын ажиллагааны хөтөлбөр, үйл ажиллагаа, мөн соёлын бодлогын хүрээнд нийгмийг хамруулах, ядуурлыг бууруулах бодлогоор дамжуулан хэрэгжүүлэх;

6.1.5 Хөгжиж буй орнуудын уран бүтээлч, соёлын мэргэжилтэн, дадлагажигч нарын шилжилт хөдөлгөөн, тэднийг хөгжиж буй болон хөгжингүй улс орнуудын газар нутагт нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх, ийм солилцоог хэрэгжүүлэхийн тулд хөгжиж буй болон хөгжингүй орнуудын аль алинд нь уян хатан, богино хугацааны виз гаргах бодлого баримтлах;

6.1.6 Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын хооронд хамтарсан үйлдвэрлэл, хамтарсан түгээлтийн хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлэх, улмаар хамтарсан үйлдвэрлэлд зориулсан зах зээл бий болгох.

6.2 Мэдээлэл солилцох ба сургалтаар дамжуулан чадавхийг бий болгох

6.2.1 Соёлын солилцоо, сүлжээд, чадавхийг бий болгох хөтөлбөрөөр дамжуулан хөгжиж буй, хөгжингүй улс орнуудын соёлын салбарын янз бүрийн хэсэгт ажиллаж буй төрийн эрх мэдэлтнүүд болон соёлын салбарт хамаарах уран бүтээлч, мэргэжилтэн, дадлагажигч нарын хооронд гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх;

6.2.2 Хувьсан өөрчлөгдөж буй мэдээлэл, харилцааны технологийг сурталчлах, түгээх механизмын шинэ хэлбэр, бизнесийн шинэ загварын талаарх мэдээллийн солилцоог дэмжих;

6.2.3 Удирдлага, маркетинг, санхүүгийн чадварыг боловсронгуй болгох замаар соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдийн бизнесийн болон зохион байгуулах чадварыг нэмэгдүүлэх.

6.3 Соёлын үйлдвэрлэл, хувийн хэвшлийн салбарт технологи нэвтрүүлэхэд дараах зүйлсийг хийнэ

6.3.1 Олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан бодит нөөц, үр чадварын аль алиныг нь хөгжүүлэн, технологийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэхэд байнгын тооцоолол хийх. Мөн хөгжиж буй орнуудад технологи нэвтрүүлэх шударга, таатай нөхцөл байдлаар хангах;

6.3.2 Үйлдвэрлэх, түгээх, дэлгэрүүлэх, энэ хэрэгцээ шаардлагыг дэмжин тэтгэхэд мэдээлэл, харилцааны шинэ технологи нэвтрүүлэх;

6.3.3 Соёлын салбарын төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтэн, мэдээлэл харилцааны технологийн шинжээчдийг тогтмол солилцох, харилцаатай байхад дэмжлэг үзүүлэх;

6.3.4 Хөгжиж буй орнуудад үр өгөөжтэй байх технологийн хамтарсан хөгжил дэвшлийг нэвтрүүлэх талаар зохих арга хэмжээ авах.

6.4 Санхүүгийн дэмжлэг

6.4.1 Хөгжлийн албан ёсны тусламж үзүүлэх төлөвлөгөөнд соёлын салбарыг нэгтгэх;

6.4.2 Бичил, жижиг, дунд хэмжээний аж ахуйн нэгж, соёлын үйлдвэрлэл, соёлын салбарын дадлагажигч, уран бүтээлч, мэргэжилтэн нарыг төрийн болон хувийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэхэд оролцуулах, ингэхдээ мөнгөн тэтгэмж, бага хүүтэй зээл, бичил зээл олгох, санхүүгийн баталгаа гаргах, техникийн туслалцаа үзүүлэх, татварын хөнгөлөлт олгох зэрэг арга хэмжээ авах;

6.4.3 Технологийн инноваци, соёлын салбарын хөгжилд хувийн хэвшлүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор татварын урамшуулал олгох гэх мэт арга хэмжээ авч талуудыг урамшуулан дэмжих.

Нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг

7. Хөгжлийн төлөөх хамтын ажиллагаатай холбоотой ЮНЕСКО-ийн үүргийг харгалзан талууд 14 дүгээр зүйлд заасан заалтуудыг дагах, хэрэгжүүлэхийг дэмжиж ажиллахыг Нарийн бичгийн дарга нарын газраас хүсэх. Талуудад үр өгөөжтэй байх хөгжлийн төлөөх хамтын ажиллагааны шилдэг туршлагын талаарх мэдээ мэдээлэл цуглуулахад дэмжлэг үзүүлэхийг хүсэх мөн багтана.

Түншлэлийн загвар

1. Түншлэлтэй холбоотой конвенцын хамгийн тодорхой заалт бол 15 дугаар зүйл юм (Хамтын зохицуулалт). Түншлэлтэй хамааралтай асуудлыг конвенцын бусад заалт, ялангуяа 12 дугаар зүйл (Олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих)-д шууд буюу шууд бусаар тусгасан.

2. 15 дугаар зүйл. Хамтын хэлэлцээрүүд

Талууд хөгжиж буй орнуудын соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чадавхийг бэхжүүлэхэд хамтран ажиллах зорилгоор төрийн, хувийн хэвшлийн болон ашгийн бус байгууллагуудын хоорондын түншлэлийг хөгжүүлэхийг хөхиүлэн дэмжинэ. Түншлэлийн эдгээр шинэлэг хэлбэрүүд нь хөгжиж буй орнуудын бодит хэрэгцээ шаардлагыг харгалзан дэд бүтэц, хүний нөөц, бодлогын цаашдын хөгжил, түүнчлэн соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний солилцоонд анхаарал тавина.

Түншлэлийн тодорхойлолт, онцлог шинж

3. Түншлэл гэдэг нь төрийн албаны (орон нутгийн болон үндэсний түвшинд) болон бусад (бус нутгийн болон олон улсын түвшинд) удирдлагууд, иргэний нийгэм гэх мэт нийгмийн янз бүрийн давхаргаас гаралтай хоёр болон түүнээс дээш байгууллага хоорондын хамтын ажиллагааны сайн дурын хэлцэл юм. Иргэний нийгэм гэдэгт хувийн салбар, хэвлэл мэдээлэл, академийн

байгууллага, уран бүтээлч, уран бүтээлийн баг зэрэг багтана. Түншлэгч талууд эрсдэл, үр ашгийн аль алинийг нь харилцан тэгш хүртэх бөгөөд шийдвэр гаргах, нөөц баялгийг хуваарилах гэх мэт үйл ажиллагааны загварыг талууд харилцан зөвшилцөж тохирдог.

4. Түншлэлийг амжилттай хэрэгжүүлэх гол зарчим нь харилцан тэгш эрхтэй байх, ил тод байх, харилцан ашигтай байх, үүрэг хариуцлагатай байх, харилцан хөгжиж дэвждэг байх явдал юм.

Түншлэлийн зорилго, хамрах хүрээ

5. Түншлэл нь дараах зорилгуудыг хэрэгжүүлэхийг эрмэлзэн нэмүү өртөг шингэсэн үйл ажиллагаа явуулахыг зорьдог ч үүгээр хязгаарлагддаггүй:
 - 5.1 Соёлын чиглэлийн төрийн албан хаагч, мэргэжилтнүүд болон холбогдох салбаруудыг чадваржуулах;
 - 5.2 Соёлын мэргэжилтэн, дадлагажигч, холбогдох салбаруудад чиглэсэн байгууллага байгуулах;
 - 5.3 Соёлын бодлого боловсруулах, сурталчлан таниулах;
 - 5.4 Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихийг гол чиг шугамаа болгох, дэмжлэг үзүүлэх;
 - 5.5 Конвенцын 8 дугаар зүйлд заасанчлан эрсдэлд орсон хэмээн үзэж буй соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, соёлын илэрхийллийг хамгаалах;
 - 5.6 Орон нутгийн, үндэсний, бүс нутгийн зах зээлийг бий болгох, тэтгэх;
 - 5.7 Соёлын солилцоо, соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалыг дэмжин зохих тусламж үзүүлэх, олон улсын зах зээлд нэвтрүүлэх.
6. 15 дугаар зүйлд заасны дагуу энэхүү конвенцын хүрээнд явагдаж буй түншлэл нь конвенцын талууд болох хөгжиж буй орнуудын эрх ашигт нийцсэн байна.
 - 6.1 Хөгжиж буй орнуудын эрх ашгийг хүндэтгэн үзсэн энэхүү хамтын хэлэлцээрийг цаашид хэвээр хадгалахын тулд холбогдох соёлын үйлдвэрлэл, салбарын хувьцаа эзэмшигчидтэй хэлэлцэн зөвшилцөж, эдгээр хэрэгцээ шаардлагадаа хэтийг харсан дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд соёлын илэрхийлэл, талбарыг танин тогтоох зорилгоор үндэсний, бүс нутгийн, олон улсын түншүүдтэй хамтран ажиллахад анхаарах;
 - 6.2 Хэрэгцээ шаардлагыг үнэлэх үнэлгээнд задлан шинжлэх, статистик, чанарын мэдээллүүд багтах бөгөөд үүнийг үнэлэн дүгнэснээр эн тэргүүний чухал зүйлээ голлон анхаарсан стратеги боловсруулж, зорилгоо тодорхойлон, зохих хяналт хийх боломж олгодог.
 - 6.3 Түншлэл нь төрийн салбар нэгж болон төрийн бус байгууллага, ашгийн бус байгууллага, хувийн салбар зэрэг иргэний нийгэм дунд бодитойгоор орших, оршин байх боломжтой бүтэц, сүлжээдийг бий болгоход аль болох анхаарах нь зүйтэй.

Түншлэх үйл явц

7. Түншлэл байгуулахад дөрвөн үе шатыг дамждаг. Үүнд:
 - 7.1 Харилцаа холбоо тогтоох, үүсгэх: Талууд хөгжил дэвшил, хөрөнгө оруулалттай холбоотойгоор эн тэргүүний чухал салбар, түншээ тодорхойлон, хэрэгцээ шаардлагаа үнэлэн дүгнэж хэлэлцэнэ. Талууд болон түншүүд нөөц баялаг, үүрэг, хариуцлагаа эн тэнцүү хуваарилах талаар хэлэлцэн тогтож, харилцаа тогтоох арга замаа олон, харилцаанд оролцоно.
 - 7.2 Хэрэгжүүлэх, удирдлагаар хангах, хадгалж үлдэх: Талууд түншлэлээ ил тод, үр өгөөжтэйгээр хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй. Түншлэл нь төрийн бус байгууллага, хувийн салбар зэрэг иргэний нийгэм дунд аль болох бодит, боломжит бүтэц, сүлжээдийг бий болгох хэрэгтэй.
 - 7.3 Шилдэг туршлагаа дахин хэрэглэх, үнэлэх, хянан боловсруулах, хуваалцах: Талууд түншлэгчдээ түншлэлийн үр өгөөжийг ялангуяа дараах 3 түвшингээр үнэлж, дүгнэхийг дэмжих: (1) түншлэл, (2) түншлэл дэх тэдний үүрэг, (3) уг түншлэлийн зорилгын үр дүн. Олж авсан дадлага туршлага, хувийн болон хамтын үнэлгээг хэлэлцсэнээр түншүүд түншлэл буюу эхний удаагийн төслөө хянан, засаж сайжруулах төдийгүй түншлэлийн үнэ цэнийн талаар хэлэлцэнэ. Талууд түншлэлийг амжилттай хэрэгжүүлэх явцад гарсан шилдэг туршлагаа хуваалцахыг сайшаан дэмжинэ.
 - 7.4 Үр дүнг тооцоолох: Хэрэгцээ шаардлагыг үнэлэх үнэлгээнд задлан шинжлэх, статистик, чанарын мэдээлэл багтах бөгөөд ингэж үнэлэн дүгнэснээр эн тэргүүний чухал зүйлээ голлон анхаарсан стратеги боловсруулж, зорилгоо тодорхойлон, зохих хяналт тавьж үр дүнг тооцох боломжтой болдог.

ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг

8. Соёлын үйлдвэрлэлийг дэмжин төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх индэр болсон Соёлын олон төрлийг хамгаалах дэлхийн нэгдлийг түшиглэсэн ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газар нь олон улсын түвшинд зохицуулагч, идэвхжүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал:
 - 8.1 Янз бүрийн оролцогч талуудын хооронд салбар хоорондын түншлэлийг хөхиүлэн дэмжих;
 - 8.2 Төрийн болон хувийн хэвшлийн салбар, түүнчлэн ашгийн бус салбар (хэрэгцээ шаардлага, төсөл, шилдэг туршлагыг судалсан судалгаа зэргийн талаарх мэдээ мэдээллийг хамруулан) дахь одоогийн болон ирээдүйн түншүүдийн талаарх мэдээ мэдээлэл, ялангуяа цахим хуудсаараа дамжуулан менежментийн ашигтай аргатай холбогдох холбоосуудаар хангах.
9. Төв байгууллага, салбар нэгжүүд тус тусын чиг үүргийн хүрээнд үүрэг хариуцлага хүлээнэ. Тэднийг энэ чиглэлд зорилгоо түгээн дэлгэрүүлэхэд ЮНЕСКО-ийн Үндэсний комиссуудын сүлжээ, тэдний чадавхийг ашиглахыг дэмждэг;

10. Түүнчлэн, конвенцын хүрээнд заагдсан салбарт шинэлэг төслүүдийг боловсруулан хандивлагч нарт танилцуулах ажлыг Нарийн бичгийн дарга нарын зүгээс хийнэ.

Хөгжиж буй орнуудад зориулсан хөнгөлөлттэй нөхцөл

16 дугаар зүйл. Хөгжиж буй орнуудад зориулсан хөнгөлөлттэй нөхцөл

Хөгжингүй орнууд нь хөгжиж буй орнуудын уран бүтээлчид болон соёлын салбарын бусад мэргэжилтнүүд, дадлагажигч нарт, түүнчлэн соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд хөнгөлөлттэй нөхцөлийг бүтцийн болон хууль эрх зүйн зохих хүрээнд олгох замаар хөгжиж буй орнуудтай соёлын солилцоо хийхэд дэмжлэг үзүүлнэ.

1. Удиртгал

- 1.1 Тус конвенцын стратегийн зорилгыг харгалзан 16 дугаар зүйлд хөгжиж буй болон хөгжингүй орнуудын хооронд соёлын солилцоо явуулахын зорилгыг тодорхойлсон. Зохих хууль эрх зүйн болон байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнуудад олгож буй хөнгөлөлттэй нөхцөл бол хөгжиж буй орнуудад эрчимтэй соёлын салбарыг бий болгох, илүү тэнцвэртэй, өргөн цар хүрээний соёлын солилцоог хэрэгжүүлэхийн тулд 16 дугаар зүйлд тусгаж өгсөн арга юм.
- 1.2 Конвенцтой холбоотойгоор 16 дугаар зүйлийг бүхэлд нь тайлбарлан хавсаргав. Талууд конвенцын холбогдох бүхий л заалт, үйл ажиллагааны янз бүрийн удирдамжийг ашиглан хамтдаа хөгжин дэвшиж, ихийг бүтээхийн төлөө чармайх хэрэгтэй.
- 1.3 Хамтын ажиллагааны үндсэн зарчим, гол утга санаа нь 16 дугаар зүйлд заасан хөнгөлөлттэй нөхцөлийг үр өгөөжтэйгээр хэрэгжүүлэхэд бүхий л талуудын хоорондын харилцааг зохицуулна.

2. Талуудын үүрэг

- 2.1 Хөгжиж буй орнуудыг дэмжихэд хөгжингүй орнуудын хүлээх үүргийг мөн 16 дугаар зүйлд зааж өгсөн. Үүнд дараах зүйлс хамаарна:
 - (a) Уран бүтээлч, соёлын бусад мэргэжилтэн, дадлагажигчид;
 - (b) Соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ.
- 2.2 16 дугаар зүйлийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа болгохын тулд хөгжингүй орнууд байгууллагын зохих түвшинд үндэсний бодлогоо хэрэгжүүлж, шаардлагатай арга хэмжээг авч, мөн хоёр талын, бүс нутгийн, олон талт харилцаа, механизмуудыг ашиглан тэргүүлэх үүрэг гүйцэтгэх хэрэгтэй.
- 2.3 Хөнгөлөлттэй нөхцөлийн үндсэн зарчмын хүрээнд дэмжлэг хүртэж байгаа хөгжиж буй орнуудад хөгжингүй орнуудын зүгээс таатай боломж олгохыг дэмждэг бөгөөд ингэснээр тэд өөрсдийн хэрэгцээ шаардлага, эн тэргүүний чухал зүйлсээ тодорхой илэрхийлэх эрхтэй болдог. Хөнгөлөлттэй нөхцөлийг үр өгөөжтэй хэрэгжүүлэхийн тулд үндэсний

бодлогоо түүнд нийцүүлэхийг хөгжиж буй орнуудад зөвлөдөг. Гэхдээ хөнгөлөлттэй нөхцөлийг хэрэгжүүлэх нь эдгээр үндэсний бодлогыг хэрэгжүүлэх болзол гэж үзэж болохгүй. Эцэст нь хөнгөлөлттэй нөхцөлийг үр өгөөжтэй хэрэгжүүлснээр хөгжиж буй орнуудад үр ашгийг нь хүртэх боломж олгон, үндэсний бодлогоо тодорхойлж, үйл ажиллагаа явуулахад нь хөгжингүй орнууд туслах хэрэгтэй.

- 2.4 16 дугаар зүйлийн дагуу аль нэг хөгжиж буй орон өөр нэг хөгжиж буй оронд хөнгөлөлттэй нөхцөлийг санал болгох үүрэг хүлээдэггүй бол Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааны хүрээнд хөгжиж буй орнууд бусад хөгжиж буй орнууддаа хөнгөлөлттэй нөхцөлийг санал болгохыг дэмждэг.

3. Байгууллагын болон хууль эрх зүйн хүрээ

- 3.1 16 дугаар зүйлд тодорхойлсон хөнгөлөлттэй нөхцөл нь худалдааны явцуу утгаас илүү өргөн хүрээтэй. Энэ нь соёлын болон худалдааны бүрэлдэхүүн хэсгийн аль алинийг нь багтаасан гэж ойлгож болно.

- 3.2 Талуудын баримталж буй хууль эрх зүйн болон байгууллагын хүрээ зохихуулах бөгөөд энэ нь дараах цар хүрээнд үйлчилнэ:

- Соёлын хүрээ;
- Худалдааны хүрээ;
- Худалдаа, соёлын хосолсон хүрээ.

3.3 Соёлын хүрээ

- 2.2.1 Тогтвортой хөгжлийн хүрээн дэх соёлын хамтын ажиллагаа бол конвенцын 16 дугаар зүйлд заасан хөнгөлөлттэй нөхцөлийн цөм элемент юм. Талууд соёлын хамтын ажиллагааны хэлцлээ боловсронгуй болгох, хоёр талын, бүс нутгийн, олон талын солилцооны хэлэлцээр, хөтөлбөрүүдийг өргөжүүлэн тэлэх, олон хувилбар гаргаж ирэх соёлын хамтын ажиллагааны механизм ашиглахыг дэмжинэ.

- 2.2.2 Үндэсний бодлого болон олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа, мөн хөнгөлөлттэй нөхцөлд зориулан соёлын хамтын ажиллагааны механизмын хүрээнд боловсруулдаг тус тусын үйл ажиллагааны удирдамжийг харгалзан үйлдсэн конвенцын заалтуудад (6, 7, 12, 14 дугаар зүйл) дараах зүйлсийг тусгасан байх боловч үүгээр хязгаарлагдахгүй.

- (a) Хөгжиж буй орнуудын уран бүтээлч, соёлын бусад мэргэжилтэн, дадлагажигч нарыг харгалзан үзэх:

- (i) Уран бүтээлчид болон бусад бүтээлч үйл явцыг дэмжин хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэрэгсэл боловсруулахад нь хөгжиж буй орнуудад дэмжлэг үзүүлэх экспертизээр хангах;

- (ii) Хууль эрх зүйн хүрээ болон шилдэг туршлагын талаар мэдээлэл солилцох;

- (iii) Хөгжингүй орнуудын мэргэжлийн сүлжээнд тэднийг нэгтгэхийн тулд сургалт, солилцоо, чиг баримжаа олгох үйл ажиллагаа зэргээр

чадавх бий болгох;

- (iv) Уран бүтээлч болон соёлын бусад мэргэжилтэн, дадлагажигч нар, ялангуяа хөгжиж буй орны энэ чиглэлийн хүмүүс ажил мэргэжлийн шалтгаанаар хөгжингүй орнуудад зорчих тохиолдолд дэмжих зорилгоор шилжилт хөдөлгөөн хийхэд нь хялбар болгон зохицуулах.
Зохих заалтуудад нийцүүлэн үүнтэй холбогдуулж авах арга хэмжээнд хилээр нэвтрэх, зочлох, түр зуур зорчих виз олгох журмыг хялбарчлах, визийн үнэ тарифийг хөнгөлөх зэрэг багтана;
 - (v) Санхүүжилтийг зохицуулах, нөөц баялгийг хуваарилах, мөн хөгжингүй орнуудын соёлын нөөц баялгаас хүртэхийг дэмжих;
 - (vi) Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын иргэний нийгмийн оролцогчдын хооронд хөгжлийн төлөөх түншлэл зэрэг сүлжээ бий болгохыг сайшаан дэмжих;
 - (vii) Одоогийн конвенцтой холбоотой үйл ажиллагааны хүрээнд хөгжиж буй орны уран бүтээлч, бусад соёлын мэргэжилтэн, дадлагажигч нарт санхүүгийн онцгой урамшуулал олгох;
- (b) Хөгжиж буй орны соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг харгалзан:
- (i) Дотоодын соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, үйлдвэрлэх, түгээх, дэлгэрүүлэхтэй холбоотой арга хэмжээ авах, бодлого боловсруулахад нь хөгжиж буй орнуудад туслах, экспертизээр хангах;
 - (ii) Хөгжиж буй орнуудын соёлын аж ахуйн нэгжүүдэд зориулан татварын хөнгөлөлт үзүүлэх, давхар татвар ногдуулахаас зайлсхийх гэрээ хэлэлцээр байгуулах зэрэг санхүүгийн онцгой арга хэмжээ авах, урамшуулал олгох;
 - (iii) Тоног төхөөрөмжтэй болох, технологи оруулж ирэх, экспертиз авах зэрэг техникийн туслалцаа үзүүлэх;
 - (iv) Хөгжиж буй орнуудын соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжингүй орнуудын зах зээлд нэвтрүүлэн түгээх, дэлгэрүүлэхэд онцгой дэмжлэг, тусламж үзүүлэх замаар тэдний соёлын бараа бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, ялангуяа хамтран үйлдвэрлэх, түгээх хэлэлцээр байгуулах, эсвэл энэ асуудлыг тусгасан дотоодын санаачлагыг дэмжих;
 - (v) Шууд болон шууд бус тусламжийн хэлбэртэй байж болох санхүүгийн туслалцаа үзүүлэх;
 - (vi) Хөгжиж буй орнуудын янз бүрийн соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хөхиүлэн дэмжих зорилгоор соёлын болон худалдааны үйл ажиллагаанд тэднийг оролцуулах;
 - (vii) Хөгжиж буй орнуудын соёлын чиглэлийн аж ахуйн нэгжүүд хөгжингүй оронд үйл ажиллагаа явуулах, санаачилга гаргах, түүгээр зогсохгүй хөрөнгө оруулалт хийхэд дэмжлэг үзүүлэх. Тухайлбал, мэдээллийн үйлчилгээ, санхүүгийн болон хууль эрх зүйн хүрээнд тодорхой зохицуулалт хийх, тусламж үзүүлэх гэх мэт;

- (viii) Хөгжиж буй орнуудын соёлын үйлдвэрлэлд хувийн салбарууд хөрөнгө оруулалт хийхийг дэмжих;
- (ix) Хөгжиж буй орнуудын соёлын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, түгээлтийг дэмжих зорилгоор шаардлагатай техникийн материал, тоног хэрэгсэл тогтмол импортлон, тэдний соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээг дэлгэрүүлэхийг дэмжих;
- (x) Хөгжингүй орнууд хөгжлийн тусламжийн төрийн бодлогоороо хөгжиж буй орнуудын соёлын салбарын хөгжлийн төсөлд зохих анхаарал тавихыг баталгаажуулах.

2.3. Худалдааны хүрээ

- 2.3.1 Олон талын, бүс нутгийн, хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд худалдааны салбарт хамаарах арга хэрэгслүүдийг талууд соёлын салбарын хөнгөлөлттэй нөхцөлийг хэрэгжүүлэхэд ашиглах боломжтой.
- 2.3.2 Олон талын, бүс нутгийн буюу хоёр талын худалдааны хэлэлцээрийг хамруулан конвенцод оролцогч талууд эдгээр хэлэлцээрүүдийн заалтууд, 16 дугаар зүйлд заасны дагуу хөгжиж буй орнуудыг дэмжин хөнгөлөлттэй нөхцөл олгох талаар уг заалтуудад тусгагдсан тус тусын арга хэрэгслүүдийг авч үзэж болно.
- 2.3.3 Хөнгөлөлттэй нөхцөлд зориулсан энэ мэт хамрах хүрээ, заалтуудыг ашиглахдаа талууд конвенцын 20 дугаар зүйлд нийцсэн, холбогдох заалтуудыг авч хэлэлцэж болно.

3.5. Худалдаа ба соёлын хүрээний нэгдэл

- 3.5.1 Талууд соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнчлэн уран бүтээлч, соёлын бусад мэргэжилтэн, дадлагажигч нарыг хамарсан соёлын болон худалдааны чиг баримжааг хослуулсан онцгой хэлэлцээр боловсруулан хэрэгжүүлэх боломжтой. (e.g. Флоренцийн хэлэлцээр ба дагалдах Найробигийн протокол)
4. Хөгжиж буй орнуудад хөнгөлөлттэй нөхцөлийг үр өгөөжтэй хэрэгжүүлэх үндэсний бодлого, арга хэмжээ
- 4.1 Хөгжлийн төлөөх хамтын ажиллагаа, үндэсний бодлоготой холбоотой конвенцын заалтуудын (6, 7, 14 дүгээр заалт) хүрээнд хөгжиж буй орнуудыг хөнгөлөлттэй нөхцөлөөс хүртэж буй үр ашгаа өсгөн нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, бодлого хэрэгжүүлэхийг нь дэмжинэ. Иймэрхүү бодлого, арга хэмжээнд дараах зүйлс багтах боловч эдгээрээр хязгаарлагдахгүй:
 - 4.0.1 Үндэсний түвшинд соёлын салбар, соёлын үйлдвэрлэл үүсэн гарах, хөгжих орчныг бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
 - 4.0.2 Соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой заалтуудыг нэмэгдүүлэх;
 - 4.0.3 Дотоодын соёлын салбар, соёлын үйлдвэрлэлд нь стратегийн дэмжлэг үзүүлэх;
 - 4.0.4 Соёлын салбарт урлагийн болон удирдах чадварын аль алиныг нь харгалзсан чадавх бий болгох, дадал чадварыг хөгжүүлэх;

4.0.5 Бүхий л соёлын илэрхийллийг бэхжүүлэн, түгээн дэлгэрүүлж буй газраас мэдлэг, экспертиз идэвхтэй эрэлхийлэх.

5. Иргэний нийгмийн үүрэг

- 5.1 Иргэний нийгмийн оролцоотой холбоотой конвенцын 11 дүгээр зүйл болон холбогдох үйл ажиллагааны удирдамжид заасны дагуу иргэний нийгмийн идэвхтэй оролцоог 16 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд дэмжинэ.
- 5.2 16 дугаар зүйлийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэний нийгэм ямар нэгэн хязгаарт баригдахгүйгээр дараах зүйлсийг хийх боломжтой:
 - 5.1.1 Хэрэгцээ шаардлагыг үнэлэхэд хувь нэмрээ оруулах, хөнгөлөлттэй нөхцөлийн суурь зарчмыг боловсруулах, сайжруулах, үр өгөөжтэй нэвтрүүлэх талаар мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх, шинэ санаагаар хангах;
 - 5.1.2 Эрх бүхий удирдлагууд хүсэлт гаргасан тохиолдолд хөгжиж буй орнуудын уран бүтээлч, соёлын бусад мэргэжилтэн, дадлагажигч нарын визний хүсэлтийн талаарх лавлагаа мэдээллээр хангах;
 - 5.1.3 16 дугаар зүйлийг ялангуяа энэ салбарт хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, сорилтуудыг харгалзан, конвенцод оролцогчдын хувьд ажиглагчийн хэмжээнд талуудыг эргэх холбоогоор хангах;
 - 5.1.4 Үндэсний түвшинд 16 дугаар зүйлийг хэрэгжүүлэх, хянах явцыг судлах салбарын судалгаанд санаачлагатай, идэвхтэй оролцох.

6. Зохицуулалт

- 6.1 16 дугаар зүйлд заасан хөнгөлөлттэй нөхцөлийг гүрэгөөжтэй хэрэгжүүлэхдээ талуудад худалдаа, соёлын хүрээний тууштай бодлого авч хэрэгжүүлэхийг зөвлөдөг. Түүнчлэн талуудад соёл, худалдааны чиглэлийн ажил эрхэлдэг үндэсний хэмжээний байгууллагууд, мөн хөгжиж буй болон хөгжингүй орнуудын төрийн байгууллагуудтай нягт хамтын ажиллагаатай байхыг зөвлөдөг.

7. Хяналт шинжилгээ ба мэдээллийн солилцоо

- 7.1 16 дугаар зүйлийг хамруулан уг конвенцын хэрэгжилтийг хэрхэн хянахыг конвенцын 9 дүгээр зүйлийг (Мэдээлэл солилцоо ба ил тод байдал) хэрэглэх, ялангуяа талуудын хугацаат тайлангийн үүргээр баталгаажуулсан.
- 7.2 Конвенцын 9 дүгээр зүйл дэх үйл ажиллагааны удирдамжид тодорхойлсон загварын дагуу хөгжингүй орнууд 16 дугаар зүйлд заасан үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлсэн талаарх тайлан илтгэлээ ЮНЕСКО-д дөрвөн жил тутамд тогтмол тавина. Мэдээллийн үнэн зөв эсэхийг талуудын бага хурал болон хороогоор хянан нягтлах болно.
- 7.3 Талууд конвенцын 19 дүгээр зүйлд заасан шилдэг туршлага, экспертиз хуваалцах, мэдээллийн солилцоог нэмэгдүүлэх, дэмжин туслах арга хэмжээ, механизмыг авч хэрэгжүүлнэ (мэдээлэл солилцох, дүн шинжилгээ хийх, түгээн дэлгэрүүлэх).

- 7.4 Талууд 16 дугаар зүйлд заасан хөнгөлөлттэй нөхцөлийг хэрхэн үр өгөөжтэй хэрэгжүүлэх талаарх судалгаа чухал үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрнө. Судалгаанд аль болох олон түнш оролцуулан явуулах хэрэгтэй. Ингэхийн тулд талууд 16 дугаар зүйлтэй холбоотой аливаа судалгааны үр дүнг эмхтгэн тараах үүрэгтэй.

Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сангийн нөөцийг ашиглах тухай удирдамж

Талуудын бага хурлын 4-р хуралдаанаар хянан засварласан. (2013 оны 6-р сарын 11-13, Парис)

18 дугаар зүйл - Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сан

1. Соёлын олон төрлийг дэмжих олон улсын санг/ цаашид “Сан” гэх/ үүгээр байгуулна.
2. ЮНЕСКО-ийн Санхүүгийн дүрэмд заасан ёсоор итгэлцлийн сан юм.
3. Санг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:
 - (a) Талуудын сайн дурын хандив;
 - (b) Энэ зорилгоор ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаас баталсан хөрөнгө;
 - (c) Бусад улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн байгууллагууд болон хөтөлбөрүүд, бүс нутгийн болон олон улсын бусад байгууллагууд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд эсвэл хувь хүмүүсээс оруулах хандив, бэлэг, өв залгамжлал;
 - (d) Сангийн хөрөнгөд ногдох аливаа хүү;
 - (e) Цуглуулсан хандив болон сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан үйл ажиллагаанаас олсон орлого;
 - (f) Сангийн дүрмээр зөвшөөрөгдсөн аливаа бусад эх үүсвэр.
4. Сангийн хөрөнгийн зарцуулалтыг 22 дугаар зүйлд заасан талуудын бага хурлын удирдамжийг үндэслэн Засгийн газар хоорондын хороо шийдвэрлэнэ.
5. Засгийн газар хоорондын хороо нь өөрийн баталсан тодорхой төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой нийтийн болон тусгай зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн хандив болон бусад хэлбэрийн тусламжийг авч болно.
6. Санд хандив өгөх нь энэхүү конвенцын зорилгод үл нийцэх улс төр, эдийн засгийн болон бусад ямар ч нөхцөлийг дагалдуулах ёсгүй.
7. Талууд энэхүү конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор сайн дурын хандиваа тогтмол өргөж байхад хүчин чармайлт тавина.

Стратегийн бодлого, зорилго

1. Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сан (СОТДОУС)-ийн зорилго нь талуудын бага хурлаар шийдвэрлэсэн удирдамжийг үндэслэл болгон Засгийн газар хоорондын хороо (цаашид “Хороо” гэх)-оор баталсан үйл ажиллагаа, төслүүдийг санхүүжүүлэхэд оршино. Үүнд, конвенцын 14 дүгээр зүйлд (СОТДОУС-ийн Санхүүгийн дүрмийн 3 дугаар зүйл) заасны дагуу хөгжиж буй орнуудад эрчимтай хөгжих соёлын салбар бий болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийн төлөөх олон улсын хамтын ажиллагаа явуулах гэх мэт.
2. СОТДОУС-ийн гол зорилго нь соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаа, мөн орон нутгийн болон бүс нутгийн түвшинд хэрэгжих боломжтой соёлын үйлдвэрлэлийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай байгууллагын дэд бүтцийг бэхжүүлэх зэрэг соёлын илэрхийллийн олон төрлийг бүтээх, үйлдвэрлэх, түгээх, хэрэглэхэд шүүд нөлөө үзүүлэх бодлого, стратеги боловсруулах, нэвтрүүлэх замаар бүтцийн өөрчлөлт дагуулахуйц төсөлд хөрөнгө оруулах явдал юм.
3. Соёлын үйлдвэрлэл тогтвортой хөгжил, ялангуяа эдийн засгийн өсөлт, зохистой амьдралын чанарыг бий болгох таатай боломж, үр өгөөж өгдөг гэдгийг СОТДОУС-ийн төслүүд нь харуулж байна.
4. СОТДОУС-г түүний Санхүүгийн дүрмийн 1.1 дүгээр зүйлд нийцүүлэн Тусгай дансаар удирдан зохион байгуулдаг бөгөөд олон хандивлагчтай байх боловч хөгжингүй баян орнуудаас тусгай нөхцөлөөр (зөвхөн тухайн улс орны бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хандивыг зарцуулах заалт) болон тусгай зорилготойгоор өгсөн хандивыг хүлээн авахгүй.
5. СОТДОУС-ийн нөөцийн ашиглалт конвенцын үзэл санаа, заалтуудад харшлахгүй байх ёстой. 18.3(а), 18.7 дугаар заалтуудад нийцүүлэн талууд жил бүр сайн дурын хандив өгөхийг чармайх хэрэгтэй. Хороо мөн талуудаас жил бүр ЮНЕСКО-ийн төсөвт төвлөрүүлдэг хандивынхаа дор хаяж нэг хувьтай тэнцэх хандив өгөхийг зөвлөдөг. СОТДОУС-ийн нөөц хөрөнгийг хөгжиж буй орнуудын төслийг санхүүжүүлэхэд ашигладаг. Олон нийтийн хөгжлийн тусламж нь хороогоор батлагдсан төслийг дэмжих СОТДОУС-ийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглагдана. Ингэхдээ ЮНЕСКО-ийн Тусгай дансыг удирдан явуулах заалтад нийцсэн байна.
6. СОТДОУС-г удирдан зохион байгуулахдаа хороо уг нөөц хөрөнгийн ашиглалтыг хянан дараах байдлаар батална:
 - 6.1 Хорооноос гаргасан хөтөлбөрийн болон стратегийн эн тэргүүний чухал зүйлд нийцсэн байна;
 - 6.2 Үр ашгийг хүртэгч хөгжиж буй орнуудын эн тэргүүний чухал зүйл, хэрэгцээ шаардлагад нийцсэн байна;
 - 6.3 Өмнөд-Өмнөд, Хойд-Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжсэн байна;
 - 6.4 Соёлын салбарт бүтцийн нөлөө, тууштай, тогтвортой үр дүн гаргахад хувь нэмрээ оруулна;
 - 6.5 Үр ашгийг хүртэгч талуудын өмчлөлийн үзэл баримтлалыг хүндэтгэн үзнэ;
 - 6.6 СОТДОУС-ийн нөөцийг газар зүйн хувьд аль болох тэгш хүртээмжтэй

- хуваарилах бөгөөд уг нөөц хөрөнгөөс хувь хүртэж байгаагүй болон хамгийн бага хүртсэн талуудыг эн тэргүүнд тавина;
- 6.7 Нэгдсэн Үндэсний Байгууллагын тогтолцооны хүрээнд баримталдаг санхүүгийн хариуцлага хүлээх зарчмыг ханган ажиллана;
- 6.8 Үндсэндээ төслийн үйл ажиллагаанд зарцуулах санхүүгийн хэрэгцээг ханган, 15.7 дугаар хэсэгт заасан нэмэлт зардлыг доод хэмжээгээр нь гаргана;
- 6.9 Нөөц хөрөнгийг хэт үр ашиггүй байдлаар тараах, зорилтот бус үйл ажиллагаанд зарцуулахаас зайлсхийнэ;
5. НҮБХХБХ-аас хөгжиж буй эдийн засагтай, шилжилтийн эдийн засагтай, буурай хөгжилтэй орнууд хэмээн зарласан ЮНЕСКО-ийн Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай 2005 оны конвенцын оролцогч талууд
- 6.10 Жендэрийн тэгш эрхийг хөхиүлэн дэмжинэ;
- 6.11 Соёлын илэрхийллийн олон төрлийг бүтээх, үйлдвэрлэх, түгээн дэлгэрүүлэх, хуваарилах, хэрэглэхэд конвенцын 7 дугаар зүйлд тодорхойлсон нийгмийн янз бүрийн бүлгүүдийн оролцоог хөхиүлэн дэмжинэ;
- 6.12 Ижил төрлийн салбарыг хамарсан олон улсын бусад санхүүжилтийг нэмэгдүүлэн, гуравдагч талаас санхүүгийн дэмжлэг авсан болон авах боломжтой төслийг санхүүжүүлэх СОТДОУС-ийн боломжийг бууруулахгүй байх зарчмыг баримтална.

Хөндлөнгөөс оролцох салбарууд

7. Санхүүжилтийг дараах байдлаар хуваарилна:
- 7.1 Дараах нөхцөлтэй төслүүдэд:
- 7.1.1 Соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааг бүтээх, үйлдвэрлэх, түгээх, хэрэглэхэд шууд нөлөө үзүүлэх бодлого, стратегийг боловсруулах эсвэл нэвтрүүлэх;
- 7.1.2 Хөгжиж буй орнуудад хэрэгжих боломжтой орон нутгийн болон бүс нутгийн соёлын үйлдвэрлэл, зах зээлийг дэмжихийн тулд зайлшгүй шаардлагатай байгууллагын бүтэц, мэргэжлийн чадавх зэрэг зохион байгуулалттай холбоотой дэд бүтцийн үялдаа холбоог бататгах;
- 7.2 Хороогоор батлагдсан санхүүгийн хязгаарын хүрээнд оролцоог дэмжинэ. Уг дэмжлэгт дараах зүйлс багтана:
- 7.2.1 Конвенцын 23.7 дугаар зүйлд заасанчлан онцгой үйл хэргийн талаар хэлэлцэх хуралд хорооны урилгаар хүрэлцэн ирж, оролцож буй хөгжиж буй орнуудын төрийн болон хувийн байгууллага, хувь хүмүүсийн зардал;
- 7.2.2 Хорооны гишүүн буурай хөгжилтэй орнуудын засгийн газрын

шинжээчид конвенцын байгууллагын хуралд оролцох хүсэлт гаргасан тохиолдолд уг хуралд оролцох оролцооны зардал. Хүсэлтийг талуудын бага хурал болон хорооны чуулган хуралдахаас доод тал нь хоёр сарын өмнө конвенцын Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн байна;

- 7.3 Хороогоор батлагдсан шинжээчдийн баг төслийн үнэлгээг хороогоор хэлэлцүүлэхээс өмнө хийхэд зориулж олгоно. Мөн Нарийн бичгийн дарга нарын газар болон шинжээчдийн баг хоорондын үулзалтыг хоёр жил тутамд Парист хуралдуулахад төсөв хуваарилна.
8. Алдагдал нөхөх, өр эргэн төлөх буюу хүү төлөх, соёлын илэрхийллийг зөвхөн үйлдвэрлэхтэй хамаатай, мөн тогтмол зардал нөхөх тухайн үеийн үйл ажиллагааг дэмжих чиглэлийн төсөл СОТДОУС-аас дэмжлэг хүртэх боломжгүй.
9. Тусгай данснаас хүртэх боломжтой санхүүжилтэд үндэслэн хорооны чуулган бүрээс дээр дурдсан тусламжийн төрөл бүрд төсөв батална.

Үр шим хүртэгчид

10. СОТДОУС-аас үр шим хүртэх эрх авах:

10.1Төсөл:

10.1.1 Конвенцэд нэгдэн орсон бүхий л хөгжиж буй орнууд;

10.1.2 Конвенцын оролцогч талууд болох хөгжиж буй орнуудын төрийн бус байгууллагууд(ТББ). Эдгээр нь иргэний нийгмийн үүрэг, оролцоотой холбоотой Үйл ажиллагааны удирдамжид тусгагдсан конвенцын байгууллагуудын хуралд төлөөлөх эрх бүхий зохицуулалттай иргэний нийгмийн тодорхойлолт, шалгууруудыг хангасан байна;

10.1.3 Олон улсын төрийн бус байгууллагууд (ОУТББ). Эдгээр нь иргэний нийгмийн үүрэг, оролцоотой холбоотой Үйл ажиллагааны удирдамжид тусгагдсан конвенцын байгууллагуудын хуралд төлөөлөгч оролцуулах эрх бүхий зохицуулалттай иргэний нийгмийн тодорхойлолт болон шалгууруудыг хангасан байна;

10.1.4 Конвенцын оролцогч талууд болох хөгжиж буй орнуудын соёлын салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа, хувийн салбараас санхүүжилт хүртэх боломж хязгаарлагдмал, тухайн орны дотоодын хууль, эрх зүйд бүрэн нийцсэн бичил, жижиг, дунд хувийн хэвشلүүд.

10.2 Оролцооны тусламж:

10.2.1 Конвенцын 23.7 дугаар зүйлд нийцсэн хөгжиж буй орнуудын төрийн болон хувийн байгууллага, хувь хүн;

10.2.2 Хорооны гишүүн буурай хөгжилтэй орнуудын засгийн газрын шинжээчид.

10.3 Ашиг сонирхлын аливаа зөрчлөөс зайлсхийхийн тулд Нарийн бичгийн дарга нарын газарт өргөн барьсан төслийг урьдчилан сонгох, батлахад оролцож буй аливаа байгууллага эсхүл Үндэсний комиссууд СОТДОУС-ийн санхүүжилтийг хүртэх боломжгүй.

Өргөн барих, санхүүжүүлэх дээд хязгаар

11. Өргөн барих, санхүүжүүлэх дээд хязгаарын хувьд дараах зүйлсийг анхаарна:

11.1 СОТДОУС-аас санхүүжилт хүсэж буй нэг төслийн дээд хэмжээ 100,000 ам.доллар байх;

11.2 Төслийн хэрэгжилтийн хугацаа 12-24 сар байна;

11.3 Үндэсний комисс болон талуудаас томилсон бусад албаны сувгууд санхүүжилт хүсэх хугацаа бүрт дээд тал нь дөрвөн өргөдөл, үүнд талууд (төрийн захиргаа/байгууллага) хоёр өргөдөл, ТББ хоёр өргөдөл илгээх боломжтой;

11.4 ОУТББ бүр санхүүжилт хүсэх хугацаанд үр шим хүртэгч орноос бичгээр баталгаа гаргуулан дээд тал нь хоёр өргөдөл өгөх боломжтой.

Улс орны түвшинд урьдчилан сонголт хийх үйл явц

12. Улс орны түвшинд урьдчилан сонголт хийх үйл явцын хүрээнд дараах зүйлсийг харгалзан авч үзнэ. Үүнд:

12.1 Үндэсний комиссууд эсвэл талуудаас томилсон албаны бусад хэрэгслээс өөрийн улсдаа санхүүжилт хүссэн хүсэлт гаргах товыг Нарийн бичгийн дарга нарын газраас тогтоосон өргөн барих эцсийн хугацааг харгалзан зохих хугацаанд зарлаж болно;

12.2 Үндэсний комиссууд эсвэл талуудаас томилсон албаны бусад хэрэгслээс Нарийн бичгийн дарга нарын газарт өргөн барих төслүүдийг үнэлэх, урьдчилан сонгон шалгаруулалт хийх зорилгоор урьдчилан сонгон шалгаруулалт хийх багийг, нэн ялангуяа Соёлын яам ба /эсвэл соёлын үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн бусад яам, соёлын салбарт мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагын гишүүдийг оролцуулан бүрдүүлнэ;

12.3 Урьдчилан сонгон шалгаруулах баг тухайн төслийн ач холбогдол, улс орны хэрэгцээ шаардлага, эн тэргүүний чухал зүйлд нийцэж байгаа эсэх, оролцогч талуудын дунд зөвлөлдөхүйц сэдэв болж чадах эсэхэд үнэлгээ өгөх үүрэгтэй.

Санхүүжилтийн хүсэлтийг өргөн барих үйл явц

13. Санхүүжилтийн хүсэлтийг өргөн барих үйл явцын хүрээнд дараах зүйлсийг харгалзан авч үзнэ. Үүнд:

13.1 Нарийн бичгийн дарга нарын газраас жил бүрийн нэгдүгээр сард санхүүгийн хүсэлт хүлээн авах зар гаргана. Нарийн бичгийн дарга нарын

газар санхүүжилт хүссэн бүх хүсэлтийг тавдугаар сарын 15-ны дотор хүлээн авна. Эцсийн хугацаа дууссаны дараа ирүүлсэн бичиг баримтыг хүчингүйд тооцно;

- 13.2 Талууд болон ТББ-аас гаргасан санхүүгийн хүсэлтийг Үндэсний комиссууд эсвэл талуудаас томилсон албаны бусад хэрэгслээр дамжуулан Нарийн бичгийн дарга нарын газарт өргөн барина. Энэ нь уг төслийн ач холбогдол, тухайн улсын хэрэгцээ шаардлага, эн тэргүүний чухал зүйлд нийцсэн гэдгийг баталгаажуулдаг;
- 13.3 ОУТББ-аас гаргаж буй санхүүгийн хүсэлтийг уг төсөл нь үр шим хүртэгчийн хэрэгцээ шаардлага, эн тэргүүний чухал зүйлд нийцсэн, чухал төсөл гэдгийг баталгаажуулан үйлдсэн бичгийн хамт Нарийн бичгийн дарга нарын газарт шууд өргөн барина. ОУТББ-аас гаргаж буй санхүүгийн хүсэлтийг тусгайд нь өргөн барьж, дэд бүсийн, бүсийн, бүс хоорондын нөлөөг нь заавал тодорхойлно;
- 13.4 Хүсэлтийг хүлээж авахдаа Нарийн бичгийн дарга нарын газар СОТДОУС-ийн хөндлөнгөөс оролцох зарчмын хүрээнд өргөдөл бүрэн эсэх, мөн хэрэгцээтэй эсэхийг баталгаажуулсан техникийн үнэлгээ өгнө. Шалгаж гүйцээний дараа Нарийн бичгийн дарга нарын газар сонгогдсон төслийн баримт бичгүүдийн үнэлгээг хийлгэхээр шинжээчдийн багт илгээнэ.

Санхүүжилт хүсэх маягт

14. 2005 оны конвенцын цахим хуудсанд байршуулсан Нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан өргөдлийн маягтыг санхүүжилтийн хүсэлт гаргах албан ёсны маягт хэмээн үзнэ.
15. Санхүүжилт хүссэн бүхий л хүсэлтийг англи, франц хоёр хэлний аль нэг дээр нь үйлдэх бөгөөд дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
 - 15.1 Хүсэлт гаргагчийн үндсэн мэдээлэл. Үүнд эрхэм зорилго, үйл ажиллагаа болон төслийн багийн гишүүдийн хувийн мэдээлэл зэрэг багтана;
 - 15.2 Төслийн хураангуй;
 - 15.3 Төслийн товч мэдээ (гарчиг, богино болон урт хугацааны хэмжигдэхүйц зорилго, тухайн орны орчин нөхцөл, хэрэгцээ шаардлагыг үнэлсэн үнэлгээ, үйл ажиллагаа, нийгэм, соёл, эдийн засгийн үр нөлөө, үр шим хүртэгчид, түншлэл зэргийг харгалзан хүлээж буй үр дүн);
 - 15.4 Төслийг хэрэгжүүлэхээр санхүүгийн болон захиргааны хариуцлага хүлээн ажиллах үр шим хүртэгч байгууллагын төлөөлөгчийн нэр, хаяг;
 - 15.5 Ажлын хуваарь, цаг хугацаа;
 - 15.6 Санал болгож буй төслийн тогтвортой байдлыг хөхиүлэн дэмжих арга хэрэгсэл;
 - 15.7 СОТДОУС-аас хүсэж буй санхүүгийн хэмжээ бүхий нарийвчилсан төсөв, бусад эх сурвалжийг хамруулна. Дангаар эсвэл хамтарсан санхүүжилтийг аль болох өргөн хүрээнд дэмжинэ. Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөлтэй холбоотой нэмэлт зардлыг хамгийн ихдээ төслийн нийт төсвийн 30 хувиас хэтрүүлэхгүй;

15.8 СОТДОУС-аас хүсэх эхний ээлжийн санхүүжилтийн хүсэлт дуусгавар болохтой холбоотой аливаа мэдээлэл.

Шинжээчдийн баг

16. Нарийн бичгийн дарга нарын газраас зургаан гишүүнээс бүрдсэн шинжээчдийн багийг дараах шалгуурт үндэслэн батлуулахаар хороонд санал болгоно. Үүнд:

- Газар зүйн тэгш хуваарилалт, төлөөлөл;
- Соёлын бодлого, соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, мэргэжлийн туршлага;
- Төсөлд үнэлгээ хийж байсан туршлага;
- Олон улсын хамтын ажиллагаанд оролцож байсан мэргэжлийн туршлага;
- ЮНЕСКО-ийн аль нэг бүс нутагт мэргэжлийн арвин туршлага хуримтлуулсан байдал;
- Жендэрийн тэгш байдал;
- Англи эсвэл франц хэлийг чөлөөтэй эзэмшсэн, боломжтой бол өөр бусад хэлээр сайн ойлгодог байх.

16.1 Шинжээчдийн багийн гишүүд дөрвөн жил ажиллах үүрэгтэй. Ажлын залгамж халааг хангахын тулд хоёр жил тутамд багийн гишүүдийн тэн хагасыг шинэчилдэг;

16.2 Шинжээчдийн багийн зургаан гишүүн дотроосоо өөрсдийн зохицуулагчаа томилно;

16.3 Шинжээчдийн багийн уулзалтыг Нарийн бичгийн дарга нарын газраас хоёр жил тутамд Парист зохион байгуулна;

16.4 Шинжээчдийн баг нь хороогоор хэлэлцүүлэх, боломжтой бол батлуулахаар зөвлөмж бэлтгэн хүргүүлэх үүрэгтэй. Шинжээчдийн багийн зөвлөмжилсөн төслүүдийг хороогоор хянан шийдвэрлэх үед тус хорооны хуралдаанд зохицуулагчийг урьж оролцуулна;

16.5 Төслийн өргөдөл бүрд Нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан үнэлгээний загварыг ашиглан хоёр шинжээч үнэлгээ хийнэ. Шинжээч өөрийн орны төсөлд үнэлгээ хийхгүй.

Шинжээчдийн багийн зөвлөмж

17. Шинжээчдийн баг Нарийн бичгийн дарга нарын газраас хүлээн авсан санхүүгийн хүсэлтэд үнэлгээ хийх үүрэгтэй. Ингэхдээ үнэлгээний албан ёсны аргыг ашиглахаас гадна СОТДОУС-ийн ерөнхий зорилгыг харгалзан үзнэ.

17.1 Шинжээчдийн баг хороонд дараах зөвлөмжийг хүргүүлнэ:

17.1.1 Олгож болох санхүүгийн хязгаарын хэмжээнд санхүүжилт хүртэх төслийн жагсаалт;

- 17.1.2 Хамруулж болох хамгийн дээд хэмжээний доод хязгаар нь 75 хувь хүртэлх төслүүд;
 - 17.1.3 Үр шим хүртэгч бүрийн зөвхөн нэг төсөл;
 - 17.1.4 Боломжтой бол, СОТДОУС-аас төсөл, үйл ажиллагаанд зориулахаар хүсэлт гаргаж буй санхүүжилтийн тохиргоог дагалдах тайлбарын хамт.
- 17.2 Нарийн бичгийн дарга нарын газар хорооны чуулган эхлэхээс дөрвөн долоо хоногийн өмнө төслийн бүхий л бичиг баримт, шинжээчдийн багийн хийсэн үнэлгээ, зөвлөмжийг цахим хуудсанд байршуулна.

Хорооны шийдвэр гаргалт

18. Хороо ээлжит чуулганаараа төслүүдийг авч хэлэлцэн батламжилна.
19. Хорооны шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэхийн тулд шинжээчдийн багийн зөвлөмжид нарийвчилсан илтгэлийг хавсаргана. Үүнд дараах зүйлс багтана.
- 19.1 Хүсэлт гаргаж буй төслийн хураангуй;
 - 19.2 Болзошгүй үр нөлөө, хүлээгдэж буй үр дүн;
 - 19.3 СОТДОУС-аас санхүүжүүлэх үнийн дүнгийн талаарх санал;
 - 19.4 СОТДОУС-ийн зорилго болон СОТДОУС-ийн оролцоотой талбарт тухайн төслийн хамаарал/нийцтэй байдал;
 - 19.5 Санал оруулж буй төслийн хэрэгжилт, гүйцэтгэлийн загварын ач холбогдол, үр өгөөж, хүлээгдэж буй бүтцийн үр нөлөөг үнэлэх үнэлгээ;
 - 19.6 Үр шим хүртэгчид ямар түвшинд эзэмшихийг тодорхойлон тусгаж, төслийн тогтвортой байдлыг дүгнэсэн дүн шинжилгээ, гарцын түвшингээс гадна урт хугацаанд хүлээгдэж буй үр дүнгийн төлөвлөгөө, түүнчлэн бүтцийн үр нөлөөг бий болгох боломжтой төсөл, ирээдүй хойч үед бүтцийн өөрчлөлтөд зориулан арга хэмжээ авч хэрэгжүүлэх, орчин нөхцөл бүрдүүлэх;
 - 19.7 Төслийн ашиг сонирхлын асуудлыг үнэлэх үнэлгээ;
 - 19.8 Уг төсөл жендэрийн эрх тэгш байдлыг хэрхэн харгалзан авч үзсэнийг үнэлэх үнэлгээ.

Хяналт шинжилгээ

20. ЮНЕСКО нь төсөл хэрэгжүүлэхэд гарах хүндрэл бэрхшээлүүдийг танин тогтоох, тогтвортой хэрэгжих нөхцөлийг ханган ажиллахад хүрэлцэхүйц хэмжээний санхүүгийн болон хүний нөөцөд тулгуурлан эрсдэлд суурилсан төслийг хянан шинжлэх тогтолцоог бүрдүүлнэ. Энэхүү хяналт шинжилгээний тогтолцоо нь урт болон богино хугацааны зорилгууд, ТХХБХХ гэсэн үзүүлэлтүүдэд суурилна.
21. ЮНЕСКО-ийн холбогдох бүх салбар нэгжүүд СОТДОУС-ийн одоогийн төслүүдийн хяналт шинжилгээ болон тухайн улсын түвшинд ЮНЕСКО-ийн

бусад үйл хэрэгтэй холбогдох байдал, харилцан хамаарлыг ханган Нарийн бичгийн дарга нарын газартай хамтран ажиллах холбогдох хүн/байгууллагыг томилно. ЮНЕСКО-ийн салбар нэгжүүдийн оролцоо нь СОТДОУС-ийн төслийн түншүүд, цаашид гарч ирэх хандивлагч нарын хооронд харилцаа холбоо тогтоох, харилцан туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх явдал юм.

Үнэлгээ

22. СОТДОУС-д таван жил тутамд хөндлөнгийн хяналт оруулж, үнэлгээ хийнэ.
23. Үүнээс гадна, аливаа төслийг хорооны хүсэлтээр эргэн хянаж, зарцуулсан хөрөнгийнхөө хэмжээнд зорилгоо хэрхэн биелүүлсэн, хэр үр өгөөжтэй байсныг нь үнэлэх боломжтой. Хөрөнгө оруулсан төслийн үнэлгээгээр хөгжиж буй орнуудад эрчимтэй соёлын үйлдвэрлэл үүсэн бий болохыг дэмжих, бэхжүүлэхэд үзүүлж буй нөлөө болон авсан сургамжаа үзүүлэх хэрэгтэй. Уг үнэлгээнд конвенцын мэдлэгийн тавцанд тэргүүн туршлагуудыг цуглуулж түгээн дэлгэрүүлэх үүднээс олж авсан дадлага туршлага нь бусад төслүүдэд хэр үр өгөөжтэй байсныг тусгана.
24. СОТДОУС-ийн тусгай дансанд баримталдаг санхүүгийн дүрмийн хүрээнд ЮНЕСКО-ийн хянагч нь СОТДОУС-ийн санхүүгийн тооцооны бүртгэлийг хадгалах, аудит хийх үүрэг бүхий ЮНЕСКО-ийн хөндлөнгийн аудиторт жил тутмын санхүүгийн тайлан мэдээгээ танилцуулах үүрэг хүлээнэ.

Тайлан өгөх

25. Төслийн үр шим хүртэгчид төслийн хэрэгжилт болон хүлээгдэж буй үр дүнгийн гүйцэтгэлээ тайлбарласан, задлан шинжилсэн, санхүүгийн тайлангаа Нарийн бичгийн дарга нарын газарт өгнө. Үр шим хүртэгчид үлдэгдэл санхүүжилтээ авахын тулд Нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан тайлангийн загварыг ашиглан тайлангаа бичиж хүргүүлнэ. Үлдэгдэл санхүүжилтээ аваагүй үр шим хүртэгчид дахин шинэ төслийн санхүүжилтаас хуваарилалт хийхгүй.

Мэдээлэл солилцох, дүн шинжилгээ хийх, түгээх

19 дүгээр зүйл. Мэдээлэл солилцох, дүн шинжилгээ хийх, түгээх

1. Талууд соёлын илэрхийллийн олон төрлийн талаар цуглуулсан мэдээлэл болон статистик тоо мэдээ, түүнчлэн түүнийг хамгаалах, хөхиүлэн дэмжих тэргүүний туршлагатай холбоотой мэдээлэл, тусгай мэдлэг, туршлага солилцохоор тохиролцоно.
2. ЮНЕСКО нь Нарийн бичгийн дарга нарын газрын одоогийн бүтцийг ашиглан уг асуудлаарх бүхий л мэдээлэл, статистик тоо баримт, тэргүүн туршлагыг цуглуулах, дүн шинжилгээ хийх болон түгээн дэлгэрүүлэх явдлыг дэмжинэ.
3. ЮНЕСКО нь соёлын илэрхийллийн салбарт үйл ажиллагаа явуулдаг янз бүрийн салбар болон төрийн, хувийн хэвшлийн, ашгийн бус байгууллагуудын талаарх мэдээллийн санг бүрдүүлж, шинэчилж байна.

4. Мэдээлэл цуглуулах ажлыг дэмжихийн тулд ЮНЕСКО нь уг асуудлаар тусламж авахыг хүссэн талуудын чадавхийг бий болгох, тусгай мэдлэг болон туршлагыг нь өргөжүүлэхэд онцгой анхаарна.
5. Энэхүү зүйлийн дагуу цуглуулсан мэдээлэл нь 9 дүгээр зүйлийн заалтуудад заасан мэдээлэлд нэмэлт болно.

Үндсэн зарчим

1. 19 дүгээр зүйл дэх үйл ажиллагааны удирдамжид мэдээ мэдээлэл, статистик тоо баримт болон тэргүүний туршлагуудыг солилцох, дүн шинжилгээ хийх, түгээх үйл хэргийг олон улсын түвшинд явуулах арга хэрэгслүүдийг тодорхойлон заасан. Энэ нь талуудын дөрвөн жил тутамд тайлангаа бичиж, өргөн барих талаар тодорхой заасан үйл ажиллагааны удирдамжийн нэмэлт болно (9 дүгээр зүйл).
2. 19 дүгээр зүйлийн зорилго нь:
 - Талууд мэдээ мэдээлэл, статистик тоо баримт, шилдэг туршлага солилцох, дүн шинжилгээ хийх, түгээх, ялангуяа шаардлагатай тохиолдолд стандарт үзүүлэлт боловсруулах тал дээр хамтран ажиллах ерөнхий хүрээ бий болгох;
 - Цуглуулж, дүн шинжилгээ хийн, түгээсэн мэдээ мэдээлэл, статистик тоо баримт, шилдэг туршлагуудынхаа ач холбогдол, цаашлаад жишигдэхүйц байдлыг бататгах;
 - Мэдээ мэдээлэл, статистик тоо баримт, шилдэг туршлагуудыг цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх үйл хэргийг хэрэгжүүлэхэд тохирох түнш, арга замуудыг тодорхойлох;
 - Шаардлагатай экспертиз, ялангуяа мэдээ мэдээлэл, тоо баримт цуглуулах, дүн шинжилгээ хийх чадавхийг бэхжүүлэх зэрэг болно.

Талуудын үүрэг, хариуцлага

3. Талууд доор тусгайлан заасны дагуу өөрийн нутаг дэвсгэр болон олон улсын хамтын ажиллагааны хүрээнд өрнөж буй аливаа үйл ажиллагаанд оролцоно.
4. Талуудыг үндэсний түвшинд мэдээ баримт цуглуулах, мэдээллийн дэд бүтцээ сайжруулахыг хөхиүлэн дэмжинэ. Энэ утгаараа чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд зориулж олон улсын дэмжлэг хүсэх боломжтой.
5. Талууд мэдээлэл, харилцааны технологийг зохих байдлаар ашиглан өөрийн нутаг дэвсгэрт мэдээ мэдээлэл, тоо баримт солилцох, дүн шинжилгээ хийх, түгээх үйл ажиллагаа явуулахыг нь хөхиүлэн дэмжинэ. Ийм үйл ажиллагааг үндэсний хэмжээний холбоо барих хүн/байгууллагаар дамжуулан эсвэл хамтран ажиллах зарчмаар нээлттэй, ил тод хэлбэрээр явуулна. Ингэхдээ энэ салбарт мэргэшсэн иргэний нийгмийн оролцогчид болон үндэсний зохицуулагчдыг оролцуулна. Цуглуулсан мэдээ мэдээлэл, тоо баримтыг конвенцын 9.1 дүгээр зүйлийн дагуу талууд дөрвөн жил тутамд өргөн барих тайлан мэдээндээ ашиглах боломжтой.
6. Талуудын өөрсдийн нутаг дэвсгэрт явуулж буй үйл ажиллагааг олон улсын, бүс нутгийн, дэд бүс нутгийн түвшний санаачилгаар хөгжүүлж/өргөжүүлэх

боломжтой. Талуудын нэн ялангуяа дараах чиглэлийн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжинэ. Үүнд:

- (i) мэдээ мэдээлэл, мэдлэг хуваалцахад чиглэсэн үйл ажиллагааг олон улсын, бүс нутгийн, дэд бүс нутгийн түвшинд дэмжих хүчин чармайлтуудад нэгдэх;
- (ii) соёлын илэрхийллүүдийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга зам, арга хэрэгслүүдээр тэргүүний, ач холбогдолтой туршлагаа солилцох явдлыг дэмжих;
- (iii) Соёлын илэрхийллийн олон төрлийн талаар мэдээ баримт цуглуулах, үзүүлэлт боловсруулах тал дээр экспертиз солилцоход дэмжлэг үзүүлнэ. Үүнд мэргэжилтнүүд, ялангуяа залуу мэргэжилтнүүдийг сургах, солилцох явдлыг дэмжих зэрэг багтана.

ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг, хариуцлага

7. ЮНЕСКО нь (а) мэдээ мэдээлэл, статистик тоо баримт, тэргүүн туршлага цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээхэд дэмжлэг үзүүлэн, (б) соёлын илэрхийллийн салбарт мэргэшсэн төрийн, хувийн, иргэний нийгмийн гол гол оролцогчдын талаар мэдээ мэдээлэл гарган, шинэчилж, (в) чадавх бий болгоход дэмжлэг үзүүлнэ.
8. ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газар нь дараах чиглэлийн үйл хэрэгт хүчин зүтгэнэ.
Үүнд:
 - Конвенцыг хэрэгжүүлэхэд оролцох шинжээчдийн талаарх мэдээллийн сан боловсруулах, хадгалах, ялангуяа чадавх бий болгох хүсэлтийг хүлээн авч дэмжлэг үзүүлэх;
 - өөрсдийгөө харьцуулж үзэх боломж олгон шинжээч, дадлагажигч нарт зориулсан цахим хэлэлцүүлгийн форум зохиох хэлбэрээр мэдээ мэдээлэл, тэргүүний туршлагаа олон улсын түвшинд солилцохыг нь дэмжих;
 - Дэлхийн янз бүрийн бүс нутаг, дэд бүс нутгуудаас цугласан мэдээллийн эх сурвалжийн сүлжээг дэмжин, мөн эдгээр эх сурвалжийг авч ашиглахад нь дэмжлэг үзүүлнэ.
9. Гишүүн улсуудын авч ашигладаг статистикийн мэдээ мэдээлэл цуглуулах дэлхий дахины, байнгын нэгж болохын хувьд ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн (ЮСИ)-ийг (i) 2009 оны Соёлын статистикийн хүрээг хэрэгжүүлэх чадавхийг бий болгох стратегийн нэг хэсэг болгон бүс нутгийн сургалт семинарыг зохион байгуулах, (ii) Конвенцтой холбоотой шинэлэг арга зүйн тал дээр олон улсын шинжээч нартай цаашид ч хамтран ажиллах явдлыг нь хөхиүлэн дэмжинэ. Түүнчлэн, сургалтын хөтөч, статистикийн арга зүйн гарын авлагыг үндэсний, бүс нутгийн, орон нутгийн түвшний зорилтот бүлгүүдийн харилцан адилгүй хэрэгцээ, чадавхид нийцүүлэн хэд хэдэн хэлээр гаргаж болно. Ийм үйл ажиллагаанд ЮНЕСКО-ийн салбар нэгжүүд, соёлын статистикийн бүс нутгийн зөвлөхүүдээс бүрдсэн ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн сүлжээг идэвхтэй оролцуулах нь зайлшгүй чухал юм.

Иргэний нийгмийн оролцоо

10. Иргэний нийгмийн оролцогчид мэдээ мэдээлэл, тоо баримт гаргагч, түгээгчийн хувиар оролцох ёстой.
11. Дэлхийн янз бүрийн бүс нутгуудаас оролцож буй иргэний нийгмийн байгууллагууд олон улсын, бүс нутгийн, дэд бүс нутгийн түвшинд хамтын ажиллагаа бий болгохыг дэмжин үйл ажиллагаагаа Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлж байхыг хөхиүлэн дэмжинэ.

Конвенцыг олны хүртээл болгох, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээ***Үндсэн зарчим***

1. Конвенцыг үр өгөөжтэй хэрэгжүүлэхийн тулд талуудыг боломжит бүхий л аргаар дэмжинэ. Нэн ялангуяа конвенцын зорилго, зарчмуудыг илүү анхааран үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд конвенцыг олны хүртээл болгох, дэмжин ажиллах явдлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авна (1, 2 дугаар зүйл).
2. Ингэхийн тулд талууд, уран бүтээлч, соёлын бусад мэргэжилтэн, дадлагажигч нарыг хамарсан иргэний нийгэм, мөн төрийн болон хувийн салбар зэрэг бүхий л оролцогч талуудыг хамруулан хамтран ажиллах нь нэн чухал.
3. Конвенцыг олны хүртээл болгох, дэмжин ажиллахад чиглэсэн үйл ажиллагаа нь соёрхон батлахыг дэмжих чиглэлийн стратегийн хүрээнд хийгдэж буй цорын ганц сайн дурын ажил болох Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сангийн (цаашид “Сан” гэх) дэмжлэгтэйгээр сан бүрдүүлэх үйл хэрэгтэй нягт холбоотой.

Конвенцыг олны хүртээл болгох, дэмжин ажиллах чиглэлд талуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ***Үндэсний түвшинд***

4. Талууд өөрсдийн нутаг дэвсгэрт конвенцыг олны хүртээл болгох, дэмжин ажиллахад нь түлхэц болох арга хэмжээг авч ашиглах, боловсруулах зэргийг нь дэмжинэ. Дор дурдсан арга хэмжээнүүд үүнд хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
 - 4.1 Үндэсний комисс, иргэний нийгэм, янз бүрийн салбарын манлайлагчид, улс төрийн шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах, татан оролцуулах, мөн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, харилцааг тогтворжуулах зорилгоор тэдний хоорондын уялдаа холбоог хөхиүлэн дэмжих;
 - 4.2 Соёлын илэрхийллийн олон төрлийн талаарх ойлголтыг дэмжих, нэмэгдүүлэх зорилго бүхий төрийн болон хувийн хэвшил, мөн иргэний нийгмийн санаачилгыг нэгтгэн боловсруулах, хэрэгжүүлэх явдлыг дэмжих;
 - 4.3 Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, соёлын илэрхийллийн орон зайд орон нутгийн болон үндэсний бодлогын ач холбогдлыг өргөж өгөх зорилгоор

- конвенцод зориулсан зохицуулалтын бүтэц бий болгох, бэхжүүлэх;
- 4.4 Конвенцийн зорилго, зарчмыг түгээхийн тулд мэдээллийн хэрэгслийн кампанит ажил өрнүүлэхийг хөхиүлэн дэмжих, дэмжлэг үзүүлэх;
 - 4.5 Конвенцтой холбоотой хэн бүхэн, интернэтэд ч ашиглах боломжтой харилцааны хэрэгслүүдийг ашиглах;
 - 4.6 Соёлын илэрхийллийн олон төрлийн талаар семинар, дадлага ажил, олон нийтийн форум зохиох, мөн үзэсгэлэн, наадам, өдөрлөг зохион байгуулах, ялангуяа 5-р сарын 21-нд Харилцан яриа, хөгжлийн төлөөх соёлын олон төрлийн дэлхийн өдрийг тэмдэглэхийг дэмжих;
 - 4.7 Нэн ялангуяа залуучуудад энэхүү конвенцыг ухуулан таниулахын тулд тусгай хөтөлбөр боловсруулж боловсролын үйл ажиллагаа явуулах;
 - 4.8 Конвенцээс тодорхойлон гаргасан асуудлуудыг хариуцаж буй соёлын салбарын залуу мэргэжилтнүүдтэй хамтран олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулах.

Бүс нутгийн болон олон улсын түвшинд

5. Конвенцыг олны хүртээл болгох, дэмжих зорилгоор талуудын үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг хоёр талын, бүс нутгийн, олон улсын түвшний санаачлагаар бататгаж болно. Нарийн бичгийн дарга нарын газар болон салбар нэгжүүдийн тусламжтайгаар талуудыг дараах байдлаар хөхиүлэн дэмжинэ. Үүнд:
 - 5.1 Конвенцыг олны хүртээл болгох, дэмжин ажиллах явдлыг тогтворжуулахтай холбоотой харилцааны арга хэрэгслүүдийг боловсруулах, бусадтай хуваалцах, нэг ижил бүс нутагт буй орнуудын хооронд арга хэмжээ зохион байгуулах (5-р сарын 21-н таарч буй долоо хоногт ЮНЕСКО-оос зохион байгуулдаг Соёлын олон төрлийн наадам г.м);
 - 5.2 Сангийн дэмжсэн төсөл, үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх;
 - 5.3 Конвенцын хамрах хүрээний асуудалд ашиг сонирхолтой, энэ чиглэлд үйл ажиллагаа явуулдаг Засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудын ойлголтыг нэмэгдүүлэх, боломжтой бол хамтарсан үйл ажиллагаа зохион байгуулах.

Иргэний нийгмийн оролцоо

6. Иргэний нийгмийн оролцооны талаар тусгасан конвенцын 11 дүгээр зүйл болон үйл ажиллагааны удирдамжид заасанчлан конвенцыг олны хүртээл болгох, дэмжин ажиллахад иргэний нийгэм оролцогч талуудтай хамтран мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хамтын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж хувь нэмрээ оруулахыг хөхиүлэн дэмжинэ.
7. Ингэхийн тулд иргэний нийгэм дараах байдлаар хүчин чармайлт гаргах боловч үйл ажиллагаа нь үүгээр хязгаарлагдахгүй:
 - 7.1 Бүхий л түвшинд ялангуяа уран бүтээлчдийг төлөөлдөг соёлын мэргэжлийн байгууллагууд, соёлын илэрхийллийг бүтээх, үйлдвэрлэх, түгээх үйл явцад оролцдог бусад байгууллагуудтай хамтран хурал, семинар, форум зохион байгуулж, конвенцод хамаарах үндэсний, бүс нутгийн, олон улсын бага хурлуудад оролцох;

- 7.2 Конвенцыг үхуулан таниулах мэдээллийн арга хэрэгсэл боловсруулах, хэвлэн нийтлэх;
- 7.3 Оролцогч талуудад мэдээлэл түгээх (үндэсний мэдээллийн хэрэгсэл, цахим хуудас, мэдээллийн товхимлоор дамжуулан);
- 7.4 Конвенцын талаар сургалт, судалгааны семинар зохион байгуулахын тулд холбогдох яамд, үндэсний комисс, их дээд сургууль, судалгааны хүрээлэнгүүдтэй түншлэлийн харилцаа тогтоож ажиллах.

ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг

- 8. Конвенцыг олны хүртээл болгох, дэмжин ажиллах явдлыг сайжруулахад нь хороонд туслах зорилгоор ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газар дараах үүргийг гүйцэтгэх бөгөөд ажил үүрэг нь үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:
 - 8.1 Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар мэдээ мэдээлэл цуглуулах, хуваалцах, түгээх, талууд болон төрийн бус байгууллага, соёлын мэргэжилтнүүд, иргэний нийгэм хоорондоо мэдээлэл солилцох явдлыг дэмжинэ;
 - 8.2 Конвенцын гол утга санааг олон нийтэд хүргэх, үүний хэрэгжилтийн талаарх мэдээ мэдээллийг түгээх аргыг боловсруулах. Эдгээр аргыг боловсруулан хэд хэдэн хэлээр орчуулж түгээнэ;
 - 8.3 Конвенцын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор дадлага ажил, семинар, бага хурал зохион байгуулах;
 - 8.4 Харилцан яриа, хөгжлийн төлөөх соёлын олон төрлийг хамгаалах дэлхийн өдөр зэрэг олон улсын хэмжээний тэмдэглэлт үйл ажиллагаагаар дамжуулан конвенцын ач холбогдлыг онцлон тэмдэглэх;
 - 8.5 Сангийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төслүүдийг хэвлэн нийтлэнэ.

Конвенцыг олон нийтэд хүргэх, дэмжин ажиллах арга хэмжээнүүдийг мөрдлөг болгох, зохицуулах

- 9. Талуудын конвенцыг хөхиүлэн дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх, өөр хоорондоо мэдээлэл болон тэргүүний туршлагаа солилцох, олон улсын түвшинд хүчин чармайлт гаргах явдлыг өөрсдийн томилсон холбоо барих хүн/байгууллага (конвенцын 9, 28 дугаар зүйл) эсвэл Үндэсний комиссоор дамжуулан ажиллахыг хөхиүлэн дэмжинэ.

Конвенцын бэлгэ тэмдгийг ашиглах талаарх удирдамж

1. Үндсэн зарчим

- 1. Үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд конвенцыг олны хүртээл болгох, дэмжин ажиллахыг хөхиүлэн дэмжихийн тулд конвенцод нэгдсэн талууд зорилго, зарчмаа тодорхойлж, бэлгэ тэмдэгтэй болохыг чухалчилж үзнэ.
- 2. Конвенцын бэлгэ тэмдэг нь конвенцын харилцан хамаарал, үзэл баримтлал, утга санаа, бусадтай харилцах харилцааг илтгэсэн график дүрслэл байна.
- 3. Конвенцын бэлгэ тэмдгийг дангаар нь (цаашид “дан бэлгэ тэмдэг” гэх) болон

ЮНЕСКО-ийн логотой хамт (цаашид “хос бэлгэ тэмдэг” гэх) хэрэглэнэ.



4. Дан бэлгэ тэмдгийг ашиглахдаа одоогийн удирдамжид тусгасан заалтуудыг мөрдлөг болгоно.
5. Хос бэлгэ тэмдгийг ашиглахдаа одоо мөрдөж буй удирдамж болон ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаар баталсан ЮНЕСКО-ийн нэр, товчлол, лого, интернэт домэйн нэр ашиглахтай холбоотой зааварчилгааг мөрдлөг болгон баримтална. Иймээс хос бэлгэ тэмдгийг ашиглахдаа одоогийн удирдамж болон ЮНЕСКО-ийн нэр, товчлол, лого, интернэт домэйн нэр ашиглах тухай зааварчилгааг холбогдох удирдамжид тусгасан заалтуудтай нийцүүлэн хатуу мөрдөнө.

II. Дан болон хос бэлгэ тэмдгийн график дизайн

6. Конвенцын албан ёсны тамга тэмдэг болон ашиглаж буй дан бэлгэ тэмдгийг үзүүлбэл:

ХАР, ЦАГААН	ӨНГӨТ
	
Соёлын илэрхийллийн олон төрөл	Соёлын илэрхийллийн олон төрөл

7. Хос бэлгэ тэмдгийг үзүүлбэл:

ХАР, ЦАГААН	ӨНГӨТ
	
Нэгдсэн Үндэсний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага Соёлын Илэрхийллийн Олон Төрөл	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага Соёлын Илэрхийллийн Олон Төрөл

III. Бэлгэ тэмдгийг ашиглах эрх

8. Дараах газрууд дан бэлгэ тэмдгийг одоо мөрдөж буй удирдамжид зүйлчлэн заасан зохиогчийн эрхийг авахгүйгээр ашиглах эрхтэй. Үүнд:
 - (a) Конвенцын хууль ёсны байгууллагууд:
 - i) Талуудын бага хурал;
 - ii) Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих Засгийн газар хоорондын хороо (цаашид “Хороо” гэх); болон
 - (b) ЮНЕСКО-ийн 2005 оны конвенцын Нарийн бичгийн дарга нарын газар (цаашид “НБДНГ” гэх).

9. Уг бэлгэ тэмдгийг ашиглах эрх авахыг хүсэж буй бусад газрууд доорх дөрөвдүгээр хэсгийн заалтад нийцүүлэн хүсэлт гаргаж, зохиогчийн эрхийн зөвшөөрөл авна.

IV. График стандарт

10. Дан болон хос бэлгэ тэмдгийн аль алиныг нь ЮНЕСКО-ийн албан ёсны зургаан хэлээр ашиглана. Бэлгэ тэмдгүүдийг графикийн тусгай дүрмийн дагуу, Нарийн бичгийн дарга нарын газраас тусгайлан боловсруулж, конвенцын цахим хуудсанд байршуулсан Брэнд гарын авлагыг ашиглан дахин хийх ба өөрчлөхийг хориглоно.
11. Дан болон хос бэлгэ тэмдгийг ЮНЕСКО-ийн албан ёсны зургаан хэлээс гадна өөр хэл дээр ашиглах бол журмын дагуу ЮНЕСКО-оор заавал батлуулна.

V. Дан бэлгэ тэмдгийг ашиглах эрх авах

12. Дан бэлгэ тэмдгийг ашиглах эрх авна гэдэг нь талуудын бага хурал болон/эсвэл хорооны тусгай эрхийг авна гэсэн үг бөгөөд эрхийг аль нь ч олгож болно.
13. Талуудын бага хурал болон хороо нь Нарийн бичгийн дарга нарын газарт дан бэлгэ тэмдэг ашиглах зөвшөөрөл олгох эрхтэй.
14. Дан бэлгэ тэмдгийг ашиглах эрх олгох шийдвэрийг дараах шалгуурт үндэслэн гаргана. Үүнд:
- (a) Конвенцын зорилго, зарчимд нийцсэн, үүнээс гажаагүй байх;
 - (b) Конвенц болон соёлын илэрхийллийн олон төрлийг ойлгуулах, олны хүртээл болгоход нөлөөлөхүйц байх; мөн
 - (c) Хүсэлт гаргаж буй байгууллагын нэр хүнд, мэргэжлийн түршлага, төлөвлөж буй үйл ажиллагаанд зарцуулах санхүүгийн болон техникийн нөөц боломж гэх зэрэг төлөвлөж буй үйл ажиллагаагаа амжилттай зохион байгуулахыг тодорхойлсон баталгаа гаргана.
15. Олон улсын, бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн хэмжээний, мөн өнөө үеийн соёлын илэрхийллийн олон төрлийн томоохон цар хүрээг хамарсан, мөн уран бүтээлч, соёлыг үйлдвэрлэгч, бодлого боловсруулагч/иргэний нийгмийг хамарсан онцгой үйл ажиллагаа гэх мэт үйл ажиллагаанд зориулан дан бэлгэ тэмдэг ашиглах хүсэлтийг хэдийд ч илгээж болно. Энэ үйл ажиллагаанд тоглолт, үзэсгэлэн, аудио дүрс бүхий бүтээл, хэвлэл (хэвлэмэл болон электрон), түүнчлэн бага хурал, хурал, наадам, кино, ном, хөгжмийн чиглэлийн үзэсгэлэн худалдаа гэх мэт олон нийтийн арга хэмжээ багтана.
16. Дан бэлгэ тэмдэг ашиглах хүсэлт гаргахад дараах алхмуудыг зайлшгүй дагаж мөрдөнө. Үүнд:
- (a) Алхам 1: Үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшний үйл ажиллагаа зохион байгуулах хүсэлт гаргагч нь дан бэлгэ тэмдэг ашиглах тухай “Хүсэлт гаргах анкет” бөглөн тухайн тал болон талуудыг хамаарах ЮНЕСКО-ийн Үндэсний комисст, эсвэл тухайн үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж буй нутаг дэвсгэрт талуудыг бүрэн төлөөлөх эрх бүхий үндэсний хэмжээний бусад удирдах байгууллагад өргөн барина.
 - (b) Алхам 2: Үндэсний комисс эсвэл үндэсний хэмжээний эрх бүхий байгууллага уг хүсэлтийг дэмжих эсвэл үл дэмжих тухай хяналт шалгалт

явуулж, “Баталгааны анкет”-ыг ашиглан санал болгож буй хүсэлтийг Нарийн бичгийн дарга нарын газарт илгээнэ. Санал болгосон үйл ажиллагаа эхлэхээс гурван сарын өмнө хүсэлтийг Нарийн бичгийн дарга нарын газарт өргөн барьсан байна.

- (c) Алхам 3: Илгээсэн хүсэлтүүдийг Нарийн бичгийн дарга нарын газар одоо мөрдөгдөж буй удирдамжийн 14 дүгээр хэсэгт заасан шалгуурын дагуу үнэлж, сонгоно.
- (d) Алхам 4: Нарийн бичгийн дарга нарын газар бүх хүсэлтэд хариу өгнө. Батлагдсан хүсэлтүүдийн хувьд уг хүсэлт гаргагчид Нарийн бичгийн дарга нарын газраас дан бэлгэ тэмдэг, Брэнд гарын авлага бүхий электрон файлийг илгээнэ. Энэ талаар холбогдох Үндэсний комисс эсвэл эрх бүхий үндэсний байгууллага, Байнгын төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.
- (e) Алхам 5: Нарийн бичгийн дарга нарын газар бэлгэ тэмдгийг ашигласан талаар тайлан илтгэл бэлтгэн хороо болон талуудын бага хурлын хуралдаан бүрд өргөн барина.

VI. Хос бэлгэ тэмдгийн эрх авах

- 17. Санхүүгийн дэмжлэг, гэрээний зохицуулалт, дэмжлэг үзүүлэх тусгай үйл ажиллагааны хүрээнд хос бэлгэ тэмдэг ашиглах зөвшөөрлийг гагцхүү Ерөнхий захирал олгох эрхтэй.
- 18. ЮНЕСКО өөрийн хүлээх ёс суртахууны үүргийн хүрээнд үйл ажиллагаанд нь шууд хамаардаггүй, санхүүгийн туслалцаа үзүүлдэггүй, эрх зүйн үүрэг хариуцлага хүлээх чадамжгүй байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлж болно. Санхүүгийн тусламж нь цаг хугацааны хувьд хязгаартай бөгөөд олон улсын, бүс нутгийн, үндэсний хэмжээний, мөн соёлын илэрхийллийн олон төрлийн өргөн хүрээг хамарсан, мөн уран бүтээлч, соёлыг үйлдвэрлэгч, бодлого боловсруулагч болон иргэний нийгмийг хамарсан тусгай үйл ажиллагаанд зориулан олгогдоно. Энэ үйл ажиллагаанд тоглолт, үзэсгэлэн, соёлын үйлдвэрлэлийн наадам, кино, ном, хөгжмийн чиглэлийн үзэсгэлэн худалдаа зэрэг багтана. Санхүүгийн дэмжлэгийг мөн тусгай аудио дүртс бүтээл, хэвлэл (хэвлэмэл болон электрон), түүнчлэн бага хурал, хурал гэх мэт олон нийтийн арга хэмжээнд зориулан олгож болно.
- 19. Санхүүгийн дэмжлэг авах зорилготойгоор хос бэлгэ тэмдэг ашиглах хүсэлтийг тухайн тал болон талуудыг төлөөлж ЮНЕСКО-ийн Үндэсний комисс эсвэл уг төлөвлөсөн үйл ажиллагааг явуулах газар нутаг дээрх талуудаас томилсон эрх бүхий үндэсний байгууллагаар баталгаажуулан ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд өргөн барина.
- 20. Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сангийн дэмжлэг авч буй төслүүд (цаашид “СОТДОУС-аас санхүүжиж буй төсөл” гэх) нь СОТДОУС-ийн хороогоор баталгаажсан байна.
- 21. СОТДОУС-аас санхүүжиж буй төслийг хороогоор баталгаажуулсны дараа ЮНЕСКО-гийн “Засгийн газар хоорондын газруудад хуваарилах гэрээ”-ээр баталгаажуулан гарын үсэг зурна. Ингэснээр гэрээнд заасан нөхцөлийн дагуу СОТДОУС-аас санхүүжиж буй төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хос бэлгэ тэмдгийг авч ашиглах боломжтой болох юм.
- 22. Түншлэлийн хэлэлцээрийг ЮНЕСКО, түншлэгч талууд хэлэлцэж батална.

Түншлэгч талууд гэдэгт конвенцын зорилго, зарчмыг нэвтрүүлэн, олон улсын, бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвشلүүд, иргэний нийгэм зэрэг багтана.

23. Түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд хос бэлгэ тэмдэг ашиглах эрхийг ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газар олгоно.
24. Сан бүрдүүлэх үйл ажиллагааг гагцхүү СОТДОУС-д зориулан хандив цуглуулах зорилго бүхий конвенцын оролцогч талууд (төрийн, хувийн, иргэний нийгэм) эрхлэн явуулна.
25. Сан бүрдүүлэх үйл ажиллагаанд хос бэлгэ тэмдгийг ашиглахдаа ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газраас эрх авна.
26. Арилжааны зориулалтаар ашиглах гэдэг нь гол төлөв ашиг олох зорилгоор ЮНЕСКО-ийн нэр, товчлол, лого, интернет домэйн нэрийг ашиглан бараа арилжих, үйлчилгээ явуулах явдал юм.
27. Хос бэлгэ тэмдгийг арилжааны зориулалтаар ашиглах хүсэлтээ Үндэсний комисс эсвэл тусгайлан томилогдсон үндэсний хэмжээний эрх бүхий бусад байгууллагад илгээсэн хүсэлтийн хамт ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд илгээж бичгээр хариу авна.

VII. Бэлгэ тэмдгийг арилжааны зорилгоор ашиглан СОТДОУС-д хандив өргөх

28. Бэлгэ тэмдгийг арилжааны зориулалтаар ашиглан ашиг олсон тохиолдолд ашгийн тодорхой хувийг СОТДОУС-д хандивлах үүрэг хүлээнэ.
29. СОТДОУС-д хандивлах хувийг СОТДОУС-ийн тусгай дансны Санхүүгийн дүрмийн дагуу зохицуулна.

VIII. Хамгаалах

30. ЮНЕСКО-ийн нэр, товчлол, логог Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцын 6 дугаар зүйлд заасны дагуу Парисын холбооны гишүүн улсууд хүлээн зөвшөөрч, нийтэд мэдээлсэн бөгөөд 1883 онд батлан, 1967 онд Стокгольмд шинэчлэн баталсан. Уг конвенцын бэлгэ тэмдгийг Дэлхийн оюуны өмчийн байгууллагад (ДОӨБ) [өргөн барьж], Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцын 6 дугаар зүйлд заасанчлан Парисын холбооны гишүүн улсууд [хүлээн зөвшөөрч, нийтэд мэдээлэн], 1883 онд баталж 1967 онд шинэчлэн баталжээ. Конвенцын бэлгэ тэмдэг, ЮНЕСКО-ийн нэр, товчлол, логог итгэл эвдэн хуурамчаар ашиглах болон өөр ямар нэгэн хохирол учруулах байдлаар ашиглахаас урьдчилан сэргийлэхийн тулд ЮНЕСКО Парисын конвенцын гишүүн улсуудын дотоодын системд оролцоно.
31. Талууд бэлгэ тэмдгийг ашиглах эрх бүхий байгууллагуудын нэр, хаягийг ЮНЕСКО-д мэдээлэх үүрэгтэй.
32. Онцгой нөхцөлд, конвенцын албан ёсны байгууллагууд ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд конвенцын бэлгэ тэмдгийг зохистой ашиглаж буй эсэхэд хяналт тавих, хор хохиролтойгоор ашиглаж байна хэмээн үзвэл шүүн хэлэлцэх тухай хүсэлт гаргана.
33. ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал конвенцын бэлгэ тэмдгийг олон улсын түвшинд зөвшөөрөлгүйгээр ашиглах явдлыг шүүн хэлэлцэх үүрэгтэй. Конвенцод нэгдсэн талууд өөр өөрийн оронд бэлгэ тэмдгийг конвенцын

хууль ёсны гишүүн болоогүй ямар нэгэн бүлэг эсвэл ямар нэгэн зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлж болох бүхий л арга хэмжээг авна.

34. Нарийн бичгийн дарга нарын газар болон талууд үндэсний хэмжээнд конвенцын бэлгэ тэмдгийг ямар нэгэн зөвшөөрөлгүй ашиглахаас урьдчилан сэргийлж, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй удирдамжийг мөрдөж буй эрх бүхий үндэсний хэмжээний байгууллагуудтай хамтран ажиллана.

Конвенцыг дижитал орчинд хэрэгжүүлэх тухай удирдамж

Талуудын бага хурлын зургаадугаар чуулганаар батлав (2017 оны зургадугаар сарын 12-15, Парис)

1. Үндсэн зарчим

1. Эдгээр удирдамж нь соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээж, үйлдвэрлэж, түгээн дэлгэрүүлж, хэрэглэж, цахим хэлбэрээр хадгалдаг дижитал орчинд Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенцыг ойлгох, тайлбарлах, хэрэгжүүлэх стратегийн суурь зохицуулалт болох юм. Эдгээр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь соёлын илэрхийллийг тухайлбал, компьютерийн программ, сүлжээ, текст, видео, зураг, аудио бичлэгээр дамжуулан түгээнэ. Мөн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дижитал кодтой платформийг тасралтгүй хөгжүүлэх замаар түгэн тархаж байдаг.
2. Өвөрмөц шинж, үнэт зүйл, утга санааг тээгч соёлын үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог шинж нь дижитал орчинд өөрчлөгдөхгүй. Харин ч соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний (соёлын болон эдийн засгийн) хос мөн шинж чанарыг таних нь соёлын илэрхийллийг дижитал орчинд ашиглах, дижитал хэрэгсэл ашиглан тэдгээрийг үйлдвэрлэх боломжтой болгож байгаа хэрэг юм.
3. Дижитал орчинд бүтээх, илэрхийлэх, мэдээлэх, харилцах эрх чөлөө, хүний эрхийг хамгаалан дэмжинэ гэдэг нь хүний эрхийг эрхэмлэсэн нээлттэй интернэт орчныг дэмжиж байдаг интернетийн нэгдмэл зарчмыг дэмжиж байна гэсэн үг бөгөөд үүнийг олон талын оролцогч талуудын оролцоотойгоор тодорхойлон, бүгд ашиглах боломжтой.
4. Дэлхий дахинд дижитал технологийг авч ашиглаж байгаа үзүүлэлтүүдэд нэлээд ялгаа бий. Дижитал ялгаа нь гол төлөв улс орон дотор, улс орон хооронд, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хооронд, мөн хөгжиж буй, хөгжингүй орнуудын аль алиных нь хот, хөдөөгийн хооронд гардаг. Энэ нь соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх, үйлдвэрлэх, түгээх, дижитал орчинд нэвтрүүлэх арга замд нөлөөлж байна.
5. Нийгмийн сүлжээний асар хурдацтай тэлэлт, хэрэглэгчтэй холбоотой контент (ХХК), мэдээ баримтын тэсрэлт, загваруудыг түгээхэд гарч буй бэрхшээл, хэрэглэгчдийн гар дээрх харилцан холбоотой мультимедиа хэрэгслүүдийг өсгөн нэмэгдүүлэх зэрэг нь дэлхийн өнцөг булан бүрт байгаа бүтээлч салбарт асар ихээр нөлөөлж байна. Технологийн өөрчлөлт ч мөн шинэ оролцогч гарч ирэх, шинэ логик бий болоход хүргэж байгаа бөгөөд ялангуяа төрийн бодлого боловсруулахтай холбоотойгоор соёлын илэрхийллийн олон

төрлийг дэмжих таатай боломж, шинэ нөхцөлийг бий болгосоор байна.

6. Технологийн хувьд төвийг сахих нь конвенцын нэгэн зарчим болон батлагдсаныг санаж, эдгээр удирдамжийг бүхэлд нь конвенцтой, түүнчлэн дижитал орчинд соёлын илэрхийллийн олон төрөлд хандах хандлагыг дэмжих явдалтай холбон тайлбарлаж, хэрэглэнэ. Эдгээр удирдамж нь дижиталтай холбоотой асуудал, мэдээ мэдээлэл, харилцааны шинэ технологийн талаар тусгасан одоогийн удирдамж, конвенц дэх үүнтэй холбоотой бүхий л заалтад нэмэлт болох юм.
7. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилго 2030 хөтөлбөр, ажил хэрэг, хүний эрх, мөн олон улсын хүний эрхийн акт, зарчмуудын талаарх Нэгдсэн Үндэсний Байгууллагын Удирдах зарчимтай холбоотой энэхүү конвенц болон удирдамжуудыг хүндэтгэн дагахыг бүхий л оролцогч талуудаас хүсдэг. Эдгээр удирдамжууд нэн түрүүнд төрийн байгууллагуудад чиглэгдэнэ. Төрийн бус байгууллагууд, төрийн болон хувийн салбарын соёлын болон бүтээлч үйлдвэрлэл, түүний дотор дэлхийн хэмжээний дижитал платформууд, интернэт үйлчилгээ үзүүлэгч (ИҮЗ)-ид болон дижитал орчинд хамаарах бусад оролцогчдыг эдгээр удирдамжуудыг дагаж мөрдөхийг дэмжинэ.

Удирдах зарчим

8. Конвенцын 1 болон 2 дугаар зүйлд заасан зорилго, зарчмуудыг хэрэгжүүлснээр удирдамж дараах үр дүнд хүрэхээр зорьж байна. Үүнд:
 - 8.1 Технологийн хувьд төвийг сахих тухай конвенцын зарчмыг дахин батлах;
 - 8.2 Ямар ч арга хэрэгсэл, технологи ашиглаж байсан ч соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хосолмол (соёлын болон эдийн засгийн) мөн чанарыг дахин хүлээн зөвшөөрүүлэх;
 - 8.3 Дижитал хэрэгсэл ашиглахыг хөхиүлэн дэмжих, боловсролын хөтөлбөрөөр дамжуулан дижитал чадвар олгох;
 - 8.4 Дижитал орчинд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, дэмжих арга, бодлого боловсруулах, авч ашиглах, хэрэгжүүлэх бүрэн эрхийг талуудад дахин олгох;
 - 8.5 Интернэтийн хувьд төвийг сахих зарчмыг даган аюулгүй байдлыг хангах, интернэтийн үйлчилгээнээс мэдээллийн урсгалыг үл ялгаварлах зарчмаар, харилцан тэгш эрхтэйгээр авч ашиглах, эцсийн шатны хэрэглэгчийн эрхтэй холбоотой заалт оруулах (орон нутгийн соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалд нөлөөлдөг тусгай аппликейшнүүдийг хаах, удаашруулах эрсдэлтэй мэдээллийн урсгалын зохицуулалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор);
 - 8.6 Дижитал орчинд соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалыг тэнцвэртэй, тэгш эрхтэйгээр ашиглахыг дэмжих, ялангуяа хөгжиж буй орнуудын уран бүтээлч, соёлын мэргэжилтэн, аж ахуйн нэгж, бие даасан байгууллагуудын бүтээж, үйлдвэрлэж буй бүтээлүүдэд зориулсан хөнгөлөлт эдлүүлэх заалтуудаар дамжуулан дэмжлэг үзүүлэх;
 - 8.7 Дижитал хөтөлбөр, төслүүдэд дэмжлэг үзүүлдэг олон улсын тусламжийн хөтөлбөрийн хүрээнд болон үндэсний дижитал стратегийн

- тогтвортой хөгжлийн хүрээнд яригдаж буй эдийн засаг, боловсрол, соёлын ойлголтуудыг нэмэгдүүлэх;
- 8.8 Дижитал технологийг илүү өргөн хүрээнд ашиглах боломж олгох, холбогдох чадвар, чадавхийг хөгжүүлэх, дижитал орчинд соёлын, бүтээлч хөдөлгөөнт үйлдвэрлэлийг бий болгоход чиглэсэн механизмыг дэмжих зэрэг хөгжлийн төлөөх олон улсын хамтын ажиллагааг дэмжин ажиллах;
- 8.9 Соёлын илэрхийллийн олон төрлийг бүтээх, түгээх, ашиглах урьдчилсан нөхцөл болох хүний эрхийн бусад заалт, илэрхийлэх, мэдээлэх, харилцах, хувийн нууцаа хамгаалах үндсэн эрх чөлөөг хүндэтгэн үзэхийг дэмжин ажиллана. Үүнд илэрхийлэх эрх чөлөөний үр дүн болох уран бүтээлийн эрх чөлөө, дижитал орчинд ажиллаж буй зохиогч, уран бүтээлчдийн нийгэм, эдийн засгийн эрх, сонгон түншилж буй бүхий л түншүүдтэйгээ харилцаа холбоотой байх нөхцөлийг дэмжин ажиллах зэрэг хамаарна;
- 8.10 Дижитал орчинд хүний эрхийг хүндэтгэн үзэхийг дэмжин ажиллана. Охид, эмэгтэйчүүд дижитал орчинд соёлын илэрхийллийг бүтээгч, үйлдвэрлэгч, хэрэглэгч болон соёлын, бүтээлч үйлдвэрлэлд оролцох оролцоог нь дэмжих, үүгээр дамжуулан тэдний эрх мэдэл, жендерийн тэгш байдлыг эрхэмлэх асуудал үүнд орно;
- 8.11 Сүлжээнд холбогдоогүй байгаа хүмүүс ч мөн сүлжээнд бусадтайгаа ижил эрх эдлэх бөгөөд ялангуяа Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын хэлэлцээр, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд заасны дагуу сонгосон мэдээллийн хэрэгслээрээ дамжуулан илэрхийлэх хязгааргүй эрх чөлөө эдлэхийг баталгаажуулна.

Талууд дижитал орчинд соёлын засаглалын тогтолцоог бэхжүүлнэ

9. Конвенцын 5, 6, 7 дугаар зүйл болон эдгээр удирдамжид нийцүүлэн талууд дижитал орчинд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжихэд чиглэсэн одоогийн бодлого, арга хэмжээг шинэчилж батлахыг зорилго болгоно. Ингэхдээ нийгмийн янз бүрийн бүлэг, эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлага, түсгэй нөхцөл байдлыг зохих хэмжээгээр анхаарна.
10. Эдгээр бодлого, арга хэмжээ нь бүтээн түүрвих, үйлдвэрлэх, түгээх, дэлгэрүүлэх, хэрэглэх, таашаах бүхий л хүрээг хамрахыг зорино. Үүнд энэхүү үнэт зүйлийн гинжин хэлхээний явцад гарах томоохон өөрчлөлт, шинэ оролцогч гарч ирэх зэргийг тооцоолсон байна.
11. Соёлын илэрхийллийн олон төрөл, хэвлэл мэдээллийн хэрэгслийн дижитал орчин дахь олон төрлийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн төрийн үйлчилгээний, хувийн болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, мөн бие даасан мэдээллийн байгууллагуудын хууль эрх зүй, зохицуулалтын хүрээг шинэчлэхийг талуудад уриална. Үүнд үнэт зүйлсийн гинжин хэлхээний явцад үйл ажиллагааны нийлэмжийг тооцоолсон байна.
12. Олон нийт болон соёлын салбарын дижитал чадавхийн түвшинг нэмэгдүүлэх, дижитал орчинд соёлын илэрхийллийн олон төрлийг бүтээн түүрвих, үйлдвэрлэх, түгээх, дэлгэрүүлэх, хэрэглэх явцад гарч буй өөрчлөлтөд бүрэн дүүрэн оролцоход шаардлагатай үр чадвар, нөү-хауг дэмжин ажиллахад

талуудыг хөхиүлэн дэмжинэ.

13. Холбогдох яамд болон хүрээлэнгүүдийн төлөөлөл (соёл, судалгаа, худалдаа, үйлдвэрлэл, харилцаа холбоо, боловсролын асуудал эрхэлсэн) болон конвенцын зохицуулагч болон иргэний нийгмийн төлөөлөгчдөөс бүрдсэн дижиталтай холбоотой асуудал хариуцсан яам хоорондын бүлэг байгуулахад талуудыг хөхиүлэн дэмжинэ.
14. Талууд дижитал орчинд уран бүтээлийн цаг үеэ олсон, интерактив ажлыг оролцуулан бүтээлч байдлын шинэ хэлбэрийг бүтээн түүрвэх шатанд нь дэмжихийг зорилгоо болгоно. Үүнд үндэсний, бүс нутгийн, эсвэл орон нутгийн түвшний бодлого, хөтөлбөр, санхүүжилтийн хуваарь хамаарна. Тухайлбал:
 - 13.1 Дижитал хэрэгслүүдтэй ажиллаж буй уран бүтээлч, соёлын бусад мэргэжилтнүүдэд шууд дэмжлэг үзүүлэх;
 - 13.2 Бүтээн түүрвэх үйл ажиллагаа болон бүтээгч, гүйцэтгэгч нарыг шударгаар урамшуулахыг дэмжих;
 - 13.3 Дижитал технологи ашиглаж буй уран бүтээлч, соёлын бусад мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг гүнзгийрүүлэн дижитал орчинд илүү сайн ажилладаг болгох зорилгоор сургалтын хөтөлбөр, боловсролын хөтөлбөр шинээр боловсруулах;
 - 13.4 Урлагийн чиглэлийн хамтын ажиллагаа, туршилт явуулах боломж олгодог инкубатор, лаборатори, уран бүтээлчдийн байрсууц, сүлжээний үйл ажиллагаагаар дамжуулан олон улсын хамтын ажиллагааг дэмжих төвүүд зэрэг дижитал бүтээлч байдал, инновацийг хэрэгжүүлэхэд зориулсан орон зайг бий болгох;
 - 13.5 Соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй уран бүтээлч, боловсрол, соёлын мэргэжилтнүүдийн хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ. Үүнд загвар зохион бүтээгч, програмчин, инженер, судлаач зэрэг дижитал орчинд ажиллагсад хамаарна;
 - 13.6 Дижитал орчинд шинийг бүтээгчдийг дараах байдлаар дэмжин, бүтээлийг нь үнэлнэ. Үүнд:
 - Уран бүтээлч, урлагийн мэргэжилтнүүдийн цалин хөлс тэгш, шударга байх;
 - Дижитал борлуулагч, интернэт үйлчилгээ үзүүлэгч (ИҮҮ), хууль ёсны эрх эзэмшигч нарын дунд орлогыг хуваарилахдаа ил тод байх;
 - Зайлшгүй шаардлагатай нөөцийг ашиглах;
 - Хамтын менежмент хийх, боломжтой бол дижитал эрхийн гэрээ хэлэлцээрийг хамтран хийж зөвшөөрөл олгох зэргээр оюуны өмчийн эрхийг хамгаалах, хүндэтгэх; мөн
 - Бүтээлээ баримтжуулах, архивлах хууль эрх зүйн цахим тогтолцоог бий болгох.
15. Талууд соёлын болон бүтээлч үйлдвэрийг орчин үеийн болгон шинэчлэхэд үйлдвэрлэх шатанд нь дэмжлэг үзүүлэхийг зорино. Дижитал орчинд соёлын илэрхийллийг үйлдвэрлэхтэй холбоотой арга хэмжээнүүд дараах зорилготой байна. Үүнд:
 - 15.1 Соёлын болон бүтээлч үйлдвэрийн үйлдвэрлэх үйл явцад, ялангуяа бичил, жижиг, дунд хэмжээний аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагуудын дунд технологийн хэрэгсэл нэвтрүүлэх, дижитал

болгох явдлыг дэмжих;

- 15.2 Дижитал орчинд үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх сонирхолтой соёлын салбарын бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллагууд, орон нутгийн үйлдвэрлэл эрхэлдэг компаниуд эсвэл инкубаторуудад дэмжлэг үзүүлэх;
 - 15.3 Дижитал орчинд соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийг санхүүжүүлэх шинэ хэлбэрийг дэмжих, дижитал орчинд төрийн болон хувийн салбаруудын түншлэлийн шинэ хэлбэрийг хөхиүлэн дэмжих;
 - 15.4 Судалгаа, боловсруулах ажилд дижитал технологи ашиглаж буй уран бүтээлчдийн нийгэмд тустай, харилцааны шинэ хэрэгсэл бий болгоход гүйцэтгэж буй үүргийг үнэлэх.
16. Талуудыг дижитал орчинд бүтээлээ түгээхийг нь дэмжих, таатай боломж олгох, орон нутагт дижитал зах зээл бий болж, хөгжихөд нь түгээн дэлгэрүүлэх шатанд нь дэмжлэг үзүүлэхийг зорилго болгоно. Үнэт зүйлийн гинжин хэлхээний энэ шатанд баримтлах арга хэмжээнүүд дараах зорилготой:
- 16.1 Соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг түгээх дижитал түгээгч, дижитал оролцогч нар (цахим платформ, интернэт үйлчилгээ үзүүлэгч (ИҮҮ), хайлтын программууд, нийгмийн сүлжээ)-ыг багтаасан дижитал мэдээллийн хэрэгслийн олон төрлийг хөхиүлэн дэмжих, түүнчлэн үндэсний болон орон нутгийн соёлын контентийг илрүүлэх, олны хүртээл болгох;
 - 16.2 Мэдээ баримт цуглуулах, ашиглах ил тод байдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор төрийн байгууллага, хувийн салбарын үйлчилгээ үзүүлэгчдийн хоорондын харилцааг дэмжин ажиллах, дижитал орчинд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах дүрэм журам гаргахыг дэмжих, орон нутагт соёлын бүтээл бүтээх, ашиглах боломжийг дэмжих;
 - 16.3 Соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг түгээх янз бүрийн дижитал орчин бий болгох зорилгоор мета-өгөгдөл, интерфейс, программ хангамж, протокол, форматын болон электрон харилцааны сүлжээ, үйлчилгээг стандартчилах, харилцан үйлчлэлд оруулах;
 - 16.4 Цахим худалдааг дэмжих, хамгаалах зорилгоор цахимаар шилжүүлэх механизм, үйл явцыг тохируулах, орчин үеийн болгон шинэчлэх;
 - 16.5 Дижитал орчинд, ялангуяа хөгжиж буй орнуудын дижитал орчинд соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ солилцохдоо шударга, ил тод, тогтвортой, ёс зүйтэй худалдаа хийхийг хөхиүлэн дэмжих;
 - 16.6 Соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимаар түгээх хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үүнд зохиогчийн эрх болон холбогдох эрхүүдийн талаарх олон улсын гэрээ хэлэлцээрийг соёрхон батлах, соёлын бараа бүтээгдэхүүний хууль бус цахим наймаа, зохиогчийн эрхийг зөрчих хууль бус ажиллагаанаас хамгаалах арга хэмжээ, гэрээний зохицуулалт хамаарна;
 - 16.7 Соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимаар түгээх болон контентийг илүүтэй тараах явдлыг сайжруулах зорилгоор цахим платформ (видео, аудио болон бусад хэрэгсэл), эдгээр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний (лицензийн хэлэлцээр, техник хэрэгслийг байршуулах гэх мэт) хууль ёсны эрхийг эзэмшигч нарын хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих.

17. Талууд соёлын илэрхийллийн олон төрлийг үнэгүй, тогтмол ашигладаг, мөн дижитал орчинд соёлын амьдралд илүү их оролцоотой болгохын тулд хүртээмжийн шатанд анхаарч ажиллахыг зорилго болгоно. Үүнд соёлын бараа бүтээгдэхүүний олон төрөл, нөү-хау, дижитал технологийг байнгын ашиглах боломжийг бүрдүүлэх арга хэмжээнүүд хамаарах бөгөөд дараах зорилготой:
 - 17.1 Хэрэглэгчдэд контент хүргэхийг тодорхойлж буй дижитал механизмаар (алгоритмыг санал болгох) соёлын илэрхийллийн өргөн хүрээний цахим орчин дахь нийлүүлэлтийг хангахын тулд индексжүүлэлт болон контентийн лавлагааны горимыг ил тод, тодорхой болгох;
 - 17.2 Дижитал орчинд соёлын илэрхийллийн олон төрлийг хэрэглэх явдлыг сайжруулахын тулд харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх, бэхжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх;
 - 17.3 Дижитал орчинд асар хурдацтай байнгын хувьсал гарч байгаа хэдий ч соёлын контентийг дэлхий нийтээр тасралтгүй ашиглах дэд бүтцийг хөгжүүлэх болон дижитал хадгалалтын аргыг хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжих;
 - 17.4 Дижитал орчинд хэл шинжлэлийн олон төрөл, орчуулгын интерфэйсийг дэмжин хөгжүүлэх;
 - 17.5 Соёлын илэрхийллийн олон төрлийг цахимаар ашиглах боломжоор хангадаг төрийн соёлын байгууллагуудыг дэмжин ажиллах;
 - 17.6 Сургууль, номын сан, соёлын төв зэрэг төрийн байгууллагуудад шаардлагатай байгаа дижитал тоног хэрэгслүүдийг нийлүүлэх;
 - 17.7 Дижитал бичиг үсэгт тайлагдах, интернэт болон дижитал тоног хэрэгсэл эзэмших, ашиглах ойлголттой болох, нийтийн боловсрол эзэмших программ нэвтрүүлэх;
 - 17.8 Хууль ёсны эзэмшигчдэд шударга цалин хөлс олгох хууль эрх зүйн арга хэмжээнүүдийг хөхиүлэн дэмжих.

Соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалын тэнцвэрт байдлыг хангах

18. Олон улсын эв санааны нэгдэл, хамтын ажиллагааны хүрээнд талууд конвенцын 16 дугаар зүйлд нийцүүлэн хөгжиж буй орнуудын соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалыг дижитал орчинд илүү тогтвортой болгох чиглэлд хөнгөлөлттэй нөхцөл эдлүүлэхээр заалт оруулахыг зорилго болгоно. Тухайлбал талууд:
 - 18.1 Урлаг, соёлын хамтын ажиллагаа, хамтарсан үйлдвэрлэл, хамтран борлуулах хэлэлцээрээр дамжуулан хөгжиж буй орнуудын уран бүтээлч, соёлын мэргэжилтэн, аж ахуйн нэгж, бие даасан байгууллагуудын үйлдвэрлэсэн дижитал орчин дахь соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг сайжруулах;
 - 18.2 Олон улсын худалдааны хэлэлцээрийн одоогийн болон цаашид нэмж орох заалтууд, хөгжиж буй орнуудаас дижитал орчинд орж ирж буй соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээр хөнгөлөлттэй нөхцөл олгох механизмуудыг авч хэлэлцэж болно.
19. Дижитал орчны соёл, худалдаа, хөрөнгө оруулалтын орон зайд нэгдсэн

хандлагыг бий болгоход дэмжлэг үзүүлэх, конвенцын зорилго, зарчмуудыг түгээн дэлгэрүүлэх зорилготой конвенцын 21 дүгээр зүйлээр хүлээсэн үүргийнхээ дагуу талууд дараах зүйлсийг дэмжин ажиллана. Үүнд:

- 19.1 Дижитал орчин дахь соёлын илэрхийллийн олон төрөлд зориулсан янз бүрийн хууль эрх зүйн арга хэрэгслүүд нэмэгдэх, харилцан уялдаатай байх;
- 19.2 Дижитал орчин дахь соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд нөлөөлөх хоёр талын, бүс нутгийн, олон талын хэлэлцээрийн ил тод байдал;
- 19.3 Соёл, худалдаа хариуцсан үндэсний хэмжээний эрх бүхий байгууллагууд, холбогдох бусад төрийн байгууллага, нэгжүүд, иргэний нийгмийн төлөөлөгчдийн хоорондын нягт уялдаа холбоо;
- 19.4 Олон улсын түвшний хоёрталын, бүс нутгийн болон олон талт хэлэлцээрт соёлын тухай заалт оруулах, тухайлбал, соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хос шинж чанарыг авч үзсэн заалт оруулах. Үүнд соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг таниулах цахим худалдааны статусыг онцгойлон анхаарсан хөнгөлөлттэй нөхцөл эдлүүлэх заалт хамаарна;
- 19.5 Худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээрт тусгасан дижитал орчны талаар ойлгомжтой тодорхой нэмэлт тайлбарыг конвенц болон эдгээр удирдамжид нэмж оруулах, түүнчлэн шаардлагатай тохиолдолд төрийн шинэ бодлого боловсруулах чадавх нөөцлөх зэргээр хэрэгжүүлэх боломжтой заалтууд оруулах.

Соёлыг тогтвортой хөгжлийн хүрээнд нэгтгэх нь

20. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030, Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ууд, конвенцын 13, 14 дүгээр зүйлд заасны дагуу талууд соёлын асуудлуудын ач холбогдол хийгээд дижитал орчинд тогтвортой хөгжлийн нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны хэм хэмжээг чухалчлан үзсэн үндэсний хөгжлийн бодлого, олон улсын тусламжийн хөтөлбөр боловсруулах боломжтой.
21. Талууд мэдээлэл, харилцааны технологийн төлөвлөгөө, дижитал стратегийн хөгжилд соёлыг нэгтгэн, конвенц болон конвенцын зорилго, зарчимд нэмэлт оруулна.
22. Талууд чадавх дээшлүүлэх үйл ажиллагаа, тогтвортой технологи (програм болон техник хангамж), нөү-хауг нэвтрүүлэх, мөн дэд бүтэц хөгжүүлэх асуудлыг үндэсний болон олон улсын түвшинд дэмжин ажиллана.
23. Үндэсний түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээ дараах зорилготой байна. Үүнд:
 - 23.1 Орон нутгийн соёлын контентийн ойлголтыг нэмэгдүүлэх, хэрэглээг дэмжих, улмаар дижитал орчинд хэрэгжих боломжтой соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийг орон нутгийн, бүс нутгийн, үндэсний түвшинд хөгжүүлэхийг дэмжих;
 - 23.2 Соёлын нөөцийг хуваарилахад газар зүйн тэнцвэрт байдал, конвенцын 7 дугаар зүйлд заасан хувь хүний болон нийгмийн янз бүрийн бүлгүүдэд зориулсан нөөцийг тэгш хүртэх боломжийг олгохын тулд технологийн тусгай хэрэгцээг үнэлэх;
 - 23.3 Дижиталтай холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа бусад яамдын хөтөлбөрт соёлын асуудлыг нэгтгэхийн тулд яам хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих;

- 23.4 Боловсрол, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, судалгаа, хот төлөвлөлт зэрэг бусад салбарт дижитал орчныг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх, боловсронгуй болгох.
24. Олон улсын түвшинд явуулах арга хэмжээ хөгжиж буй орнуудыг дараах байдлаар дэмжих зорилготой:
- 24.1 Соёлын хамтын ажиллагааны гэрээ хэлцлийг шинэчлэх, ингэснээр ялангуяа хамтын бүтээл түүрвх, хамтран борлуулалт хийх гэрээ хэлэлцээрийг байгуулахдаа дижитал технологийн үр нөлөөг тооцоолох;
- 24.2 Бүтээгчдийн хоорондын орон зайг үл харгалзан сүлжээнд оруулах үрлагийн бүтээлийг хамтран үйлдвэрлэх, түгээхийг хөнгөвчлөх зорилготой хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг хөгжүүлэх;
- 24.3 Доод шатнаас гарах соёлын хамтын ажиллагааны санаачлагыг тэргүүн эгнээнд тавих. Үүнд орон нутгийн оролцогчид буюу багахан хэмжээний хандиваар санхүүжих төдий дээд шатнаас гаргасан санаачилга (тоног хэрэгсэл, программ хангамж, контент, холбоо) орно;
- 24.4 Интернет, дижитал хэрэгслийг ашиглах тухай ойлголтыг олон нийтэд хүргэх боловсролын үйл ажиллагаа явуулан дижитал орчинд соёлын контент, нөөцийг тэгш хүртэх нөхцөлөөр хангах;
- 24.5 Ялангуяа Соёлын олон төрлийг дэмжих олон улсын санд сайн дурын татвар байнга өгөх хэлбэрээр дижитал орчинд конвенцыг хэрэгжүүлэхтэй холбоотой төслүүдийг дэмжих.

Иргэний нийгмийн үүрэг

25. Конвенцын 11 дүгээр зүйл, түүний удирдамжид заасанчлан иргэний нийгмийн байгууллагатай цахим орчинд дижитал ертөнцийн хувьслыг хянахад хувь нэмрээ оруулахын тулд түншлэх нь нэн чухал. Түншлэл нь дараах хэлбэртэй байж болно:
- 25.1 Дижитал технологи (нийтийн сүлжээ, хөдөлгөөнт аппликейшн, цахим хэлэлцүүлгийн платформ) хэрэглэх, үйл ажиллагаа зохион байгуулах, харилцааны хэрэгсэл бүтээх (дундын ажлын платформ, интерактив солилцооны платформ, блог, мэдээллийн цахим бюллетин) зэргээр дижитал орчны чадавхийн талаар илүү их ойлголттой болох тал дээр санаачлага гаргах;
- 25.2 Соёлын салбарын оролцогчидтой дижиталын асуудлаар зөвлөлдөн үр дүнг талуудын бага хурал болон Засгийн газар хоорондын хороонд бичгээр (мэдээллийн баримт бичгүүд) болон аман хэлбэрээр хүргүүлж конвенцын удирдах байгууллагуудтай хуваалцахад идэвх зүтгэл гаргах;
- 25.3 Дижитал технологиос үүдэлтэй уран бүтээлч, соёлын бусад мэргэжилтэн, дадлагажигч нарт гарч ирэх боломж бололцоо, тулгамдаж буй сорилт бэрхшээлийг агуулсан холбогдох мэдээллийг гаргаж өгөх замаар талуудын зүгээс дөрвөн жил тутамд өргөн барьдаг тайланг бэлтгэхэд идэвхтэй оролцох;
- 25.4 Дижитал орчин дахь соёлын илэрхийллийн олон төрөлтэй холбоотой асуудалд шууд болон шууд бусаар анхаарлаа хандуулах, бусад олон улсын байгууллагуудад нөлөөлөх зорилгоор уран бүтээлч, соёлын мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач, шинжээч зэрэг иргэний нийгмийн төлөөллүүд хамтран ажиллах.

Мэдээ мэдээлэл, шилдэг туршлага хуримтлуулах, хуваалцах

26. Конвенцын 9 болон 19 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхдээ талууд:
 - 26.1 Дижитал орчинд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, дэмжихтэй холбогдсон боломж бололцоо, сорилт бэрхшээлд чиглэсэн бодлогын талаар дөрвөн жил тутамд өргөн барьдаг тайландаа системтэйгээр дурдах;
 - 26.2 Дижитал орчин дахь соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл, практик, хэрэглээний талаар харьцуулсан статистикийн мэдээ цуглуулахыг хөхиүлэн дэмжих;
 - 26.3 Хөгжиж буй орнуудад дижитал орчин дахь соёлын илэрхийллийн олон төрөлд чиглэсэн боломж бололцоо, хүндрэл бэрхшээлийн талаар хэлэлцүүлэг явуулах, шилдэг туршлагаа хуваалцах зэрэгт анхаарна.

ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг

27. Конвенцын 19 дүгээр зүйлд заасанчлан Нарийн бичгийн дарга нарын газар холбогдох олон улсын байгууллага, иргэний нийгэм, талуудтай салбар хоорондын харилцаатай байж, хамтран:
 - 27.1 Дижитал орчинд соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнчлэн энэ чиглэлийн технологийн хөгжлийн талаарх мэдээ мэдээлэл, статистикийн мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх;
 - 27.2 Мэдлэгийн менежментийн системийн тусламжтайгаар шилдэг туршлагын жагсаалт гарган хадгалах;
 - 27.3 Дижитал технологи, ялангуяа худалдаа, оюуны өмч, харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын бусад оролцогчидтой хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, конвенцыг илүү их ойлгуулан таниулах, конвенцын бүхий л оролцогч талуудтай мэдээлэл хуваалцах зорилгоор талууд болон иргэний нийгэмтэй хэлэлцүүлэг өрнүүлэх;
 - 27.4 Цахим орчинд соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжихэд гарч буй боломж бололцоо, тулгамдаж буй сорилт бэрхшээлийн талаар талуудын хооронд хэлэлцүүлэг өрнүүлэх, удирдах байгууллагуудад мэдээлэх зэргийг дэмжинэ.

3

2005 ОНЫ КОНВЕНЦОД ОРОЛЦОГЧ
ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

2005 оны конвенцод оролцогч талуудын Бага хурлын Үйл ажиллагааны дүрэм

Конвенцод оролцогч талуудын Бага хурлын анхдугаар чуулганаар (2007 оны 6-р сарын 18-20, Парис) батлан, хоёрдугаар чуулганаар (2009 оны 6-р сарын 15-26, Парис) нэмэлт өөрчлөлт оруулав.

I. Оролцоо

Дүрэм 1 – Үндсэн оролцогчид

2005 оны 10-р сарын 20-ны өдөр хуралдсан Ерөнхий бага хурлын чуулганаар баталсан Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенцын (цаашид “конвенц” гэх) оролцогч талуудын төлөөлөгчид талуудын Бага хуралд (цаашид “Бага хурал” гэх) санал өгөх эрхтэйгээр оролцож болно.

Дүрэм 2 – Ажиглагчид

- 1.1 Конвенцод нэгдээгүй ЮНЕСКО-ийн гишүүн улсуудын төлөөлөгчид, ЮНЕСКО-ийн байнгын ажиглагч төлөөлөгч нар дүрмийн 9.3-д зааснаар Бага хурлын үйл ажиллагаанд санал өгөх эрхгүйгээр ажиглагчаар оролцож болно.
- 1.2 Нэгдсэн Үндэстний Байгууллага, Нэгдсэн Үндэстний системийн байгууллагуудын төлөөлөгчид болон ЮНЕСКО-той хоёр талын төлөөллийн хэлэлцээр байгуулсан Засгийн газар хоорондын бусад байгууллагууд дүрмийн 9.3-д зааснаар санал өгөх эрхгүйгээр Бага хурлын үйл ажиллагаанд оролцож болно.
- 1.3 Дүрмийн 2.2-т дурдсанаас бусад засгийн газар хоорондын байгууллага, конвенцод хамаарах салбарыг сонирхон, үйл ажиллагаанд нь оролцож буй төрийн бус байгууллагуудыг дүрмийн 9.3-д зааснаар санал өгөх эрхгүйгээр Бага хурлын үйл ажиллагаа, түүний бүх хуралдаан, аль нэг хуралдаан, эсвэл хуралдааны аль нэг онцгой хуралдаанд ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд бичгээр хүсэлт гаргасны үндсэн дээр ажиглагчаар урьж оролцуулж болно.

II. Бага хурлын зохион байгуулалт

Дүрэм 3 – Бага хурлын чуулган

Бага хурал нь хоёр жил тутамд ээлжит чуулганаа зарлан хуралдуулна. Бага хурал нь өөрөө шийдвэр гарган эсвэл Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих Засгийн газар хоорондын хороо (цаашид “Хороо” гэх) доод тал нь талуудын гуравны нэгээс хуралдуулах хүсэлт хүлээн авсан тохиолдолд ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно.

Дүрэм 4 – Хэлэлцэх асуудлын урьдчилсан хөтөлбөр

Бага хурлын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын урьдчилсан хөтөлбөрт дараах асуудлууд багтана. Үүнд:

- (a) Конвенц болон мөрдөж буй дүрэмтэй холбоотой аливаа асуудал;
- (b) Өмнөх Бага хурлын чуулганаар шийдвэрлэсэн аливаа асуудал;
- (c) Хороонд хамаарах аливаа асуудал;

- (d) Конвенцын талуудын зүгээс өргөн барьсан аливаа асуудал;
- (e) Ерөнхий захирлын зүгээс өргөн барьсан аливаа асуудал.

Дүрэм 5 – Удирдах гишүүдийг сонгох

Бага хурал нь дарга, нэг болон түүнээс дээш тооны дэд дарга, илтгэгч нарыг сонгоно.

Дүрэм 6 – Даргын хүлээх үүрэг

- 5.1 Дарга нь одоо мөрдөж буй дүрмийн хүрээнд олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн сацуу Бага хурлын ээлжит чуулган бүрийг нээх, хаах үүрэгтэй. Тэрээр хуралдааны хэлэлцүүлгийг чиглүүлж, энэхүү дүрмийн хэрэгжилтийг хянаж, үг хэлэх зөвшөөрөл өгөх, санал өгөх асуултуудыг оруулж, шийдвэрүүдийг зарлана. Мөн хурлын дэгийг баримтлуулж одоо үйлчилж буй дүрмийн дагуу хурлын үйл явцыг удирдан хянана. Тэрээр санал өгөх эрхгүй боловч өөрийн төлөөлөгчдөөс төлөөний хүнийг томилж санал өгүүлж болно.
- 5.2 Дарга аливаа хуралдаан эсвэл хуралдааны зарим хэсэгт оролцох боломжгүй тохиолдолд түүнийг дэд дарга орлоно. Даргын үүргийг гүйцэтгэж буй дэд дарга даргатай нэгэн адил эрх, үүрэг хүлээнэ.

III. Хурлын үйл ажиллагааг удирдан явуулах

Дүрэм 7 – Хурлын олон нийтэд ил тод байдал

Бага хурлаас өөрөөр шийдвэрлээгүй тохиолдолд хурлын үйл ажиллагааг олон нийтэд ил тод явуулна.

Дүрэм 8 – Хурлын ирц

- 7.1 Дүрэм 1-д дурдсан талуудын дийлэнх олонх Бага хуралд оролцсоноор ирцийг бүрдүүлнэ.
- 7.2 Хурлын ирц бүрдээгүй тохиолдолд аливаа асуудлыг хэлэлцэн Бага хурлаар шийдвэр гаргахгүй.

Дүрэм 9 – Үг хэлэх дараалал ба цагийн хязгаар

- 8.1 Үг хэлэх хүсэлт гаргасан дарааллын дагуу дарга үг хэлэх нэрсийг дуудна.
- 8.2 Хэлэлцүүлгийн цагийг баримтлуулахын тулд дарга үг хэлэх хүн тус бүрд цагийн хязгаарыг тогтоож болно.
- 8.3 Ажиглагч Бага хуралд үг хэлэх хүсэлт гаргах бүрт даргын зөвшөөрлийг авна.

Дүрэм 10 – Хурлын дээ

- 9.1 Хэлэлцүүлгийн үеэр аливаа талын төлөөлөгч хурлын дэгийн асуудлаар санал гаргаж болно. Ийм саналыг дарга шууд шийдвэрлэнэ.
- 9.2 Даргын удирдан зохицуулалтын эсрэг санал гомдол гаргаж болно. Ийм тохиолдолд уг санал гомдлоор нэн даруй санал хураалт явуулах бөгөөд санал хураалтад оролцсон талуудын дийлэнх олонхоор дэмжигдээгүй тохиолдолд даргын шийдвэр хүчинтэй хэвээр үлдэнэ.

Дүрэм 11 – Горимын санал

- 10.1 Хэлэлцүүлгийн үеэр аливаа талын төлөөлөгч хурлыг түр зогсоох, хойшлуулах, эсвэл хэлэлцүүлгийг түр хойшлуулах, хаах санал гаргаж болно.

10.2 Ийм саналаар нэн даруй санал хураалт явуулна. Дүрмийн 10.1-р заалтын дагуу ийм саналыг хуралдааны өмнөх бусад санал, хүсэлтийг дагаж мөрдөхийн тулд дараах дарааллыг баримтална. Үүнд:

- (a) Хурлыг түр зогсоох;
- (b) Хурлыг түр хойшлуулах;
- (c) Хэлэлцэж буй асуудлаарх хэлэлцүүлгийг түр хойшлуулах;
- (d) Хэлэлцэж буй асуудлаарх хэлэлцүүлгийг хаах.

Дүрэм 12 – Ажлын хэл

11.1 Бага хурлын ажил хэрэг явуулах хэл нь араб, хятад, англи, франц, орос, испани хэл байна.

11.2 Бага хурлын илтгэл эдгээр ажлын хэлний аль нэгээр явагдаж буй бол бусад хэл рүү орчуулна.

11.3 Илтгэгчид илтгэлээ эдгээр хэлнүүдийн аль нэгээр орчуулагдахаар зохицуулан өөр хэлээр илтгэлээ тавьж болно.

Дүрэм 13 – Шийдвэр ба нэмэлт өөрчлөлт

12.1 Шийдвэрийн төсөл, нэмэлт өөрчлөлтийг Дүрмийн 1-д дурдсан талуудаас өргөн барих бөгөөд Бага хурлын Нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр илгээж бүх оролцогчдод хувилан тараана.

12.2 Ерөнхий дүрмийн дагуу Бага хурлын ажлын хэл дээр үйлдэж бүх оролцогчдод урьдчилж тараагдаагүй аливаа шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал хураалт явуулахгүй.

Дүрэм 14 – Санал хураалт

13.1 Дүрмийн 1-д дурдсан тал тус бүрийн төлөөлөгч Бага хуралд нэг саналын эрхтэй байна.

13.2 Конвенцын 27.3 (б) дүгээр зүйлд заасанчлан бүс нутгийн эдийн засгийн интеграцийн байгууллагууд бүрэн эрхийнхээ хэмжээнд энэхүү конвенцэд нэгдсэн талууд болох гишүүн улсуудын тоотой тэнцүү хэмжээний санал өгөх эрх эдэлнэ. Харин гишүүн улсуудын аль нэг нь эрхээ эдэлж саналаа өгч байгаа тохиолдолд эдгээр байгууллагууд өмнөөс нь санал өгөх эрх эдлэхгүй.

13.3 Дүрмийн 8.2, 21, 22-р заалтуудыг баримтлан санал өгч байгаа талуудын дийлэнх олонхийн саналаар шийдвэрийг батлана.

13.4 Одоогийн дүрмийн зорилгын дагуу “Санал өгч байгаа талууд” гэдэг нь зөвшөөрсөн, татгалзсан санал өгч байгаа талууд гэж ойлгоно. Санал өгөхөөс түдгэлзэж байгаа талууд гэдэг нь санал өгөхгүй байгаа гэсэн үг юм.

13.5 Дарга санал хураалт эхэлснийг зарласны дараа санал хураалтыг удирдан явуулахтай холбоотой дэг алдагдахаас өөрөөр ямар ч тохиолдолд хэн ч санал хураалтыг тасалдуулж үл болно.

13.6 Хорооны гишүүдийг сонгохоос бусад ямар ч тохиолдолд санал хураалтыг гар өргөж явуулна.

13.7 Гар өргөж санал хураасан дүн эргэлзээтэй гэж үзвэл, дарга нэр дуудаж хоёр дахь санал хураалтыг явуулна. Санал хураалт явагдахаас өмнө хоёроос

багагүй төлөөлөгч хүсэлт гаргасан тохиолдолд анхнаас нь нэр дуудаж санал хураалт явуулж болно.

- 13.8 Саналд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд уг нэмэлт өөрчлөлтөд эхэлж санал хураана. Саналд хоёр болон түүнээс дээш нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд Бага хурал эх саналд нэмж оруулахаар даргын өргөн барьсан нэмэлт өөрчлөлтөд эхэлж санал хураана. Үүний дараа, дараагийн нэмж оруулах нэмэлт өөрчлөлтөд санал хураах гэх мэтээр бүх нэмэлт өөрчлөлтөд санал хурааж дуусах хүртэл үргэлжлүүлнэ.
- 13.9 Нэг болон түүнээс дээш нэмэлт өөрчлөлтийг батлах тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулж буй саналд бүхэлд нь санал хураалт явуулна.
- 13.10 Уг саналын аль нэг хэсэгт нэмж, хасч, эсвэл дахин боловсруулахаар гаргаж буй хүсэлтийг саналд оруулж буй нэмэлт өөрчлөлт гэж үзнэ.
- 13.11 Нэмэлт өөрчлөлтөөс гадна хоёр болон түүнээс дээш санал нэг асуудлыг хөндсөн бол уг саналуудыг хүсэлт гаргасан дарааллаар нь санал хурааж шийдвэрлэнэ. Нэг саналд санал хураалт явуулж дууссаны дараа Бага хурал дараагийн саналд санал хураах эсэх талаар шийдвэр гаргана.

IV. Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих Засгийн газар хоорондын хорооны гишүүдийг сонгох ба бүрэн эрхийн хугацаа

Дүрэм 15 – Газар зүйн хуваарилалт

- 14.1 Хорооны гишүүдийг сонгох сонгуулийг ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын сүүлийн чуулганаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу ЮНЕСКО-ийн сонгуулийн тойргийн бүлгийн бүрэлдэхүүнийг үндэслэж явуулна. “V бүлэг” хэмээх уг бүлэг нь Африкийн улсууд, Арабын улсууд хэмээх тусдаа хоёр бүлгээс бүрдэнэ.
- 14.2 Хорооны гишүүнчлэл нь 24 гишүүн улсаас бүрдэх бөгөөд сонгуулийн тойргийн бүлгийн дундах сонгууль бүрд бүлэг бүрийн оролцогч талуудын тоонд тэнцүү хувьтай байхаар хуваарилна. Ийм хуваарилалтын дараа сонгуулийн зургаан бүлэг тус бүрт доод тал нь гурав, дээд тал нь зургаан суудал ногдоно. Дээр дурдсан томъёолол практикт хэрэглэх боломжгүй болох тохиолдолд уг онцгой нөхцөл байдалд тохируулан тусгай зохицуулалт хийнэ.

Дүрэм 16 – Хорооны гишүүдийн бүрэн эрхийн хугацаа

Хорооны гишүүн улсуудыг дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар сонгоно. Гэхдээ эхний сонгуулиар сонгогдсон хорооны гишүүн улсуудын тэн хагасынх нь бүрэн эрхийн хугацаа хоёр жил байна. Эдгээр улсуудыг эхний сонгууль дээр сугалаа сугалж сонгоно. Ээлжлэх зарчмын дагуу Бага хурал хорооны гишүүдийн тэн хагасыг хоёр жил тутамд сонгоно. Дараах нөхцөлөөс бусад тохиолдолд гишүүдийг дахин хоёр жилийн эрхтэйгээр улираан сонгох боломжгүй. Үүнд:

- (i) Бүс нутгийн бүлэг “шинэ эхлэл”-ийг төлөөлнө;
- (ii) Эхний сонгуулийн дараа аль нэг улс хоёрхон жил алба хаасан;

- (iii) Сонгуульд оролцох бүлэг дэх улсыг төлөөлөх талуудын тоо дүрмийн 15.2-т заасан суудлын тооны доод хязгаараас бага.

Дүрэм 17 - Хороонд нэр дэвшүүлэх үйл ажиллагаа

- 16.1 Нарийн бичгийн дарга нарын газраас Бага хурлын чуулганы нээлт болохоос доод тал нь гурван сарын өмнө бүх оролцогч улсуудаас хорооны сонгуульд өрсөлдөх эсэхийг нь асууна. Хэрвээ сонгуульд оролцох хүсэлтэй бол гишүүн улс нэр дэвшүүлэлтийг Бага хурлын чуулган эхлэхээс доод тал нь зургаан долоо хоногийн өмнө Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлнэ.
- 16.2 Бага хурлын нээлтийн ажиллагаа болохоос доод тал нь дөрвөн долоо хоногийн өмнө Нарийн бичгийн дарга нарын газраас бүх оролцогч улсуудад нэр дэвшигчдийн урьдчилсан жагсаалтыг сонгуулийн бүлэг бүрт оногдох суудлын тоо, хамаарах сонгуулийн бүлгийг үзүүлсэн байдлаар илгээнэ.
- 16.3 Нэр дэвших жагсаалтыг талуудын Бага хурлын нээлтийн үйл ажиллагаанаас 48 цагийн өмнө эцэслэн шийднэ. Бага хурлын нээлтийн үйл ажиллагаанаас өмнөх 48 цагийн дотор ямар ч нэр дэвших санал хүлээн авахгүй.

Дүрэм 18 – Хорооны гишүүдийг сонгох

- 17.1 Хорооны гишүүдийн сонгуулийг нууц санал хураалтаар явуулна. Харин газар зүйн байршлаас хамааран нэр дэвшигчдийн тоо сонгогдох суудлын тоотой тэнцүү, эсвэл бага байгаа тохиолдолд нэр дэвшигчдийг санал хураалт явуулахгүйгээр сонгогдсон хэмээн зарлаж болно.
- 17.2 Сонгууль эхлэхээс өмнө дарга хуралд оролцож буй төлөөлөгчдийн дундаас итгэмжлэгдсэн хоёр төлөөлөгч сонгон, тэдэнд нэр дэвшигчдийн жагсаалтыг гардуулна. Мөн тэрээр сонгогдох суудлын тоог зарлана.
- 17.3 Нарийн бичгийн дарга нарын газар сонгуульд оролцох бүлэг бүрийн төлөөлөгч тус бүрт ямар нэгэн онцгой тэмдэг тэмдэглэгээгүй дугтуй, санал өгөх салангид цааснууд бэлдэж өгнө. Сонгуульд оролцох бүлэг бүрийн санал өгөх цаасан дээр сонгуульд оролцох бүлгийн нэр дэвшигчид болох улсыг төлөөлөх талуудын нэрийг бичсэн байна.
- 17.4 Талуудын төлөөлөгч нар сонгохыг хүссэн улсынхаа нэрсийг дугуйлан саналаа өгнө.
- 17.5 Итгэмжлэгдсэн төлөөлөгч нар даргын хяналтан дор төлөөлөгч бүрээс саналын хуудсыг цуглуулан, санал тоолох үйл ажиллагаа явуулна.
- 17.6 Дугтуйнд саналын хуудас байхгүй бол түдгэлзсэнд тооцно.
- 17.7 Сонгогдох суудлын тооноос илүү олон нэр дугуйлсан болон санал өгөгч нэг ч нэр дугуйлан саналаа өгөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- 17.8 Сонгуулийн бүлэг бүрт өгсөн саналыг тус тусад нь тоолно. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нар дугтуйг нэг нэгээр нь онгойлгож, саналын хуудсыг сонгуульд оролцож буй бүлэг тус бүрээр нь ангилан ялгана. Нэр дэвшигч улсыг төлөөлөх талуудын өгсөн саналыг үүнд зориулан бэлдсэн жагсаалтад оруулна.
- 17.9 Дарга сонгогдох суудлын тоонд дөхөж очих хамгийн их санал авсан нэр дэвшигчийг сонгогдсон хэмээн зарлана. Хоёр болон түүнээс дээш нэр

дэвшигч тэнцүү тооны санал авч улмаар сонгогдох суудлын тооноос олон нэр дэвшигч үлдсэн тохиолдолд тэнцүү тооны санал авсан нэр дэвшигчдийн дунд дахин нууц санал хураалт явуулна. Хоёр дахь санал хураалтаар хоёр болон түүнээс дээш нэр дэвшигчид тэнцүү тооны санал авсан тохиолдолд дарга аль нэг нэр дэвшигчийг тодруулахын тулд сугалаа сугалуулна.

17.10 Саналыг тоолж дууссаны дараа дарга санал хураалтын дүнг сонгуульд оролцсон бүлэг бүрээр нь тус тусад нь зарлана.

V. Чуулганы Нарийн бичгийн дарга нарын газар

Дүрэм 19 – Нарийн бичгийн дарга нарын газар

- 18.1 ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал эсвэл түүний төлөөний хүн Бага хурлын үйл ажиллагаанд сонгох эрхгүйгээр оролцоно. Тэрээр зөвлөгөөний аливаа асуудалд амаар болон бичгээр мэдэгдэл хийж болно.
- 18.2 ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал Бага хурлын Нарийн бичгийн дарга нарын газарт Бага хурлын Нарийн бичгийн даргаар ажиллах албан тушаалтан болон Бага хурлын Нарийн бичгийн дарга нарын газрын бүрэлдэхүүнд орох бусад албан тушаалтнуудыг томилно.
- 18.3 Нарийн бичгийн дарга нарын газар Бага хурлын чуулган эхлэхээс доод тал нь гуч хоногийн өмнө ажлын зургаан хэл дээр бүхий л албан бичиг баримтыг хүлээн авч, албан ёсны зургаан хэл рүү орчуулж, түгээнэ. Энэ газар зөвлөгөөний аман орчуулгын бэлтгэлийг хангах бөгөөд Бага хурлыг зохион байгуулахад шаардагдах бусад бүхий л зохион байгуулалтын ажлыг хариуцах үүрэгтэй.

VI. Үйл ажиллагааны дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах

Дүрэм 20 – Батлах

Бага хурал нь санал өгч байгаа талуудын төлөөлөгчдийн дийлэнхийн үндсэн хуралдаанаар гаргасан шийдвэрийн дагуу Үйл ажиллагааны дүрмээ батална.

Дүрэм 21 – Нэмэлт өөрчлөлт оруулах

Бага хурал санал өгч байгаа талуудын төлөөлөгчдийн гуравны хоёр хувь болох дийлэнх үндсэн хуралдаанаар гаргасан шийдвэрээр энэхүү Үйл ажиллагааны дүрмэндээ нэмэлт өөрчлөлт оруулна.

Дүрэм 22 – Түдгэлзэх

Конвенцын заалтыг шинэчилж байгаагаас бусад тохиолдолд Үйл ажиллагааны дүрмийг санал өгч байгаа талуудын гуравны хоёр хувь болох дийлэнх олонхийн гаргасан Бага хурлын шийдвэрээр түдгэлзүүлж болно.

4

СОЁЛЫН ИЛЭРХИЙЛЛИЙН ОЛОН
ТӨРЛИЙГ ХАМГААЛАХ БОЛОН
ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН ХОРООНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих Засгийн газар хоорондын хорооны Үйл ажиллагааны дүрэм

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих Засгийн газар хоорондын хороо анхны чуулганаараа баталж (2007 оны 12-р сарын 10-13, Оттава), 2005 оны конвенцод нэгдсэн талуудын Бага хурлын хоёрдугаар чуулганаар хүлээн зөвшөөрсөн (2009 оны 6-р сарын 15-16, Парис).

I. Бүрэлдэхүүн

Дүрэм 1 – Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих Засгийн газар хоорондын хороо (конвенцын 23 дугаар зүйл)

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих Засгийн газар хоорондын хороо (цаашид “хороо” гэх) нь Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенцын (цаашид “конвенц” гэх) 23 дугаар зүйлд заасны дагуу сонгогдсон конвенцын оролцогч талуудаас (цаашид “гишүүд” гэх) бүрдэнэ.

II. Чуулган

Дүрэм 2 – Ээлжит ба ээлжит бус чуулган

- 1.1 Хорооны ээлжит чуулганыг жил бүр хуралдуулна.
- 1.2 Хамгийн багадаа гишүүдийн гуравны хоёр хувь хүсэлт гаргасан тохиолдолд хороо ээлжит бус чуулган хуралдуулна.

Дүрэм 3 – Зарлан хуралдуулах

- 2.1 Хорооны чуулганыг хорооны дарга (цаашид “дарга” гэх) ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралтай (цаашид “Ерөнхий захирал” гэх) зөвшилцсөнөөр зарлан хуралдуулна.
- 2.2 Ээлжит чуулган хуралдуулах тохиолдолд Ерөнхий захирал чуулган бүрийн тов, болох газар, урьдчилсан хөтөлбөрийг хорооны гишүүдэд чуулган болохоос 60-аас доошгүй өдрийн өмнө урьдчилан мэдэгдэх бөгөөд ээлжит бус чуулган хуралдуулах тохиолдолд 30-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэнэ.
- 2.3 Ерөнхий захирал Дүрмийн 6 ба 7-д дурдсан байгууллага, хувь хүн, ажиглагч нарт чуулган бүрийн тов, болох газар, урьдчилсан хөтөлбөрийг мөн нэгэн зэрэг мэдэгдэнэ.

Дүрэм 4 – Чуулганы огноо ба болох газар

- 3.1 Хороо Ерөнхий захиралтай зөвлөлдөн чуулган бүр дээр дараагийн чуулганы товыг зарлана. Шаардлагатай тохиолдолд Товчоо Ерөнхий захиралтай зөвлөлдөн товыг өөрчилж болно.

- 3.2 Хорооны чуулган гол төлөв Парис дахь ЮНЕСКО-ийн төв байранд хуралдана. Аль нэг гишүүн улсын газар нутаг дээр чуулганыг зохион байгуулахаар гишүүдийн гуравны хоёрын санал гарсан онцгой тохиолдолд хороо Ерөнхий захиралтай зөвшилцөн шийдвэрлэж болно.

III. Оролцогчид

Дүрэм 5 – Төлөөлөгчид

- 4.1 Хорооны гишүүн бүр зөвлөх, шинжээч, орлогч нараар туслалцуулж болох төлөөлөгчөө томилно.
- 4.2 Хорооны гишүүд энэхүү конвенцын хамрах салбарт туршлагатай хүмүүсийг төлөөлөгчөөр нэр дэвшүүлнэ.
- 4.3 Хорооны гишүүд төлөөлөгчдийнхөө нэр, чиг үүрэг, ажлын туршлагын талаар Нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр мэдээлнэ.

Дүрэм 6 – Зөвлөлдөхөөр урих

Хороо төрийн эсвэл хувийн байгууллага, хувь хүмүүсийг ямар нэгэн онцгой асуудлаар зөвлөлдөх зорилгоор хуралд оролцохыг хэдийд ч урьж болно (конвенцын 23.7-р зүйл).

Дүрэм 7 – Ажиглагчид

- 6.1 Хорооны гишүүн бус, конвенцод нэгдсэн талууд хороо болон түүний харъяа байгууллагын чуулганд ажиглагчаар оролцож болох бөгөөд 18 дугаар зүйлийн заалттай холбогдуулан дор 20 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ эдэлнэ.
- 6.2 Конвенцод нэгдээгүй ЮНЕСКО-ийн гишүүн улсуудын төлөөлөгчид, туслах гишүүд, ЮНЕСКО-ийн Байнгын төлөөлөгч ажиглагч гишүүд дүрмийн 20.3 дугаар заалтын дагуу санал өгөх эрхгүйгээр, урьдчилж бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр хорооны хуралдаанд ажиглагчаар оролцож болно.
- 6.3 Нэгдсэн Үндэсний Байгууллага, Нэгдсэн Үндэсний системийн байгууллага болон ЮНЕСКО-той харилцан төлөөлөх хэлэлцээр байгуулсан засгийн газар хоорондын бусад байгууллагын төлөөлөгчид дүрмийн 20.3 дугаар заалтын дагуу санал өгөх эрхгүйгээр, урьдчилж бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр хорооны үйл ажиллагаанд ажиглагчаар оролцож болно.
- 6.4 Дүрмийн 7.3 дугаарт дурдсанаас бусад Засгийн газар хоорондын байгууллагууд, конвенцын хамаарах салбарт үйл ажиллагаа явуулдаг, явуулах сонирхолтой төрийн бус байгууллагуудыг санал өгөх эрхгүйгээр, дүрмийн 20.3 дугаар заалтын дагуу нэг удаагийн болон хэд хэдэн чуулган, эсвэл чуулганы тусгай хуралдаанд Ерөнхий захиралд бичгээр хүсэлт гаргасны үндсэн дээр ажиглагчаар оролцуулахыг хорооноос зохион байгуулж болно.

IV. Хэлэлцэх асуудал

Дүрэм 8 – Хэлэлцэх асуудлын урьдчилсан хөтөлбөр

- 7.1 Хорооны чуулганы хэлэлцэх асуудлын урьдчилсан хөтөлбөрийг ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газар бэлтгэнэ (конвенцын 24.2 дугаар зүйл).
- 7.2 Хорооны ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын урьдчилсан хөтөлбөрт дараах

зүйлс багтаж болно.Үүнд:

- (a) Конвенц эсвэл одоо үйлчилж буй дүрэмтэй холбоотой аливаа асуудал;
- (b) Конвенцод нэгдсэн талуудын Бага хурлын авч хэлэлцсэн аливаа асуудал;
- (c) Хорооны өмнөх чуулганаар шийдвэрлэсэн шийдвэртэй холбоотой аливаа асуудал;
- (d) Хорооны гишүүдийн өргөн барьсан аливаа асуудал;
- (e) Хорооны гишүүн бус, конвенцод нэгдсэн талуудын өргөн барьсан аливаа асуудал;
- (f) Ерөнхий захирлын өргөн барьсан аливаа асуудал.

7.3 Ээлжит бус чуулганы хэлэлцэх асуудлын урьдчилсан хөтөлбөрт уг чуулганыг зарлан хуралдуулахтай холбоотой асуудлууд л багтана.

Дүрэм 9 – Хэлэлцэх асуудлыг батлах

Хороо чуулган бүрийнхээ эхэнд уг чуулганаар хэлэлцэх асуудлаа батлана.

Дүрэм 10 – Нэмэлт өөрчлөлт оруулах, устгах, шинээр оруулах

Хороо хэлэлцэх асуудлын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж, устгаж, шинэ зүйл нэмэн, санал өгч байгаа гишүүдийн гуравны хоёр болох дийлэнх олонхиор дэмжигдвэл батална.

V. Товчоо

Дүрэм 11 – Товчоо

10.1 Хорооны Товчоо нь газарзүйн хувьд төлөөллийн тэнцвэрт байдлыг хангах зарчмын дагуу дарга, нэг болон түүнээс дээш дэд дарга, илтгэгчээс бүрдэнэ. Товчоо нь хорооны хурлыг зохицуулан удирдаж, хурлын огноо, цаг, дарааллыг тогтооно. Товчооны бусад гишүүд даргыг ажил үүргээ гүйцэлдүүлэхэд нь тусална.

10.2 Товчоо хорооны чуулганы үеэр шаардлагатай гэж үзвэл тогтмол хуралдана.

Дүрэм 12 – Сонгууль

11.1 Ээлжит чуулган бүрийн төгсгөлд хороо дараагийн ээлжит чуулган дуусах хүртэл бүрэн эрхийн хугацаа нь хүчинтэй хэвээр байгаа хорооны гишүүд дотроос дараагийн чуулганыг дуусах хүртэл энэ албанд үлдэн ажиллах боломжтой хүнийг дарга, дэд дарга, илтгэгчээр сонгох бөгөөд улиран сонгогдох эрхгүй. Түр хугацаанд эхний чуулганы товчооны гишүүдийг чуулганы эхэнд сонгох бөгөөд дараагийн чуулган дуусахад тэдний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болно. Даргын сонгууль дүрмийн 12.2 дугаар заалтад харшлахгүйгээр газар зүйн хувьд ээлж дараатай байх зарчмын дагуу явагдана.

11.2 Онцгой тохиолдолд чуулганыг ЮНЕСКО-ийн төв байгууллагын гадна зохион байгуулах тохиолдолд товчоог сонгож болно.

11.3 Товчоог сонгохдоо хороо газар зүйн хувьд төлөөллийн тэнцвэрт байдлыг хангах хэрэгцээ шаардлагад нийцүүлэн конвенцод хамаарах салбаруудын тэнцвэрт байдлыг аль болох хадгалахыг эрмэлзэнэ.

Дүрэм 13 – Даргын үүрэг

- 12.1 Дарга дүрмээр олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ хорооны үндсэн хуралдаан бүрийг нээж, хаана. Тэрээр хэлэлцүүлгийг удирдан чиглүүлж, эдгээр дүрмийг мөрдүүлж, үг хэлэх дарааллыг тогтоож, санал хураах асуултыг тавьж, гаргасан шийдвэрийг зарлана. Тэрээр дүрэмд нийцүүлэн хурлын дэгийг баримтлуулж хэрэгжүүлэхэд хяналт тавина. Тэрээр санал өгөхгүй боловч төлөөний хүнээ өмнөөсөө санал өгүүлж болно. Мөн тэрээр хорооноос хүлээлгэсэн бусад бүхий л үүргээ биелүүлнэ.
- 12.2 Даргын үүрэг гүйцэтгэж буй дэд дарга нь даргын нэгэн адил эрх, үүрэг хүлээнэ.
- 12.3 Хорооны харъяа хэсгийн дарга, дэд дарга нь бүрэлдэхүүн хэсгүүдээ удирддаг болохоор хорооны дарга, дэд даргатай нэгэн адил эрх, үүрэг хүлээнэ.

Дүрэм 14 – Даргыг орлох

- 13.1 Дарга хороо болон товчооны аль ч чуулганд болон аль нэг хэсэгт нь оролцох боломжгүй тохиолдолд түүний үүргийг дэд дарга гүйцэтгэнэ.
- 13.2 Дарга хорооны гишүүний төлөөлөл байхаа больсон, эсвэл өөр ямар нэг шалтгаанаар бүрэн эрхийн хугацаагаа гүйцээх боломжгүй болсон тохиолдолд хороон дотроо зөвлөлдсөний эцэст бүрэн эрхийн үлдсэн хугацаанд нь дэд дарга түүнийг орлоно.
- 13.3 Дарга өөрийн харъяат улсад хамааралтай аливаа асуудлаар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхгүй.

Дүрэм 15 – Илтгэгчийг орлох

- 14.1 Илтгэгч хороо, эсвэл товчооны аль нэг чуулганд эсвэл чуулганы аль нэг хэсэгт оролцох боломжгүй тохиолдолд дэд дарга түүнийг орлон үүрэг гүйцэтгэнэ.
- 14.2 Илтгэгч хорооны гишүүний төлөөлөл байхаа больсон, эсвэл өөр ямар нэг шалтгаанаар бүрэн эрхийн хугацаагаа гүйцээх боломжгүй болсон тохиолдолд хороон дотроо зөвлөлдсөний эцэст бүрэн эрхийн үлдсэн хугацаанд нь дэд дарга түүнийг орлоно.

VI. Ажил хэргээ явуулах

Дүрэм 16 – Хурлын ирц

- 15.1 Үндсэн хуралдааны ирц хорооны гишүүдийн дийлэнх олонхиос бүрдэнэ.
- 15.2 Бүрэлдэхүүн хэсгүүдийн хуралдааны ирц эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн гишүүн улсуудын дийлэнх олонхиос бүрдэнэ.
- 15.3 Ирц бүрдээгүй тохиолдолд хороо, бүрэлдэхүүн хэсэг хоёрын аль нь ч ямар нэг асуудал хэлэлцэн шийдэх эрхгүй.

Дүрэм 17 – Нээлттэй хуралдаан явуулах

Хорооноос өөрөөр шийдээгүй бол хурлыг бүх нийтэд нээлттэй явуулна.

Дүрэм 18 – Хаалттай хуралдаан

- 17.1 Хороо хаалттай хуралдахаар шийдвэрлэсэн онцгой тохиолдолд хуралд оролцох хүмүүсийг хорооны гишүүдийн төлөөлөгч нар дээр нэмж сонгоно.
- 17.2 Хорооны хаалттай хуралдаанаар гаргасан аливаа шийдвэрийг дараагийн нээлттэй хуралдаанд бичгээр танилцуулна.

17.3 Хаалттай хуралдсан хурал бүрд уг хурлын товч тайлан, баримт бичгүүдийг хэвлэн нийтлүүлэх эсэх талаар хороо шийдвэр гаргана. Хаалттай хуралдаанаас гарсан баримт бичгийг 20 жилийн дараа олон нийтэд дэлгэнэ.

Дүрэм 19 – Туслах байгууллагууд

18.1 Хороо ажил үүргээ явуулахад зайлшгүй шаардлагатай гэж үзвэл туслах байгууллагуудыг байгуулж болно.

18.2 Хороо уг туслах байгууллагуудыг байгуулах үедээ тэдгээрийн бүрэлдэхүүн, ажиллах хугацааг (мандатын болон бүрэн эрхийн хугацаа) тогтооно. Эдгээр туслах байгууллагууд нь хорооны гишүүдээс бүрдэнэ.

18.3 Туслах байгууллага бүр өөрийн дарга, шаардлагатай гэж үзвэл дэд дарга, илтгэгчийг сонгоно.

18.4 Туслах байгууллагуудын гишүүдийг томилохдоо дэлхийн өөр өөр бүс нутгийн төлөөллийн тэнцвэрт байдлыг хангах хэрэгцээ шаардлагыг баримтална.

Дүрэм 20 – Үг хэлэх дараалал, хязгаарт хугацаа

19.1 Дарга хорооны гишүүд буюу илтгэгч нарын үг хэлэх хүсэлт гаргасан дарааллаар нь тэдэнд үг хэлэх эрх олгоно. Ажиглагчид хэлэлцүүлгийн төгсгөлд эхлээд конвенцод нэгдсэн талуудын төлөөлөгч, дараа нь конвенцод нэгдээгүй гишүүн улсуудын төлөөлөгч, эцэст нь бусад ажиглагч нар гэсэн дарааллаар үг хэлнэ. Бүс нутгийн эдийн засгийн интеграцийн байгууллага буюу конвенцод нэгдсэн талын гишүүн болох хорооны аль нэг гишүүний хүсэлтээр дарга уг байгууллагын төлөөлөгчид үг хэлэх эрх олгон конвенцын 27(3) (с)-т заасанчлан тухайн байгууллага шийдвэрлэхээр чармайж байгаа асуудлынхаа талаар ярихыг зөвшөөрнө.

19.2 Хэрвээ тухайн нөхцөл байдалд шаардлагатай гэж үзвэл илтгэгч бүрт олгосон цагийг дарга хязгаарлаж болно.

19.3 6 ба 7 дугаар дүрэмд дурдсан байгууллага, хувь хүн, ажиглагч нар даргаас урьдчилж зөвшөөрөл авсны үндсэн дээр хуралд үг хэлж болно.

Дүрэм 21 – Саналын эх бичвэр

Хорооны аль нэг гишүүний гаргасан хүсэлтийг өөр хоёр гишүүн дэмжсэнээр үг бичвэрийг албан ёсны хоёр хэлээр үйлдэн хорооны бүх гишүүдэд тараах хүртэл аливаа саналын хэлэлцүүлэг, тогтоол, нэмэлт өөрчлөлтийг түдгэлзүүлнэ.

Дүрэм 22 – Саналыг бүрдүүлэх хэсгүүд

Аливаа саналын хэсэг бүр дээр тус тусад нь санал хураалт явуулахаар хорооны гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд түүнийг дагана. Тус тусын саналаар батлагдсан уг саналын хэсгүүдийг нэгтгэн бүхэлд нь санал хураалт явуулна. Саналыг бүрдүүлж байгаа бүхий л хэсгүүд үл зөвшөөрөгдсөн тохиолдолд уг саналыг бүхэлд нь татгалзсанд тооцно.

Дүрэм 23 – Нэмэлт өөрчлөлтөд санал хураах

22.1 Саналд ямар нэгэн нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд уг нэмэлт өөрчлөлтөд эхэлж санал хураана. Саналд хоёр болон түүнээс дээш нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд хороо эхлээд эх саналд нэмж оруулахаар даргын өргөн барьсан нэмэлт өөрчлөлтөд эхэлж санал хураана. Үүний дараа дараагийн нэмж оруулах нэмэлт өөрчлөлтөд санал хураах гэх мэтээр бүх нэмэлт өөрчлөлтөд санал хурааж дуусах хүртэл үргэлжлүүлнэ.

22.2 Нэг болон түүнээс дээш нэмэлт өөрчлөлтийг батлах тохиолдолд уг нэмэлт өөрчлөлт оруулж буй саналд бүхэлд нь санал хураана.

22.3 Уг саналын аль нэг хэсэгт нэмж, хасч, эсвэл дахин боловсруулахаар гаргаж буй хүсэлтийг саналд оруулж буй нэмэлт өөрчлөлт гэж үзнэ.

Дүрэм 24 – Саналд санал хураалт явуулах

Хоёр болон түүнээс дээш санал нэг асуудлыг хөндсөн тохиолдолд хороо өөрөөр шийдээгүй бол уг саналуудад батлагдсан дарааллаар нь санал хурааж шийдвэрлэнэ. Нэг саналд санал хураалт явуулж дууссаны дараа хороо дараагийн саналд санал хураах эсэх талаар шийдвэр гаргана.

Дүрэм 25 – Саналыг буцаах

Санал хураалт эхлэхээс өмнө буюу саналд нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө санал гаргагч саналаа хэдийд ч буцаан татаж болно. Буцаан татсан саналыг хорооны өөр нэг гишүүн дахин танилцуулж болно.

Дүрэм 26 – Хурлын дэг

25.1 Хэлэлцүүлгийн үеэр хорооны аль ч гишүүн хурлын дэгийг сануулан хэлж болох бөгөөд дарга тэр даруйд шүүн хянана.

25.2 Даргын удирдан зохицуулалтын эсрэг санал гомдол гаргаж болно. Ийм тохиолдолд уг санал гомдлоор нэн даруй санал хураалт явуулах бөгөөд санал хураалтад оролцсон талуудын дийлэнх олонхоор дэмжигдээгүй тохиолдолд даргын шийдвэр хүчинтэй хэвээр үлдэнэ.

Дүрэм 27 – Горимын санал

Хэлэлцүүлгийн үеэр хорооны гишүүн хурлыг түр зогсоох, түр завсарлуулах, хэлэлцүүлгийг түр завсарлуулах, эсвэл хаах талаар горимын санал гаргаж болно.

Дүрэм 28 – Хурлыг түр зогсоох эсвэл түр завсарлуулах

Аливаа асуудлын хэлэлцүүлгийн үеэр хорооны гишүүн хурлыг түр зогсоох эсвэл түр завсарлуулах санал оруулж болно. Ийм хүсэлтийг хэлэлцэхгүйгээр тэр даруйд нь шүүд санал хураан шийдвэрлэнэ.

Дүрэм 29 – Хэлэлцүүлгийг түр завсарлуулах

Аливаа асуудлын хэлэлцүүлгийн үеэр хорооны гишүүн хэлэлцүүлж буй асуудлыг түр завсарлуулах санал оруулж болно. Түр завсарлуулах саналыг оруулахдаа тухайн гишүүн түр завсарлагыг хугацаагүй үргэлжлүүлэх үү, эсвэл хэлэлцүүлгийг дахин явуулах тодорхой цаг зарлах үү гэдгийг шийднэ. Хүсэлт гаргаж байгаа хүний тухайд нэмж хэлэхэд уг хүсэлтийг бусад нь таашааж ч болно, эсэргүүцэж ч болно.

Дүрэм 30 – Хэлэлцүүлгийг хаах

Хорооны гишүүн бусад илтгэгч нарын хүсэлтийг нь авч хэлэлцэх эсэхээс үл хамааран хэлэлцүүлгийг хаах санал хэдийд ч оруулж болно. Харин хаахын эсрэг үг хэлэх зөвшөөрөл хүссэн тохиолдолд хоёроос илүүгүй илтгэгч үг хэлж болно. Улмаар дарга хаах хүсэлтэд санал хураалт явуулж, хороо уг хүсэлтийг таашаавал дарга уг хэлэлцүүлэг хаагдсаныг зарлана.

Дүрэм 31 – Хүсэлт гаргах дараалал

Дүрмийн 26-д заасан ёсоор ийм хүсэлтийг дараах дарааллын дагуу хурлаас өмнө бусад санал, хүсэлтийн эхэнд тавина. Үүнд:

- (а) Хурлыг түр зогсоох;

- (b) Хурлыг түр завсарлуулах;
- (c) Хэлэлцэж буй асуудлаарх хэлэлцүүлгийг түр завсарлуулах;
- (d) Хэлэлцэж буй асуудлаарх хэлэлцүүлгийг хаах

Дүрэм 32 – Шийдвэр

31.1 Хорооноос батлах нь зохистой гэж үзсэн шийдвэр, зөвлөмжийг батална.

31.2 Шийдвэр бүрийн эх бичвэрийг хөтөлбөрт тусгасан хэлэлцүүлгийн эцэст батална.

VII. Санал өгөх

Дүрэм 33 – Санал өгөх эрх

Хорооны гишүүн бүр нэг саналын эрхтэй байна.

Дүрэм 34 – Санал өгөх явцын зохицуулалт

Дарга санал хураалт эхэлснийг зарласны дараа санал хураалтын зохион байгуулалттай холбоотойгоор хорооны аль нэг гишүүн дэг алдагдаж байгаа талаар сануулга хэлэхээс бусад тохиолдолд хэн ч санал хураалтыг тасалдуулж үл болно.

Дүрэм 35 – Дийлэнх олонх

Эдгээр дүрэмд өөрөөр заагдсан байхаас үл харгалзан хорооны бүхий л шийдвэрийг санал өгч буй гишүүдийн дийлэнх олонхын саналаар авна.

Дүрэм 36 – Санал тоолох

Эдгээр дүрмийн хүрээнд “Санал өгч буй гишүүд” гэдэг нь дэмжсэн болон татгалзсан санал өгч буй гишүүд гэж ойлгоно. Санал хураалтаас түдгэлзсэн гишүүдийг санал өгөөгүй гишүүд гэж үзнэ.

Дүрэм 37 – Санал хураах арга

36.1 Хорооны аль нэг гишүүн нууц санал хураалт явуулах хүсэлт гарган өөр хоёр гишүүн дэмжээгүй л бол гар өргөж санал хураана.

36.2 Гар өргөж санал хураасан сонгуулийн үр дүнг эргэлзээтэй гэж үзвэл дарга хоёр дахь санал хураалтыг нэр дуудаж явуулна.

36.3 Санал хураалт эхлэхээс өмнө хорооны хоёроос доошгүй гишүүн хүсэлт гаргавал санал хураалтыг эхнээс нь нэр дуудаж явуулна.

Дүрэм 38 – Нууц санал хураалтаар санал хураалт явуулах

37.1 Санал хураалт эхлэхийн өмнө дарга санал хураалтын явцад хяналт тавих итгэмжлэгдсэн хоёр төлөөлөгчийг томилно.

37.2 Саналыг тоолж дуусмагц итгэмжлэгдсэн төлөөлөгчид даргад тайлагнаснаар нууц санал хураалтын дүнг зарлана. Ингэхдээ өгсөн санал дараах байдлаар тэмдэглэгдэхийг анхаарна. Үүнд:

Хорооны гишүүдийн нийт тооноос хасах зарчмаар:

- (a) Байхгүй байсан гишүүдийн тоо, байсан бол;
- (b) Хоосон санал хураах хуудасны тоо, байсан бол;
- (c) Хүчингүй санал хураах хуудасны тоо, байсан бол.

Үлдсэн тоо нь тоологдох саналын тоог бүрдүүлнэ.

VIII. Хорооны Нарийн бичгийн дарга нарын газар

Дүрэм 39 – Нарийн бичгийн дарга нарын газар

- 38.1 Хороог ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газар дэмжин ажиллана (конвенцын 24 дүгээр зүйл).
- 38.2 Ерөнхий захирал, эсвэл түүний төлөөлөгч хороо, түүний туслах байгууллагын ажилд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Тэрээр хэлэлцэгдэж буй аливаа асуудлаар аль ч үед аман болон бичгээр мэдэгдэл хийж болно.
- 38.3 Ерөнхий захирал ЮНЕСКО-ийн Нарийн бичгийн дарга нарын газраас хорооны нарийн бичгийн даргаар ажиллах хүнийг, мөн хорооны нарийн бичгийн дарга нарын газрыг бүрдүүлэх бусад албан тушаалтныг томилно.
- 38.4 Нарийн бичгийн дарга нарын газар хорооны бүх албан бичгийг хүлээн авч, орчуулан, тарааж, хэлэлцүүлгийн орчуулгын бэлтгэл ажлыг хангана.
- 38.5 Нарийн бичгийн дарга нарын газар хорооны ажлыг зохистой явуулахад шаардагдах бусад бүхий л үүргийг гүйцэтгэнэ.

IX. Ажлын хэл ба тайлан илтгэл

Дүрэм 40 – Ажлын хэл

- 39.1 Хорооны ажил хэрэг явуулах хэл нь англи, франц хэл байна. Нэгдсэн Үндэсний Байгууллагын бусад албан ёсны хэлийг ашиглах чиглэлээр нэмэлт санхүүжилт гаргуулах замаар бүхий л хүчин чармайлт гаргана.
- 39.2 Хорооны хурлын мэдэгдэл ажлын хэлний аль нэгээр гарч байгаа бол бусад хэл рүү нь орчуулна.
- 39.3 Илтгэгчид бусад хэлээр хэдий ярьж болох авч ажлын хэлний аль нэг рүү тухайн мэдэгдлийг орчуулах зохицуулалтыг өөрөө хариуцаж хийнэ.
- 39.4 Хорооны баримт бичгүүдийг англи, франц хэлээр нэгэн зэрэг үйлдэнэ.

Дүрэм 41 - Баримт бичгүүдийг тараах эцсийн хугацаа

Хорооны чуулган бүрийн урьдчилсан хөтөлбөрт тусгагдсан асуудалтай холбоотой баримт бичгүүдийг ажлын хоёр хэл дээр, цахим хэлбэрээр бэлтгэн чуулганы нээлт болохоос доод тал нь дөрвөн долоо хоногийн өмнө хорооны гишүүдэд цаасаар тараана. Дүрмийн 6, 7-д заасан байгууллага, хувь хүн, ажиглагч нарт цахим хэлбэрээр тараана.

Дүрэм 42 – Чуулганы тайлан илтгэл

Чуулган бүрийн төгсгөлд хороо чуулган дуусгавар болсон сарын дараа сард ажлын хоёр хэл дээр зэрэг хэвлэгдэн гарах шийдвэрүүдийн жагсаалтыг батална.

Дүрэм 43 – Товч бүртгэл

Нарийн бичгийн дарган газар хорооны хурлын нарийвчилсан товч бүртгэлийг ажлын хоёр хэл дээр бэлтгэн дараагийн чуулганы нээлтэн дээр батлуулна. Энэхүү товч бүртгэлийг чуулган дуусгавар болсноос хойш доод тал нь 3 сарын дараа ажлын хоёр хэлээр цахим хэлбэрээр хэвлэнэ.

Дүрэм 44 – Баримт бичгийн харилцаа

Нээлттэй хурлын хэлэлцүүлгийн эцсийн хураангуй баримт бичгийг, шийдвэрийн жагсаалтын хамт Ерөнхий захирлаас хорооны гишүүд болон дүрмийн 6, 7-д заасан байгууллага, хувь хүн, ажиглагч нарт илгээнэ.

Дүрэм 45 – Талуудн Бага хурлын тайлан илтгэл

44.1 Хороо нь өөрийн үйл ажиллагаа болон шийдвэрүүдийн тайланг бичиж талуудын Бага хуралд тайлагнана.

44.2 Хороо нь түүний өмнөөс эдгээр тайлан илтгэлүүдийг өгөхийг даргад хариуцуулж болно.

44.3 Уг тайлан илтгэлүүдийн хуулбарыг конвенцын бүх талуудад илгээнэ.

Х. Үйл ажиллагааны дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх

Дүрэм 46 – Батлах

Хороо энэхүү Үйл ажиллагааны дүрмийг үндсэн хуралдаанаараа санал өгсөн гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэж батална.

Дүрэм 47 – Нэмэлт өөрчлөлт

Конвенцын заалтаас хуулбарлан боловсруулсныг үл харгалзан хороо Үйл ажиллагааны дүрэмд үндсэн хуралдаан дээр санал өгч буй гишүүдийн гуравны хоёр хувь буюу дийлэнх олонхын шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулна. Дүрмийн 8, 9-д заасны дагуу уг өргөн барьсан нэмэлт өөрчлөлтийг чуулганы хөтөлбөрт оруулна.

Дүрэм 48 – Түдгэлзүүлэх

Конвенцын заалтаас хуулбарлан боловсруулсныг үл харгалзан хороо аливаа Үйл ажиллагааны дүрмийн саналыг үндсэн хуралдаан дээр санал өгч буй гишүүдийн гуравны хоёр хувь буюу дийлэнх олонхын шийдвэрээр түдгэлзүүлж болно.

5

СОЁЛЫН ОЛОН ТӨРЛИЙГ
ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН
САНГИЙН ТУСГАЙ ДАНСНЫ
САНХҮҮГИЙН ЖУРАМ

Соёлын олон төрлийг дэмжих олон улсын сангийн тусгай дансны санхүүгийн журам

1 дүгээр зүйл – Тусгай данс нээх

- 0.1 Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенцын (цаашид “конвенц” гэх) 18 дугаар зүйлийн дагуу Соёлын олон төрлийг дэмжих олон улсын санг байгуулна. Олон талт ивээн тэтгэгчтэй байх онцлогийг харгалзан сангийн үйл ажиллагааг тусгай дансаар зохицуулалт хийнэ.
- 0.2 ЮНЕСКО-ийн Санхүүгийн журмын 6 дугаар зүйлийн 6 дугар догол мөрөнд заасны дагуу Соёлын олон төрлийг дэмжих олон улсын санд зориулж Тусгай данс (цаашид “тусгай данс” гэх) бий болгоно.
- 0.3 Тусгай дансны үйл ажиллагааг дараах журмаар удирдан зохицуулна.

2 дугаар зүйл – Санхүүгийн жил

Санхүүгийн жилийг ЮНЕСКО-той ижил байхаар зохицуулна.

3 дугаар зүйл – Зорилго

Конвенцын 18 дугаар зүйлд заасны дагуу энэхүү тусгай дансны зорилго нь талуудын Бага хурлаас гаргасан удирдамжид үндэслэн Засгийн газар хоорондын хорооны шийдвэрээр явагдах үйл ажиллагааг санхүүжүүлэх, ядуурлыг бууруулах тогтвортой хөгжлийн төлөөх хамтын ажиллагааг дэмжин ажиллахад нь конвенцын 14 дүгээр зүйлд нийцсэн эрчимтэй соёлын салбарыг бий болгохыг дэмжих зорилгоор, ялангуяа хөгжиж буй орнуудын тусгай хэрэгцээтэй холбогдуулан талуудад дорвитой дэмжлэг үзүүлэхэд оршино.

4 дүгээр зүйл – Орлого

Конвенцын 18 дүгээр зүйлд заасны дагуу тусгай дансны орлого дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- (a) Конвенцын талуудаас өргөн барьсан сайн дурын хандив;
- (b) ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын зорилгод нийцсэн сангууд;
- (c) Дараах газруудаас өргөсөн хандив, бэлэг, өв хөрөнгө. Үүнд:
 - (i) Бусад улс;
 - (ii) Нэгдсэн Үндэсний системийн байгууллага, түүний хөтөлбөрүүд;
 - (iii) Бүс нутгийн болон олон улсын бусад байгууллагууд;
 - (iv) Төрийн болон хувийн хэвшлүүд, хувь хүн;

- (d) Тусгай дансны нөөцөд ногдох буй аливаа хүү;
- (e) Сайн дурын санд хандив босгохоор зохион байгуулж буй арга хэмжээнээс орж буй орлого, хуримтлалаас бүрдэж буй хөрөнгө.

5 дугаар зүйл – Зарцуулалт

Тусгай дансны зарцуулалтыг дээр 3 дугаар зүйлд тодорхойлсон зорилготой холбогдуулан хийнэ. Үүнд, холбогдох захиргааны зардал, тусгай данснаас гаргах хөтөлбөрийг дэмжих зардал багтана.

6 дугаар зүйл – Данснууд

- 5.1 Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ЮНЕСКО-ийн хянагч уг дансны мэдээллийг хадгална.
- 5.2 Нэг санхүүгийн жил дуусахад зарцуулагдаагүй үлдсэн үлдэгдлийг дараагийн санхүүгийн жил рүү шилжүүлнэ.
- 5.3 Тусгай дансанд харьяалагдах данснуудыг байгууллагын бусад данснуудын хамт ЮНЕСКО-ийн хөндлөнгийн аудиторуудаар шалгуулна.
- 5.4 Бэлэн бусаар өгсөн хандивыг тусгай данснаас гадна бүртгэнэ.

7 дугаар зүйл – Хөрөнгө оруулалт

- 6.1 Ерөнхий захирал тусгай дансны хүүтэй тэнцэх хэмжээгээр богино хугацааны хөрөнгө оруулалт хийж болно.
- 6.2 Энэхүү хөрөнгө оруулалтаас орох хүүг тусгай дансны хүү болгон оруулна.

8 дугаар зүйл – Тусгай дансыг хаах

Ерөнхий захирал тусгай дансны үйл ажиллагаа цаашид шаардлагагүй гэж үзвэл үүнийг хаах шийдвэр гарган Гүйцэтгэх зөвлөлд мэдэгдэнэ.

9 дүгээр зүйл – Ерөнхий заалт

Эдгээр дүрэмд өөрөөр заагаагүй бол тусгай дансыг ЮНЕСКО-ийн Санхүүгийн журамд нийцүүлэн захиран зарцуулна.

6

ХАВСРАЛТ

6.а Соёрхон батлах загвар бичиг

(хүлээн зөвшөөрөх, нэгдэн орох, батлах тохиолдлууд)

Соёрхон батлах хэрэгсэл

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенцыг
..... аар (улсын нэр) соёрхон батлах

26-р зүйлд заасан ёсоор (нэгдэн орох тохиолдолд, 27-р зүйл),

Мөн
.....-ын (улсын нэр) Засгийн газар

Дээр дурдсан конвенцыг хэлэлцэн, соёрхон баталснаар үүнд дурдсан нөхцөлүүдийг үнэн зөвөөр хэрэгжүүлэх болно.

ҮҮНИЙГ БАТЛАМЖЛАН, Миний бие гарын үсэг зурж, энэхүү тамгыг дарав.

Гүйцэтгэсэн (газар)

Өнөөдрийн (огноо)

.....

(Гарын үсэг)

Төрийн тэргүүн /Ерөнхий сайд/Гадаад хэргийн сайд

(Тамга)

5.б Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенцод нэгдсэн талуудын Бага хурлын чуулган

Чуулган	Огноо	Газар
Анхдугаар чуулган	2007 оны 6 дугаар сарын 18-20	Франц, Парис
Хоёрдугаар чуулган	2009 оны 6 дугаар сарын 15-16	Франц, Парис
Гуравдугаар чуулган	2011 оны 6 дугаар сарын 14-15	Франц, Парис
Дөрөвдүгээр чуулган	2013 оны 6 дугаар сарын 11-13	Франц, Парис
Тавдугаар чуулган	2015 оны 6 дугаар сарын 10-12	Франц, Парис
Зургаадугаар чуулган	2017 оны 6 дугаар сарын 12-15	Франц, Парис

5.с Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих Засгийн газар хоорондын хорооны чуулган

Чуулган	Огноо	Газар
Анхдугаар чуулган	2007 оны 12 дугаар сарын 10-13	Канад, Оттава
Анхдугаар албан бус чуулган	2008 оны 6 дугаар сарын 24-27	Франц, Парис
Хоёрдугаар чуулган	2008 оны 12 дугаар сарын 8-12	Франц, Парис
Хоёрдугаар албан бус чуулган	2009 оны 3 дугаар сарын 23-25	Франц, Парис
Гуравдугаар чуулган	2009 оны 12 дугаар сарын 7-9	Франц, Парис
Дөрөвдүгээр чуулган	2010 оны 11дүгээр сарын 29 – 12 дугаар сарын 3	Франц, Парис
Тавдугаар чуулган	2011 оны 12 дугаар сарын 5-7	Франц, Парис
Зургаадугаар чуулган	2012 оны 12 дугаар сарын 10-14	Франц, Парис
Долдугаар чуулган	2013 оны 12 дугаар сарын 10-13	Франц, Парис
Наймдугаар чуулган	2014 оны 12 дугаар сарын 9-11	Франц, Парис
Есдүгээр чуулган	2015 оны 12 дугаар сарын 14-16	Франц, Парис
Аравдугаар чуулган	2016 оны 12 дугаар сарын 12-15	Франц, Парис
Арваннэгдүгээр чуулган	2017 оны 12 дугаар сарын 12-15	Франц, Парис



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



Diversity of
Cultural Expressions

**Соёлын илэрхийллийн олон
төрлийн хэсэг, Соёлын хэлтэс**

ЮНЕСКО

7, place de Fontenoy – 75352 Paris 07 SP, France
Fax: +33 1 45 68 55 95
<http://en.unesco.org/creativity/>



Beijing Office
Office of the Representative to
Democratic People's Republic
of Korea, Japan, Mongolia,
People's Republic of China
and Republic of Korea

ЮНЕСКО-ийн Бээжин дэх
төлөөлөгчийн газар монгол
хэлнээ хөрвүүлэх төслийн
зохицуулагчаар ажиллав



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization
Mongolian
National Commission
for UNESCO

Энэхүү номыг ЮНЕСКО-ийн
санхүүжилтээр ЮНЕСКО-ийн
Монголын үндэсний комисс
монгол хэлнээ хөрвүүлэн хэвлүүлэв.



МОНГОЛ УНЕСКО
МОНГОЛ УНЕСКО-ЫН
ҮНДСЭНИЙ КОМИСС

Энэхүү номыг БШУСЯ-ны
дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.

Соёлын илэрхийллийн олон төрлийн хэсэг, Соёлын хэлтэс

ЮНЕСКО

7, place de Fontenoy – 75352 Paris 07 SP, France
Fax: +33 1 45 68 55 95
<http://en.unesco.org/creativity/>